

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(1)

УЛААНБААТАР ХОТ
2025 он



НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(1)

(Тайлангийн эмхэтгэл)

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ННА 78
DDC 020
Н 615

Нийтийн номын сангуудын тайлан 2024(1)

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

ISBN 978-9919-9114-7-8

ГАРЧИГ

ГАРЧИГ.....	04
ӨМНӨХ ҮГ	05
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	06
Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	92
Б.БААСТЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	133
ХАВСРАЛТ: НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН СТАТИСТИК ТАЙЛАН НЭГТГЭЛ.....	145
ДҮГНЭЛТ.....	160

ӨМНӨХ ҮГ

Технологийн хөгжилт, мэдээллийн хязгааргүй өсөлтийн энэ үед ард иргэдийг соён гэгээрүүлэгч, номын сан, мэдээллийн байгууллагын хэрэгцээ шаардлага улам ихээр бий болж байна. Дээрх өсөлтүүд нь номын сангуудыг соёл, боловсролын шинэлэг хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Энэ шаардлагад нийцэх, хүрч ажиллахын тулд аймаг, нийслэлийн номын сангууд бүхий л талаараа хичээнгүйлэн ажиллаж ирсний илрэл, ул мөрийг энэхүү тайлангаас үзэх болно. Өмнөх жилүүдэд тус тайлан 300-600 хуудас болдог байсан бол энэ жил 800 гаруй хуудастай болж байгаа нь үүнийг илтгэх нэгэн сэжиг болно. Өдий хэмжээний хуудастай номыг цахим файлд хөрвүүлэн уншихад ачаалал өгөх тул 200 хуудсаар нь салган 5 боть болгон нийтлүүлээ.

Өнгөрөгч 2024 он Монголын номын сангийн салбарт олон чухал, түүхэн үйл явдал болж өнгөрсний нэг нь Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар шинэ салбар ашиглалтад орж, номын санч- мэдээллийн ажилтнуудын сүүлийн 30 гаруй жилийн мөрөөдөл биелж, Монгол Улсын Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран номын сангийн нэгдсэн системийг хөгжүүлэн, ашиглалтад хүлээн авснаар, аймаг орон нутгийн номын сангуудыг нэгдсэн системд холбон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймгийн 216 номын санч мэдээллийн ажилтнуудад зохион байгууллаа. Энэ нь ном зүйн мэдээллийг автоматжуулж, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, электрон мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хүртээмж нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрийг оруулсан явдал мөн.

Эмхэтгэлийн төгсгөлд уламжлал ёсоор аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудыг үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн javlagaanomzui@gmail.com хаягаар болон 70188882 утсаар ирүүлнэ үү.

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол улсын Үндэсний номын сан 2024 онд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёлын салбарын томоохон бүтээн байгуулалтын нэг номын сангийн шинэ барилгаа ашиглалтад хүлээн авч үйл ажиллагаа, үйлчилгээгээ өргөжүүлсэн, цахим номын сангийн нэгдсэн системийг туршин нэвтрүүлж, 21 аймгийг холбох сургалт, арга зүйгээр ханган ажилласан онцлог ажлууд хийж, хэрэгжүүлсэн байна.

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ: Соёлын сайдын 2021 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам”-ын дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцэст тайлагнах 13 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 50 арга хэмжээний биелэлтийг Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд <http://moc.igovernment.mn/> оруулж, баталгаажуулсан ба өөрийн үнэлгээгээр 100% биелүүлж ажилласан байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

Монгол Улсын Засгийн газрын урт, дунд, богино хугацааны хөгжлийн хөтөлбөрүүд “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан болон холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах нийт 2 зорилт 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Зорилт. 1.1. Уламжлалт төрт ёсны үзэл, нүүдэлчин монголчуудын эрдэм ухааны өвийг үндэсний бичиг, үсэг, баримтат өвөөр дамжуулан үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулан сурталчилна.

Арга хэмжээ 1.1.1. Улс, үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, монголчуудын уламжлалт төрт ёсны үзэл, сургаалыг орчин үед нийцүүлэн хөгжүүлж эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэхэд нүүдэлчин монголчуудын эрдэм ухааны өвийг үндэсний бичиг, үсэг, баримтат өвөөр дамжуулан нийтэд таниулан сурталчилна.

Баримтат өвийг сурталчилсан сэдэвчилсэн үзэсгэлэн- 3. Үүнд:

1. "Богд хаан ба Олноо өргөгдсөн Монгол" тулгар сурвалж бичиг, ном судар, гэрэл зургийн үзэсгэлэн:

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны баярыг тохиолдуулан зохион байгуулж буй “Богд хаан ба Олноо өргөгдсөн Монгол” тулгар сурвалж бичиг, ном судар, гэрэл зургийн үзэсгэлэнг Монгол Улсын Үндэсний номын сангаас Залуу монголч судлаачдын Эрдмийн хэлхээ нийгэмлэг, Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан.

Нээлтийн арга хэмжээнд Улсын филармонийн гоцлол дуучин, Монгол Улсын Гавьяат жүжигчин, уртын дуучин Б.Мөнхбаатар Их Монгол Улсын төрийн дуулал хэмээгддэг “Эртний сайхан” уртын дуу, Үндэсний урлагийн Их театрын гоцлол дуучин, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Д.Наранхүү Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үеийн төрийн дуулал “Зуун лангийн жороо луус” дуугаар ая барьж, Монгол Улсын Төрийн дууллыг эгшиглүүлснээр, Монгол Улсын гурван төр

улсын дууллаар нээв. Мөн Анхдугаар Богд Жавзандамба Чингис хааны алтан ургийн угсаа Өндөр гэгээн Занабазарын зохион айлдсан Цаг лугаа зохилдуулсан залбирал Адистэдийн дээдийг хайрлагч Жанлавцогзол номыг Гандантэгчэнлин хийдийн лам хуврагууд хурсан юм.¹

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал, СГЗ Б.Ичинхорлоо, Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн шинээр томилогдсон дэд хамба С.Гантөмөр нар үг хэлж, Төрийн шагналт түүхч, доктор О.Батсайхан “Богд хаан ба Тусгаар тогтнол” илтгэл, Залуу монголч судлаачдын Эрдмийн хэлхээ нийгэмлэгээс “Төр, шашны зүтгэлтнүүд ба Тусгаар тогтнол” илтгэл тавилаа.

Харь гүрний 200 гаруй жилийн ноёрхол эрхшээлийг эцэс болгон үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, өргөн олон, дэлхий дахинаа тунхаглан зарласан 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр нь билгийн тооллын өвлийн дунд сарын шинийн 9-ний бэлгэт сайн эл өдрийг тохиолдуулан Монголын цагаагчин гахай жилийн хувьсгалын манлайлагч зүтгэлтнүүд болох Богд хаан, алтан ургийн язгууртнууд, ноёд түшмэд, шашин төрийн мэргэдийн түүхэн гэрэл зураг хийгээд Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Олноо өргөгдсөн Монгол Улсын түүхэнд холбогдох тулгар сурвалж бичиг, ном судрыг дэлгэсэн “Богд хаан ба Олноо өргөгдсөн Монгол” үзэсгэлэнг олны хүртээл болгож байна. Үзэсгэлэнгийн үзмэрүүдийг мөн төр ба шашин гэсэн хоёр жигүүрт хуваан гэрэл зураг, сурвалж бичгүүд, ном судрыг ангилан дэлгэсэн.

“Богд хаан ба Олноо өргөгдсөн Монгол” үзэсгэлэн 2023.12.21-2024.02.23-ны хугацаанд 2 сарын турш ажлын өдрүүдэд нийтийн хүртээл болох 600 орчим зорилтот үзэгчид, цахим танилцуулгыг 11 эрдэмтэн судлаачдын ярилцлагаар бэлтгэн хүргэсэн.²



1

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/videos/215373481612224/?_cft__\[0\]=AZXJVNLRIqjISTxmaO4J5KBo4a0CfdhOkIlgviFfKVqP01Slapylnl-u-QwJUK8DRfhBdyIvqgbm3frasVKR1MkZko7ShBwpkf8VAEkKZ4FK5wGs_HeпаeCmfIEjUgHHEVgdnHs1JNIPgF9Yjb0SMCsrlOUp16J51Af33HzaJWrekiM15rctAKgYw3x8BN5EnXfoZISa7623oyWhnb3-mTH&_tn_=%2C0%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/videos/215373481612224/?_cft__[0]=AZXJVNLRIqjISTxmaO4J5KBo4a0CfdhOkIlgviFfKVqP01Slapylnl-u-QwJUK8DRfhBdyIvqgbm3frasVKR1MkZko7ShBwpkf8VAEkKZ4FK5wGs_HeпаeCmfIEjUgHHEVgdnHs1JNIPgF9Yjb0SMCsrlOUp16J51Af33HzaJWrekiM15rctAKgYw3x8BN5EnXfoZISa7623oyWhnb3-mTH&_tn_=%2C0%2CP-R)

2 <https://youtu.be/IqFaJ0Zrp1M>



2. "Манж судлал-2024" олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурлын хүрээнд "Манж ном бичиг" үзэсгэлэн:

Монгол Улсын Их Сургуульд манж хэл бичгийг зааж эхэлсний 80 жилийн ойд зориулан 2024 оны 8 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд "Манж судлал-2024" олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурлыг зохион байгуулсан. Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг тохиолдуулан Монгол Улсын Үндэсний Номын Сангаас "Манж ном бичиг" үзэсгэлэнг 2024.08.24-09.13-ны өдрүүдэд зохион байгуулж, нээлтийн арга хэмжээнд тус олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцсон 12 улсын 51 эрдэмтэн судлаачийн төлөөлөл "Манж ном бичиг" үзэсгэлэнг үзэж сонирхож, өндөр сэтгэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн ба нийт 350 хүнд үзүүлсэн.

Манж судлал, тус үзэсгэлэнгийн ач холбогдол нь монголчуудын XVII-XIX зууны түүхэн баримт, сурвалж судлалын хувьд онцгой ач холбогдолтой билээ. Монгол Улсын Үндэсний Номын Сангийн сан хөмрөгт манж бичгийн 6600 гаруй дурсгал хадгалагдаж байгаагаас тус үзэсгэлэнд түүх, хууль цааз, уран зохиол, хэл шинжлэл, толь бичиг, шашин, гүн ухаан, анагаах ухаан, албан бичиг, зарлиг өргөмжлөл зэрэг ангилалд хамаарах гар бичмэл болон барын ном судраас дээжлэн дэглэж байна.

Мөн манж хэлний талаар хэвлэгдсэн судалгаа шинжилгээний бүтээл, толь бичиг, ном зүйн бүртгэл зэрэг хэвлэмэл бүтээлийг дэлгэсэн бөгөөд цахим танилцуулгыг Доктор, профессор М.Баярсайхан, МУИС-ийн багш, доктор Г.Отгонтуул, эх бичиг судлаач, багш Т.Жамъянсүрэн, Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн доктор Б.Нацагдорж зэрэг 7 судлаачдаас бичлэг хийж олон нийтэд хүргэсэн.





3. "Монголчуудын орчуулгын уламжлал" үзэсгэлэн:

Жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдөр болдог Дэлхийн орчуулагчдын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монголын Орчуулагчдын анхдугаар чуулган Төрийн ордонд болж, Монгол Улсын Үндэсний Номын Сангаас өөрийн сан хөмрөгт хадгалагдаж буй модон бар нь ЮНЕСКО-ийн Ази, Номхон далайн бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад бүртгэлтэй "Мэргэд гарахын орон" нэрт төвөд-монгол нэр томъёоны толь бичиг тэргүүтэй 15 судар, гар бичмэл, орчуулгын талаарх номоос дээжлэн 20 сударчилсан, гар бичмэл болон орчуулгын хэвлэмэл ном бүтээлийн дээжээс "Монголчуудын орчуулгын уламжлал" сэдэвт үзэсгэлэн 100 гаруй төлөөлөгч, сонирхон үзэгчдэд толилуулав.

Монголчууд бичгийн орчуулга хийж ирсэн баялаг уламжлалтай бөгөөд орчуулгын үндэс болсон толь бичгийг маш олон төрлөөр туурвиж иржээ. Мөн Жанжаа Хутагт Ролбийдорж "Мэргэд гарахуйн орон хэмээх тогтоосон даяг"-таа орчуулгын ерөнхий онолыг XVIII зуунд цэгцлэн тогтоож байсан нь орчин үеийн орчуулгын онолуудтай агуулгын хувьд зөрөөгүй байгаа нь гайхамшигтай юм.

Хамтран зохион байгуулж, оролцсон үзэсгэлэн:



“Монгол улсын нийслэл-385, Улаанбаатар хот-100” үзэсгэлэн Монголын Үндэсний музейд 4 номоор; 5. Марко Поло-700 жилд зориулсан “Марко Поло, Хубилай хаан, Монголчууд” тусгай үзэсгэлэн Чингис хаан Үндэсний музейд 1 гар бичмэлээр тус тус гаргасан.

Арга хэмжээ-3: 1. Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй Австралийн Холбооны Улсын Парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч хатагтай Сюзан Лаянс, Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Кэйти Смит тэргүүтэй төлөөлөгчид өнөөдөр Монгол Улсын Үндэсний Номын Санд зочлов.

Хүндэт зочдыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн захирал Б.Ичинхорлоо, Монголын номын сангуудын холбооны гүйцэтгэх захирал М.Даваасүрэн нар угтаж, Үнэт ховор номын музейдээ хүлээн авч, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн захирал Б.Ичинхорлоо номын сангийн түүхэн хөгжил, үйл ажиллагаа, ирээдүйн зорилго зорилт, бодлого төлөвлөлтийн талаар, Монголын номын сангуудын холбооны гүйцэтгэх захирал М.Даваасүрэн Австралийн ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр МУҮНС, МНСХ хамтран 21 аймагт хэрэгжүүлсэн “Хил хязгааргүй номын сан” төслийн талаар танилцуулав.

Зочид Үндэсний Номын Сангийн Үнэт ховор номын музей, Төвөд номын сан хөмрөг, Төвөд хэлт ном судрыг каталогт оруулах, цахимд шилжүүлэх төслийн үйл явцтай танилцсан юм.



2. Дипломат эмэгтэйчүүдийн төлөөлөгчдөд номын сангаа танилцуулсан:

Монгол Улсын Гадаад харилцааны яамны дэргэдэх Эмэгтэйчүүдийн дипломат клубийн санаачилгаар тус клубийн гишүүн эмэгтэйчүүд болон гадаад улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-дын эмэгтэйчүүдийн төлөөлөл өнөөдөр Монгол Улсын Үндэсний Номын Сангай танилцлаа.

Дипломат эмэгтэйчүүд Үндэсний Номын Сангийн Үнэт ховор номын музей, "Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэн, Төвөд номын сан хөмрөгийг үзэж сонирхон Төвөд хэлт ном судрыг каталогт оруулах, цахимд шилжүүлэх төслийн үйл явцтай танилцсан юм.

Энэ үеэр Эмэгтэйчүүдийн дипломат клубийн 25 жилийн ойд зориулсан номын дээжээс номын санд хандивласны хариуд Үндэсний Номын Сангаас талархлын бичиг гардуулсан ба зочид Үндэсний Номын Сан, Үнэт ховор номын музейтэй танилцаж, монголчуудын бичиг соёл, ном бичгийн уламжлалтай танилцсандаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн юм.



3. Эзэн Богд Чингис хааны мэндэлсэн өдөр Монгол бахархлын өдөрт түүхэн сурвалж, үндэсний баримтат өвийн 7 бүтээлээр цахим танилцуулгыг бэлтгэн нийт 58332 хүнд хүргэсэн.



Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/
May 6, 2024 · 🌐

ҮНЭТ ХОВОР НОМЫН МУЗЕЙ ҮНЭГҮЙ ҮЙЛЧИЛНЭ
Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Үнэт ховор номын музей энэ 5 дугаар сарыг дуустал олон нийтэд үнэгүй үйлчилнэ.

Үндэсний бичиг үсгийн баарыг тохиолдуулан Үнэт ховор номын музейд "Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд үзэсгэлэн" нээгдсэн бөгөөд үзэсгэлэнгийн агуулгад "ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв", ЮНЕСКО-гийн болон Монгол Улсын хосгүй үнэт өвд бүртгэлтэй Үнэт ховор номын музейн үзмэрүүд, монгол бичгээр бичигдсэн ном хэвлэл, ... See more



Байнгын үзэсгэлэнг 1824 хүнд тайлбарлан үзүүлсэн, цахимаар мэдээллийг 1,800,000 гаруй хүнд сурталчилсан.

1.1.2 Дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, цахим хуудас бий болгоно.

Байгууллагын цахим хуудсанд цахим үзэсгэлэнг 50 номоор баяжуулж, дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүд, номын санг сурталчлах хүрээнд:

1. Монголын Үндэсний Радиод “Сударчилсан ном” болон “Монгол шунхан Данжуур”, “Данжуурын гэрэлт хөшөө”,

2. МҮОНТ-ийн “Соёл эрдэнэ” хөтөлбөрт, ЮНЕСКО-д бүртгэгдсэн “Лу.Алтан товч”, “Сахиусан Дара эх”, “Монгол шунхан Данжуур” зэрэг өвүүдийн талаар,

3. “ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв” үзэсгэлэнд багтсан өвүүдийн талаар ASU.MN сайтад тус тус ярилцлага өгч сурталчлав.

4. Улсын нэр томьёоны зөвлөлийн 100 жилийн ойд зориулсан үзэсгэлэн "Нэр томьёо ба шинжлэх ухаан, технологийн хөгжил" олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр Төрийн ордонд гарсан үзэсгэлэнгийн талаар танилцуулга, бичлэгт ярилцлага өгөв. Ярилцлагын товч “Цагийн хүрд” нэвтрүүлэг, дэлгэрэнгүй нь “Эх хэл мину: “Нэр томьёо ба Шинжлэх ухаан технологийн хөгжил”-2024” нэвтрүүлгээр цацагдсан.

Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ May 26, 2024 · 🌐

Монголын радиогийн “Өглөө хөтөлбөр”-ийн баасан гаргийн өглөөний сурвалжилгаар Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ салбарын бүтээн байгуулалттай танилцсаныг хүргэж байна.

Маргааш буюу 5 сарын 27-ны өдөр шинэ барилгын нээлт 11:40 цагаас болно.



Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ May 24, 2024 · 🌐

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ШИНЭ БАРИЛГЫН НЭЭЛТ 2024.05.27-нд БОЛНО

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ барилгын нээлтийн ёслол 2024 оны 5 дугаар сарын 27-ны даваа гаргийн 11:40 морин цагт болно. Шинэ барилга нь Сүхбаатар дүүргийн зүүн талд, АНУ-ын ЭСЯ-ны урд байрлаж байна. <https://youtu.be/tzGoTOSFIZ4>



Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ June 7, 2024 · 🌐

Үндэсний Номын Сангийн шинэ байр Салбар номын сангийн талаар Арга зүйч В.Түвшинтогтох Terminal 1.0-ээр ярьсныг хүргэж байна.

https://www.youtube.com/watch?v=_LVrx2qMti8



Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ Reels · May 16 · 🌐

Х.ЧИЛААЖАВ
Үндэсний Номын Сангийн захирал асан /2010-2014/

Манай номын сан шинэ барилгаа энэ 5 дугаар сард ашиглалтад хүлээн авч, Салбар номын сангаа нээжээ. Ингэснээр Монгол Улсын Үндэсний Номын Сан хуучин 6... See more

5. Номын сангийн нийгмийн сүлжээн дэх хуудсаар “Данжуурын гэрэлт хөшөө”-ний тухай видео контент хийж түгээв.

6. Mongol HD телевизийн Terminal 1.0 хөтөлбөрт 2 удаагийн дугаарт 2 мэргэжилтэн оролцсон. Монгол Улсын Үндэсний Номын Сангийн салбар-Нийтийн номын сангийн шинэ барилгын нээлтэд зориулсан маркетинг, сурталчилгааны “Монгол Улсын Үндэсний Номын Сан” видео контент бүтээх ажлын хүрээнд 7 хэсэг бүхий 30 минут 19 секунд үргэлжлэх “Монгол Улсын Үндэсний Номын Сан” видео контентыг хийж, сурталчилсан. МҮОНР-ийн "Өв соёл" булантай 3 сарын турш 12 дугаарт хамтран ажилласан. Олон нийтийн телевизээр 50 орчим ярилцлага, танилцуулга хүргэсэн.

1.1.3 "Нүүдэлчин Монгол" наадмын хүрээнд монголчуудын бичиг үсэг, эх сурвалжийн түүх, эрдэм ухааны уламжлалыг нийтэд сурталчилна.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг 2024 оны 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Тайж хайрхан уулын өвөр байгалийн үзэсгэлэнт газар зохион байгуулагдав.

Монгол Улсын Үндэсний Номын Сан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Залуу монгол судлаачдын зуны сургуулийг дэмжин оролцож, хамтран ажилласан. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн хүрээнд тус хөтөлбөрт оролцогч Орос, Хятад, Япон, Солонгос, Турк, Польш улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 22 залуу монгол судлаачдад монгол соёлын өвийг таниулан сурталчлах дараах үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:

1. Монгол Улсын Үндэсний Номын сангийн төв байрны үйл ажиллагаатай 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр танилцуулж, Үнэт ховор номын музейг үзүүлэн монголчуудын бичиг номын соёл, ном бүтээх уламжлал, бичгийн соёл зэрэг биет болон биет бус соёлын өвийг таниулан сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулав.



2. Монгол Улсын Үндэсний Номын сангийн шинэ байрны үйл ажиллагаатай 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдөр танилцуулж, номын сангийн шинээр нэвтрүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлав.



3. Залуу монгол судлаачид 2024.08.16-ны өдөр “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг үзэж, монголчуудын соёлын биет бус өвийн 7 ай сав 362 төрөл зүйлээс танилцан суралцаж, 21 аймгийн өргөөгөөр зочлов.



4. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн үеэр залуу монгол судлаачид шагайн хавчаахай харваагаар хичээллэн суралцав.



5. “Нүүдэлчин” фестивалийн үеэр залуу монгол судлаачид тууль судлаач, доктор М.Ганболдын монгол туулийн тухай хичээлд оролцов.



6. Залуу монгол судлаачид Өвөрхангай аймгийн гэрээр зочилж, “Гүүний үрс гаргах ёслол”-ыг үзэж сонирхов.



7. Тус зуны сургуулийг хамтран зохион байгуулагч Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Маркетингийн менежер, докторант С.Чулуунпүрэв залуу монгол судлаачдад “Монголчуудын айргийн соёл” сэдвээр хичээл зааж, айраг дагасан соёл, хуруу дэмбээ зэрэг тоглоом наадгайг үзүүлэн сонирхуулж, соёлын биет бус өвүүдийн талаар сурталчлан таниулж ажиллав.




1.1.4 Үндэсний утга зохиол, ном судар, баримтат өвүүдийг бүртгүүлж, хамгаална.

Үнэт ховор номын музей, Гар бичмэл, монгол судлалын сан хөмрөг болон Төвөд номын сан хөмрөгт хадгалагдаж буй монгол бичиг, манж бичиг, төвөд бичгээр бичигдсэн нийт 50 дурсгалыг “Монгол улсын үндэсний баримтат өв”-ийн урьдчилсан жагсаалтад нэр дэвшүүлэн СӨҮТ-д жагсаалтыг хүргүүлсэн, бүртгэгдсэн нийт өв 165 болсон.

Сан хөмрөгөөс түүх, анагаах ухаан, уран зохиол, хэл шинжлэл болон бусад ухааныг хамарсан олон өвүүд хадгалагдаж буй боловч бид энэ удаад олон шинжлэх ухааныг хамарсан өвүүдийг нэр дэвшүүлэхийг зорилгүйгээр зөвхөн түүх, хууль хэмээх сэдвийн дор өвүүдийг сонгон нэр дэвшүүлэхээр мэдээлэл, тодорхойлолтыг бэлтгэсэн болно. ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад 2024 онд бүртгүүлсэн 1 өв бүртгүүлсэн. Энэ нь "Эзэн Богд Чингис хаанаас эхэлсэн Халхын долоон хошуу, дөрвөн аймгийн ноёдын гэрийн үеийн бичмэл"-ийг ба тус ЮНЕСКО-ийн баримтат өвийн X форумын хуралд Монгол Улсын Үндэсний Номын Сангаас бэлтгэсэн танилцуулга видеог англи тайлбартайгаар олон нийтэд сурталчилж,

YouTube

Хайх



The Family Chart of Hereditary Lords of the Khalkha Mongols, the House of Genghis Khan



National library of Mongolia
1.78 мянга Захиалагч

Захиалсан

5



Хуваалцах

Хадгалах



2348 хүнд үзүүлсэн.

1. Цахим номын үзэсгэлэн танилцуулгыг ЮНЕСКО-д бүртгэлтэй 7 өвийг танилцуулсан ба 2024 онд шинээр бүртгүүлсэн "Халхын дөрвөн хааны гэрийн үеийн бичмэл" угийн бичгийг сурталчилсан танилцуулга видеог МҮОНРТ, СӨҮТ-тэй хамтран хийсэн. МҮОНРТ-ээр олон нийтэд үзүүлж байна.



<https://youtu.be/xf4vQtO4A3Y>

Монгол таницуулга, мэдээлэл:

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid0ng8uFBiALLstwHEecC1dq2aHbx3GtiTJJ3dHvDacnvgA2euVQJXzgoajGrg7XEMil?_cft__\[0\]=AZVxs7YPMXGMNVf_xYB7aNt0oDGTp-u7ZaSSNzq81QyJfpFzjtVEMmZiGPK4Xkixqthmort1BzNjNovIXIAMaZlsNe0tf8I-7Lhn1DXrvy-VICXg6n6y-wJg4uvyT5jBN9zBynWHQ5UrZ_JF6BNNC6nCHehE8uIObalCjm4i-wafDK7nccj6javo08WHDQ4mWMS&_tn=%2CO%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid0ng8uFBiALLstwHEecC1dq2aHbx3GtiTJJ3dHvDacnvgA2euVQJXzgoajGrg7XEMil?_cft__[0]=AZVxs7YPMXGMNVf_xYB7aNt0oDGTp-u7ZaSSNzq81QyJfpFzjtVEMmZiGPK4Xkixqthmort1BzNjNovIXIAMaZlsNe0tf8I-7Lhn1DXrvy-VICXg6n6y-wJg4uvyT5jBN9zBynWHQ5UrZ_JF6BNNC6nCHehE8uIObalCjm4i-wafDK7nccj6javo08WHDQ4mWMS&_tn=%2CO%2CP-R)

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02XVgf3Hn4DtW9LwwzAR4ze1Ez25bUdaCGNsxnPE7tJGrFbp2LPRomN3MqDv3rBzbJI?_cft__\[0\]=AZW-GXCfzoruskFQmNjCROMIa5OJBj8j9VbDU6QDVw2GJ1yPor4CYTP9uLIOF62GLf4Yul7PJX9ISmRo9WA0cOo7feGSKCL8qUz2FvdEKDt2zSJR4d0M9SdyHNGO_n_d7NPXs46VUVes2FmhCcg2eR7NkQrTirSN0e4yu_fjaZsMflrqS1zCYJ3hy3FJrfWU&_tn=%2CO%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02XVgf3Hn4DtW9LwwzAR4ze1Ez25bUdaCGNsxnPE7tJGrFbp2LPRomN3MqDv3rBzbJI?_cft__[0]=AZW-GXCfzoruskFQmNjCROMIa5OJBj8j9VbDU6QDVw2GJ1yPor4CYTP9uLIOF62GLf4Yul7PJX9ISmRo9WA0cOo7feGSKCL8qUz2FvdEKDt2zSJR4d0M9SdyHNGO_n_d7NPXs46VUVes2FmhCcg2eR7NkQrTirSN0e4yu_fjaZsMflrqS1zCYJ3hy3FJrfWU&_tn=%2CO%2CP-R)

Мөн Монгол Улсаас ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн баримтат өвийн жагсаалтад бүртгэлтэй “ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв” тусгай үзэсгэлэнгийн хүрээнд бүртгэлтэй 7 өвийг цахимаар танилцууллаа. Үүнд:
ЮНЕСКО-д БҮРТГЭЛТЭЙ МОНГОЛ ӨВ
#1. "Мэргэд гарахын орон"-ы модон бар
#2. Лувсанданзаны "Алтан товч"

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02XVgf3Hn4DtW9LwwzAR4ze1Ez25bUdaCGNsxnPE7tJGrFbp2LPRomN3MqDv3rBzbJI?_cft__\[0\]=AZW-GXCfzorouskFQmNjCROMIa5OBj8j9VbDU6QDv2GJ1yPor4CYT9uLiOF62GLf4YuI7PJX9ISmRo9WA0cOo7feGSKCL8qUz2FvdEKDt2zSJR4d0M9SdyHNGO_n_d7NPXs46VUVes2FmhCcgh2eR7NkQrTirSN0e4yu_fjaZsMflrqS1zCYJ3hy3FJrWU&_tn_=%2CO%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02XVgf3Hn4DtW9LwwzAR4ze1Ez25bUdaCGNsxnPE7tJGrFbp2LPRomN3MqDv3rBzbJI?_cft__[0]=AZW-GXCfzorouskFQmNjCROMIa5OBj8j9VbDU6QDv2GJ1yPor4CYT9uLiOF62GLf4YuI7PJX9ISmRo9WA0cOo7feGSKCL8qUz2FvdEKDt2zSJR4d0M9SdyHNGO_n_d7NPXs46VUVes2FmhCcgh2eR7NkQrTirSN0e4yu_fjaZsMflrqS1zCYJ3hy3FJrWU&_tn_=%2CO%2CP-R)



1.1.5 Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном судрыг сонирхогч байгууллага, иргэнд гэрээ байгуулан судалгааны эргэлтэд оруулна.

Гар бичмэл, барын ном, баримтат өвийг судалгааны эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор хүсэлт гаргасан 11 байгууллага, судлаачидтай 203 номыг цахимаар авах гэрээ хийж хамтарч ажиллав.

Т

Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном судар, эрдэм шинжилгээний бүтээлийг судалгааны эргэлтэд оруулах зорилгоор байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан цахимаар өгсөн номын жагсаалт

2024.11.03

Д/д	Огноо	Гэрээний дугаар	Цахим хувилбараар өгсөн номын мэдээлэл	Хүсэлт гаргасан байгууллага, иргэн	Судалгааны сэдэв, зорилго
1	2024.01.30	№01	<p>1. 940/96 дансны дугаартай “Гучин нэгэн зэрэг нэмсэн арван найман зэрэг тэмдэглэсэн Халхын Махасамади далай Сэцэн ханы хошууны нутгийн зураг”</p> <p>2. 613/96 дансны дугаартай “Халхын Махасамади далай Сэцэн ханы хошууны нутгийн цэс”</p> <p>3. 959/96 дансны дугаартай “Олноо өргөгдсөний гуравдугаар онд</p>	<p>Судлаач доктор Ч. Жачин</p> <p>“Монголын түүхэн газар зүйн нийгэмлэг”</p> <p>ТББ-ын Удирдах</p>	<p>“Сэцэн хан Навааннэрэн”, “Наро Ванчин хутагтын намтар түүх” номуудыг бүтээх үйл ажиллагаанд зориулна.</p>

			<p>үйлдсэн Наро банчин хутагтын шавь нарын нутгийн зураг”</p> <p>4. 957/96 дансны дугаартай “Сайн ноён хан аймгийн Наро банчин хутагтын шавь нарын нутгийн зураг”</p> <p>5. 18462/97 дансны дугаартай Өргөх цэс: “Сайн ноён хан аймгийн Наро банчин хутагтын харьяат шавийн нутгийн цэс” эдгээр 5 эх сурвалжийг бүрэн эхээр</p>	<p>зөвлөлийн дарга</p> <p>Г.Бадамсамб уу</p>	
2	2024.02.05	№02	<p>3183/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” 60-62-р дэвтэр, 3184/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” 63-р дэвтэр, 3186/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” -ийн 57-59 -р дэвтэр Эдгээр 3 эх сурвалжийг бүрэн эхээр</p>	<p>Үндэсний эрх чөлөө эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн-ийн Захирал албан тушаалтай Оохной овогтой Батсайхан</p>	<p>Анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойн хүрээнд ном бүтээх үйл ажиллагаанд зориулна.</p>
3	2024.04.18	№24/14	<p>185/96 дансны дугаартай “Засагт хан аймгийн хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын анх түшмэл залгамжилснаас эдүгээ хүртэлхийн төрөл овог, гавьяа эндэгдлийг тодорхойлон бичсэн нь” эх сурвалжийг бүрэн эхээр 1 сурвалж</p>	<p>ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал баримт мэдээллийн төвийн эрхлэгч Б.Нацагдорж</p>	<p>“Засагт хан аймгийн ноёдын уг эх (Засагт хан аймгийн хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын анх түшмэл залгамжилснаас эдүгээ хүртэлхийн төрөл овог, гавьяа эндэгдлийг тодорхойлон бичсэн нь)” номыг бүтээх үйл ажиллагаанд зориулна.</p>

4	2024. 06.20	№24/4 3	“293/96 дансны дугаартай “Сайн ноён хан аймгийн хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг, тайж нарын гэрийн үеийн бичмэлийн цадиг” гар бичмэл бүтээл”	Судлаач, хэл бичгийн ухааны доктор Н.Нарангэрэл	Сайн ноён хан аймгийн талаар хэвлүүлэх түүхийн эмхэтгэлд хувилан ашиглах үйл ажиллагаанд зориулна.
5	2024. 09.25	№24/5 7 ХАГ- 24/14	<p>1. 1409/96 дансны дугаартай “Богд Жавзандамба хутагт эзэн гэгээний намтар” Дээд дэвтэр</p> <p>2. 1410/96 дансны дугаартай “Богд Жавзандамба хутагт эзэн гэгээний намтар” Доод дэвтэр</p> <p>3.1101/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Их Шавийн тамга бүхий үгүй хутагт, хувилгаан нарын шастир”</p> <p>4.1102/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Халхын Засагт хан аймгийн ван, гүнгүүдийн шастир”</p> <p>5.1103/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Сайн ноён хан аймгийн ван, гүнгүүдийн шастир”</p> <p>6.1554/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Сэцэн хан аймгийн ван, гүнгүүдийн шастир”</p> <p>7.2782/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Түшээт хан аймгийн ван, гүнгүүдийн шастир”</p> <p>8.1106/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Дөрвөд хоёр аймгийн ван, гүнгүүдийн шастир”</p> <p>9.1107/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Олон аймгийн тамга бүхий үгүй хутагт хувилгаан нарын шастир”</p>	Чингис хаан үндэсний музейн Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын хэлтсийн дарга Т.Энхтунгал аг	“Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамба хутагтын Зарлигаар тогтоосон Монгол Улсын шастир” 11 дэвтрийг бүрэн эхээр нь кирилл үсэгт буулган гар бичмэлийн хамт хэвлэх үйл ажиллагаанд зориулна.

			<p>10.1156/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Халх, Дөрвөд хоёр аймгийн засаг бус ван, гүнгүүдийн шастир”</p> <p>11.1108/96 дансны дугаартай “Зарлигаар тогтоосон Ерөнхийлөн үйлдсэн шастир” /үргэлжлэл хэсэг 28/96 дансны дугаартай “Богд Жавзандамбын анхан төрлийн нэр оршвой. Орон дацан анхан байгуулсныг бичсэн буянаар бурхны шашин өнө үүрд орших болтугай”, 5207/96 дансны дугаартай “Богд Жавзандамба хаан ширээн дор заларсны нууц түүх. Ялгуусны хөвгүүний баясгалангийн хуримын далай хэмээгдэх оршвой/</p>		
6.	2024.02.08	Хүсэлт өргөдөл	Л. Дэндэв. “Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр” 1936 он	Судлаач Бүдрагчаагийн Баяр	Хувийн архивд байгаа номынхоо байхгүй хэсгийг нөхөж хөрвүүлэх зорилготой
7	2024.02.16	Хүсэлт өргөдөл	1582/96 дансны дугаартай Дээрхийн тухай сурвалжийн 468-471-р 4 нүүр	Судлаач доктор Х. Мэндсайхан	Судалгааны ажилдаа YIII-р Богдын зарлигийг эх хэрэглэгдэхүйн болгож ашиглах
8.	2024.06.03	Хүсэлт өргөдөл	21005/01 дансны дугаартай “Халхын засагт хан аймгийн Хантайшир уулын чуулганы сайд Жүн вангийн зэрэг бөгөөд бэйлийн зэрэг Баатар засаг хошууны бэйс Базарваань миний биеэс дараалан хошууны тайж нарын гэрийн түүх” Олноо өргөгдсөний 7 дугаар он 7 сарын 11 /1917/	УБ.ЧД. 4-р хороо-Бага тойруу 12-5	Нагац талын удмын түүхэн хүмүүсийн ургийн бичигт хамаарах тул Судалгаа хийж хадгалах зорилготой

9	2024. 06.13	Хүсэлт өргөдөл	406/96-5 нүүр, 8605/96-/дэлгэмэл/ дансны дугаартай Түшээт засаг Сэрзагдын хошууны зураг, 8585/96 /дэлгэмэл/, 672/96-7нүүр дансны дугаартай Дулаан хан уулын хошууны зураг цэс, 929/96 /дэлгэмэл/ 653/96-8нүүр Рашаант уулын хошууны зураг	СХД-н 25-р хороонд оршин суугч Б. Амартүвшин, Т. Идэрхангай	Архангай аймгийн Батцэнгэл Жаргалант сумдын 100 жилийн ойн номонд оруулж хэвлүүлэхэд ашиглах
10	2024. 08.15	Хүсэлт өргөдөл	Монгол судлал, гар бичмэл номын сан хөмрөгийн хэсэгчилсэн зураг авалт бичлэгт	Баримтат киноны ерөнхий продюсор	Ховд аймгийн Дарви сумын 100 жилийн ойд зориулан бүтээж буй баримтат кинонд ашиглах
11	2024. 09.16	Хүсэлт өргөдөл	4765/96 дансны дугаартай Хангайн сан оршвой- 6 хууд-12 нүүр, 8675/96 дансны дугаартай Хангайн сан оршвой-3 хууд-6 нүүр, 20940/96 дансны дугаартай Хангайн сангийн судар оршвой- 4хууд-8 нүүр хэсэгчилсэн цахим хуулбар	Унгар улсын ЭЛТЭ их сургуулийн Монгол төв ази судлалын тэнхимийн багш доктор профессор Т. Кристина	"Хангай нурууны тахилгын" судалгаанд ашиглах

Зорилт 1.2. Хууль тогтоомж , тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Арга хэмжээ: 1.2.1 “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ, “Соёлын бүтээлч сар-2024” арга хэмжээний хүрээнд утга зохиол, ном хэвлэл, номын сангийн салбарын оролцоог нэмэгдүүлнэ.

"Соёлын бүтээлч сар-2024" арга хэмжээний удирдамж, батлагдсан төлөвлөгөөний дагуу Соён гэгээрлийн ажлын хүрээнд Орчин цагийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг С.Буяннэмэхийг онцлон зохион байгуулсан.

"Гэр бүл соёлын анхдагч орчин" хөтөлбөрүүдтэй уялдуулан С.Буяннэмэхийн намтар, зохиол бүтээлийг сурталчлан таниулах, зохиолоос чанга уншлага хийх, үзэсгэлэн, гар зургийн уралдааныг боловсролын хөтөлбөртэй уялдуулан, эрдэмтэн судлаачид оюутнуудын дунд “Суу билигт зохиолч Сономбалжирын Буяннэмэх” судлал: Лекц уулзалт хэлэлцүүлэг болон бусад зохиолчдын үйн арга хэмжээ, номын нээлт, яруу найргийн уншлага зэрэг 5 долоо хоногт 18 арга хэмжээг зохион байгуулсан.

ТЗУГ-ын хариуцсан "Бүх нийтийн боловсрол- хүний хөгжилд", "Соён гэгээрлийн салбарын онцлох хүнтэй уулзалт" 2 удаагийн хэлэлцүүлгийн зохион байгуулалтад хамтарч ажилласан.

Орчин цагийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг С.Буяннэмэхийн ном, бүтээлийн үзэсгэлэн, түүний "Алсыг зорьсон алтан загас", "Харанхуй засаг", "Их тэнгэрийн дүлий" гэх мэт зохиолууд "Уншлагын 7 хоног" арга хэмжээ, хэлэлцүүлэг, лекц, ярилцлага, өдөрлөг зохион байгуулсан.

Уншлагын долоо хоногийн хүрээнд "Алсыг зорьсон алтан загас" тууж, "Харанхуй засаг" жүжиг, "Их тэнгэрийн дүлий" өгүүллэгийг бүтээлчээр уншиж, удирдамжийн дагуу уралдаанд оролцсон оролцогчдоос шилдгүүдийг шалгаруулж, шагналыг гардуулав.

"ЭСЭЭ БИЧЛЭГ"-ийн төрөлд:

Тэргүүн байр - Дундговь аймгийн "Эрдмийн далай" ЕБС-ийн 116 ангийн сурагч Н.Анхмаа

Дэд байр - Дундговь аймгийн "Цэгц билиг" ЕБС-ийн

96 ангийн сурагч Н.Ундармаа

Тусгай байр: Нийслэлийн ЕБ-ын 151 дүгээр сургуулийн 106 ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ

"НОМЫН ТЭМДЭГЛЭЛ" төрөлд:

Тэргүүн байр - Нийслэлийн ЕБ-ын 151 дүгээр сургуулийн 106 ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ

Дэд байр - Нийслэлийн ЕБ-ын 2 дугаар сургуулийн 8а ангийн сурагч М.Индра

Тусгай байр - Нийслэлийн ЕБ-ын 2 дугаар сургуулийн 8а ангийн сурагч Б.Тэнүүн

"ГАР ЗУРАГ" төрөлд

Тэргүүн байр - Сити ИС-ийн оюутан Энх-Уянга

Дэд байр - Нийслэлийн ЕБ-ын 2 дугаар сургуулийн 8а ангийн сурагч Ц.Ундрал

Тусгай байр - Нийслэлийн ЕБ-ын 151 дүгээр сургуулийн 106 ангийн сурагч Н.Түвшинжаргал

"УРАН УНШЛАГА" төрөлд:

Тэргүүн байр - Сити ИС-ийн оюутан Б.Батхүү

Дэд байр - Нийслэлийн ЕБ-ын 151 дүгээр сургуулийн 106 ангийн сурагч С.Номин

Тусгай байр - Нийслэлийн ЕБ-ын 2 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагч Б.Ингүүнзаяа тус тус эзлэв.

Уншлагын долоо хоногт оролцож, хүрэлцэн ирсэн сурагч бүрд "Төгөлдөр Буяннэмэх" ТББ-ын тэргүүн доктор Л.Амаржаргал С.Буяннэмэхийн зохиол бүтээлийн дээжээс хүртээсэн юм.

Монгол Улсын Үндэсний Номын Сангаас зохион байгуулсан С.Буяннэмэхийн зохиолын "Уншлагын долоо хоног"-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон Нийслэлийн ЕБ-ын 2 дугаар сургуулийн Лхагважав багштай 8а ангийн хамт олон, 151 дүгээр сургуулийн Нямсайхан багштай 106 ангийн хамт олон, Сити их сургууль, МУБИС-ийн БоСС-ийн багш оюутан, сурагчид идэвхтэй оролцсон.

С.БУЯННЭМЭХИЙН БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН
<https://youtu.be/qKybod8QAMc>

Зохиолч, сэтгүүлч, утга зохиол судлаач, улс төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Сономбалжирын Буяннэмэх /1902-1937/-ийн бүтээл, гэрэл зураг, судалгааны ном хэвлэл, сонин сэтгүүлээс бүрдсэн үзэсгэлэнг Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Салбар номын сангийн шинэ байрны 2 дугаар давхарт 2024.11.04-18-ны өдрүүдэд уншигч олноо дэлгэн толилуулж байна. ... See more




1.2.2 Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 394 дүгээр тогтоолоор баталсан Монгол бичиг, соёлын түүхэнд холбогдох “Чингисийн чулууны бичиг”-ийн 800 жил, Цогт Хун тайжийн бичээс буюу “Дуутын хар чулууны бичээс”-ийн 400 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ:

Засгийн газрын 394 дүгээр тогтоолоор баталсан “Чингисийн чулууны бичиг”-ийн 800 жил, “Дуутын хар чулууны бичээс”-ийн 400 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, бүх нийтэд үндэсний бичиг үсгийн дурсгалууд, монголчуудын бичгийн соёлын өвийг сурталчлан таниулах, МУҮНС үйл ажиллагаагаа өргөжүүлэн шинэ салбар номын сангаа нээж буй баярт үйл явдлыг хамтатган “Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгал” үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарыг дуустал олон нийтэд үнэ төлбөргүйгээр толилууллаа.

Уг үзэсгэлэнг: 1. Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэг, үндэсний бичгийн дурсгал 2. Үндэсний бичгийн гайхамшигт дурсгал 3. Монголчуудын бичгийн соёлын дурсгалууд гэсэн үндсэн 3 хэсэгт ангилан, ангиллын хүрээнд МУҮНС-ийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол бичгээр бичсэн гар бичмэл, барын ном судраас дээжлэн дэглэн зохион байгууллаа. Энэхүү үзэсгэлэнг 52 оюутан, 32 сурагч, монгол болон гадаад 240 иргэн гээд нийт 324 хүнд үнэ төлбөргүй үзүүлэн сурталчлав. Тус үзэсгэлэнд багтсан өвүүдийн талаар ASU.MN сайт болон MNB телевизэд яриалцлага өгч олон нийтэд түгээв.


МУОНТ-ийн "Өглөө" хөтөлбөрөөс манай номын санд гарч буй "Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэнгээс бэлтгэсэн сурвалжилгыг хүргэж байна. <https://youtu.be/n1yMxm5kw7E>




[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02H1kRta7Q8n3RVjULp71SuH5RAZGFNkCaNJmz8qfujYWggmttAajsunxg3dVM1geQI?_cft_\[0\]=AZXeaWdLN4zPVIF87dV_XebFAWQXBH4I6NkNFbOGD6bs2LrGOK4CfYFnUh6hd-deAwtH5a63KwpbZfVeUsuCa_dTHX1rhMarWYyTNpyYID8T3uHNipa6J4awVI4u1qj7KmkhgOSmVV5Eu31VATn_mP70e7j2lw2mTZrXcmVhgiAnJpYZeKNIdG_MBZnrqDg_VzE&_tn_=%2CO%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02H1kRta7Q8n3RVjULp71SuH5RAZGFNkCaNJmz8qfujYWggmttAajsunxg3dVM1geQI?_cft_[0]=AZXeaWdLN4zPVIF87dV_XebFAWQXBH4I6NkNFbOGD6bs2LrGOK4CfYFnUh6hd-deAwtH5a63KwpbZfVeUsuCa_dTHX1rhMarWYyTNpyYID8T3uHNipa6J4awVI4u1qj7KmkhgOSmVV5Eu31VATn_mP70e7j2lw2mTZrXcmVhgiAnJpYZeKNIdG_MBZnrqDg_VzE&_tn_=%2CO%2CP-R)

Арга хэмжээ: 1.2.3. 2024 он “Үндэсний бичиг, соёлын жил” аян зохион байгуулна.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ЖИЛ-2024” арга хэмжээний нээлтийг хийж, брэндбүүк, удирдамжийг гарган соёл олон нийтийн арга хэмжээний хүрээнд Хүүхдийн төв номын сан, 21 аймгийн нийтийн номын сангууд сурталчлан, түгээж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас 2024 оны “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласантай холбогдуулан үндэсний бичиг, соёлын түүхэн ой, арга хэмжээ, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зэрэг олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх Соёлын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/120 дугаар тушаалаар баталсан арга хэмжээний хүрээнд “ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ЖИЛ-2024” агуулын мөн чанар, үнэ цэн, харагдах байдал лого, өнгө, дүрслэл гэх мэт бүхий л элементүүдийг агуулсан, уран бичлэг болон бусад техникүүдийг ашиглан зураг, дүрс, текстийг зурах буюу дижитал хэлбэрт буулгасан брэндбүүк хийлгэсэн. “Үндэсний бичиг, соёлын жил 2024” тушаалын хэрэгжилтийг ханган, удирдамжийг боловсруулан, Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний бичиг, соёлын өдрүүд-Номын баяр арга хэмжээний арга хэмжээг уялдуулан зохион байгуулж ажилласан.





Арга хэмжээ: 1.2.4. Соёлын сайдын албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллана.

1. "Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ" зорилт 2025 онд улсын хэмжээнд 5%-д хүргэх гэсэн шалгуур үзүүлэлтэд хүрэх бүрэн боломжтой. Нэгдсэн системийг шинэ барилгын үйлчилгээндээ нэвтрүүлэх, 21 аймгийн төв номын сангуудыг холбох, сан хөмрөг холбогдох шилжилт, хөрвүүлэг, сургалтын ажлууд давхар хийгдсэн байна.

2. Хүүхэд залуучуудад ном унших соёл, далыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Номын сангийн 14 боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үүнээс үүнээс 9 нь тогтмол хэрэгжүүлдэг ба Хаврын номын баярын хүрээнд 15 арга хэмжээг уялдуулан төлөвлөсөн. Шинэ барилгын төлөвлөсөн зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл нь хүүхэд залуучуудад түлхүү анхаарсан тул олон талт хөтөлбөр, арга хэмжээ цаашид нэмэгдэнэ.

3. Үндэсний номын сангийн шинэ барилга нь "А", "Б", "В" блок /3 блок/ VI буюу зоорины болон 11 давхар номын сангийн зориулалтын барилга, нийт 9948.2 м² талбайтай. Уншлагын танхим, сан хөмрөгийн эзлэх ашиглалтын талбай - 5524.42 м² хүчин чадалтай. Нүүлгэн шилжүүлэх ном, хэвлэлийг Номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаанд тавигдах стандартыг үндэслэн тооцсон. Нийт 384,000 орчим ном байрлах ч зарим албан тасалгаа, сервер инженерийн өрөө гэх зэргээр төлөвлөсөн танхимуудад сан хөмрөгийн нэмж зохион байгуулж 534,000 ном, хэвлэлийг нүүлгэн

шилжүүлсэн. Номын сангийн ном, хэвлэл нь жил ирэх тутам нэмэгдэж байдаг тул даац хэтрэх эрсдэл бий юм.

Арга хэмжээ: 1.2.5 Соёлын салбар дахь нэгдсэн тогтолцоо, хамтын ажиллагааны хүрээнд соёлын үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх яамны бодлогын хэрэгжилтийг хангана.

"Соёлын сэргэлт-2024" аяныг УБ хотод ЗГХА СУГ, 21 аймгийн СУГ-тай хамтран ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн "Монгол- гэр" үзэсгэлэн арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 12-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Манай байгууллага Баян-Өлгий аймгийн СУГ-тай хамтран боловсролын хөтөлбөрийг сурталчлан таниулах зорилготой "Алтайн оргил" казак гэрт нийт 5 хөтөлбөр, үүнээс "ГЭР мэдлэгээ сорьж, ном хожъё" боловсролын хөтөлбөрийг шинээр боловсруулан зохион байгуулсан. Казах гэр, хувцас зүүсгэл, тоглоом наадгай, бүргэдийн ан гэсэн казак үндэстний өв, соёлыг харуулсан боловсролын хөтөлбөр, асуулт, хариултын хөтөлбөр нийт 5 боловсролын хөтөлбөрийг нийт 9 өдөр 15 ажилтан хариуцан зохион байгуулж, зочилсон 1200 хүнд сурталчилсан.

Гэрийн тухай мэдлэгийг сорих, мэдлэг, мэдээлэл олгох хүрээнд гэрийн бүрдэл, оньсого, зүйр цэцэн үг, хэлц үг, бэлгэ дэмбэрлийг үг, үйл, цээр ёс, гэрийн дом, ертөнцийн гурав, гэрийн ерөөл гэсэн сэдэв агуулгын бэлтгэсэн 90 асуултыг тавьж, хөтөлбөрт 645 оролцож, амжилттай хариулсан оролцогчдод 550 номыг урамшуулалд өгсөн нь талархал хүлээсэн үйл ажиллагаа байлаа. Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл, өв, соёлын талаарх танин мэдэхүйн боловсролын хөтөлбөр нь хойч үе хүүхэд, залуучуудад соёлын биет бус өвийг сурталчилсан, өв уламжлал, эх хэлний баялаг сан хөмрөгийн мэдлэг, ухааныг түгээн дэлгэрүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж дүгнэж байна.



Монгол Улсын Үндэсний Номын Сангийн
 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн
 117 дугаар албан бичгийн
 хавсралт



**“МОНГОЛ ГЭР” ҮЗЭСГЭЛЭНГИЙН
 БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт 1.

№	Агуулга	Гүйцэтгэл	
1.	Арга хэмжээний нэр: Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Үзэсгэлэн зохион байгуулах тухай” А/52 дугаар тушаалаар батлагдсан “Монгол-Гэр” үзэсгэлэнгийн хэрэгжилт	Зорилго: “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх. “Гэр” боловсролын хөтөлбөр	
2.	Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв	
3.	Хэрэгжүүлэгч байгууллага:	Үндсэн хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч
		Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газар	Монгол Улсын Үндэсний Номын Сан
4.	Хэрэгжих нийт хугацаа:	2024 оны 5 дугаар сарын 04-нөөс 12-ны өдөр	
5.	Хэрэгжилтийн хураангуй	МУҮНС Монголын түүх, уламжлалт соёлын мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад бие даан эсвэл бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, түүнчлэн боловсролын салбарын үндэсний хөтөлбөрүүд, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжин үйл ажиллагаагаа явуулдаг. Үйл ажиллагааны хэлбэр нь: Үндэсний өв соёл, сан хөмрөгөөр дамжуулан үндэс угсаа, нас хүйс, шашин шүтлэг, нийгэмд эзлэх байр суурь, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран уншигч үйлчлүүлэгчид номын сангийн үйлчилгээг тэгш хүртэх боломжоор хангах, боловсрол олгох, сурталчлан таниулах зэргээр боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.	
6.	Боловсролын хөтөлбөрийн тоо	1	

7.	Дүгнэлт	<p>Монгол гэрийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, угсаатны онцлог бүхий Казак үндэстний гэрт байрлаж "Гэр" боловсролын хөтөлбөрийг 9 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн.</p> <p>Үүнд: Гэрийн тухай мэдлэгийг сорих, мэдлэг, мэдээлэл олгох хүрээнд гэрийн бүрдэл, оньсого, зүйр цэцэн үг, хэлц үг, бэлгэ дэмбэрлийн үг, зан үйл, цээр ёс, гэрийн дом, ертөнцийн гурав, гэрийн ерөөл гэсэн сэдэв агуулгаар бэлтгэсэн 90 асуулыг тавьж, хөтөлбөрт 645 хүн оролцож, амжилттай хариулсан оролцогчдод 550 номын урамшуулал олгосон.</p> <p>"Гэр боловсролын хөтөлбөр" хэрэгжүүлэх явцад хүүхэд, залуучууд ялангуяа ЕБС-ийн сурагчид түлхүү анхаарч сонирхож байсан ба хот, суурин газрын сурагчид дийлэнх хувь нь монгол гэрийн талаар ойлголт муутай байгаа нь ажиглагдаж байлаа. Тиймээс ерөнхий боловсролын сургуулийн түвшин бүрд хичээлээр дамжуулан Монгол гэрийн уламжлалт зан үйлийн мэдлэг олгох чиглэлд анхаарах шаардлагатай байна.</p>
----	---------	---

Хүснэгт 2.

№	Үзэгчдийн ангилал	"Алтайн оргил" гэрээр зочилсон хүний тоо										Нийт
		Тавдугаар сар										
		4	5	6	7	8	9	10	11	12		
1	Насанд хүрэгчид	55	80	55	95	105	89	95	78	125		777
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	2	1	3	2	1			2	3		14
3	Хүүхэд	45	45	15	20	25	15	25	30	35		255
4	Жуулчид	15	25	15	20	25	20	15	25	15		175
Нийт		114	151	88	137	156	124	135	135	178		1221

Хүснэгт 3.

№	Боловсролын хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрт хамрагдсан хүний тоо										Нийт
		Тавдугаар сар										
		4	5	6	7	8	9	10	11	12		
1	Хөтөлбөр 1: "Гэр" боловсролын хөтөлбөр	75	80	75	75	65	75	45	70	85		645
Нийт												




Арга хэмжээ: 1.2.6 Засгийн газрын тухай хуульд заасан "Агаарын бохирдол"-ын асуудлаар салбарын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг 4 удаа байгууллагын цахим хуудсанд сурталчилсан.

Байгууллагын гадна болон дотоод орчинд ногоон байгууламж бий болгох арга хэмжээний хүрээнд шинэ номын сангийн гадна орчинд НИТХ-ын дэмжлэгээр тус бүр нь 400,000 төгрөгийн үнэ бүхий 40 ш таримал модыг байрлуулсан ба гадна талын цэцэгжүүлэлтийг хийсэн.

Уншлагын танхим, өрөө тасалгаанд цэцэгжүүлэх аян өрнүүлж, албан хаагчид нийт 168 ш цэцэг, номын сангийн ахмадын зөвлөлөөс албан тасалгааны том, модлог ургамал 5 ширхгийг бэлэглэж, тохижилт хийсэн.

Нийт хамт олон цахилгааны хэрэглээгээ хянах, хог хаягдлаа ангилан хаях зориулалтын 12 савыг давхар бүрд байрлуулсан, хогийн цэгт хаяж хэвшсэн.




Хоёр. Төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ


Зорилт: 2.1. Номын сангийн цахим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлж, мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах технологийн нөхцөлийг бүрдүүлнэ.

Арга хэмжээ: 2.1.1 Нэг соёл систем, нэг хуудас арга хэмжээний хүрээнд байгууллагын веб, цахим хуудасны мэдээллийг сайжруулах, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хийнэ.

Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хийх хүрээнд <https://e-lib.cis.mn/> системийг нэвтрүүлж байна. Веб <https://nationallibrary.mn/>, цахим хуудас <https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/> болон <https://www.youtube.com/@NationalLibraryofMongolia> сувгуудаар Монгол Улсын Үндэсний номын сангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан ажлын мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж, цахим хуудасны дагагчдын тоог 50,675-д хүрч, сурталчилгаа мэдээлэл, танилцуулга контентыг 305 удаа бэлтгэн, 2,562,088 хүнд хүргэсэн.



Views 1.2M Reach 881.3K ↑ 104.9% 3-second views 906.7K ↑ 1.1K% 1-minute views 78K ↑ 1.2K% Content interactions 66.2K ↑ 62.2% Watch time 257d 14




Views breakdown

Jan 1, 2024 – Dec 31, 2024

Total 1,150,868
From organic 93%
From ads 7%

Top content by views

Boost content See all content





Арга хэмжээ: 2.1.2 Номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэл дижитал номын сангийн туршилтууд хийгдэж, нэвтрүүлсэн байна.

Номын сангийн Коха 22.11 хувилбарыг нэвтрүүлж, дата баазын хөрвүүлэлт, шинэчлэлт хөгжүүлэлтийг хийсэн. Номын сангийн нэгдсэн цахим систем нэвтэрсэнтэй холбоотойгоор уншигч орон зай, цаг хугацаанаас хамаарахгүйгээр хур, дан системийн тусламжтайгаар уншигчийн бүртгэл үүсгэх, ном хайх, захиалах, унших, номын сангийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нээлээ. Тус үйлчилгээг <https://e-lib.cis.mn/> хаягаар, гар утасны E-Library аппликейшныг хэрэглэгчдэд нэвтрүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2024 онд аймгийн төв номын сангуудад сургалт, хөрвүүлэлтийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: 1. Орон нутгийн номын сангуудын каталогийн датаг архивлан авч, нэгдсэн цахим системийн сургалтыг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр 21 аймаг, нийслэлийн номын сангийн 230 гаруй номын санчдыг хамрагдуулсан ба батламж олгосон. 2. Сургагч багшийг бэлтгэсэн нийт 14 номын сангийн мэргэжилтнүүд 2 мэдээллийн технологийн инженер. 3. Орон нутгийн номын

сангуудын программ хангамж, сан хөмрөгийн судалгаа хийж, нэгдсэн системийн тохиргоо хийж, номын мэдээллийн буюу каталогийн мэдээллийн санг /дата/ хуулбарлан авсан.





МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН

Цахим номын сангийн аппликейшн

Аппликейшнээ татаад хүүссэн газраасаа номын санд зочлоорой.

 App Store татах

 Google Play татах



МОНГОЛ ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

Хэрэгцээт
Үйлчилгээний нөхцөл

Тусламж
Түгээмэл асуулт хариулт

Холбоо барих /Төв байр/
Чингисийн өргөн чөлөө - 4,

- Цахим номын сангийн системийг <https://e-lib.cis.mn/> хаягаар авахаас гадна iOS болон Android үйлдлийн системтэй гар утсанд аппликейшн хэлбэрээр татагдахаар бэлтгэж, App store болон Play store дээр байршуулав.
- Тус систем дээр номыг pdf болон ePub форматаар татагдахаар бэлэн болгов.

Арга хэмжээ: 2.1.3 Номын сангийн ном, хэвлэлийг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Цахимд шилжүүлсэн ном орчин үеийн 238 ном, 56 сэтгүүл, 887 диссертацийг шилжүүлэн нийт 47051 хуудас номыг ажиллаж e-lib.cis.mn монгол судлалын талаарх болон дэлхийн шилдэг уран зохиолын 94 нэрийн, монгол хэл ном 128 нэрийн номыг цахим уншлагад шилжүүлсэн. Монгол гар бичмэл, барын номоос 460 нэрийн гар бичмэл, ном судар, диссертацийн, 40 ш данс бүртгэлийг цахимд шилжүүлсэн нь нийт 35393 хуудас /70,786 нүүр/-ийг цахим санг нэмэгдүүлсэн Төвөд ном судрыг каталогт оруулах, цахимд шилжүүлэх төслийн хүрээнд ердийн каталогийн ажилтнууд 808 судар багцаар (баринтаг) оруулсан. каталогт бүртгэх каталогийн ажилтнууд нийт 31393 гарчиг бүртгэлд оруулаад байна. Түүнээс 1241 багц судрын 417107 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд 8100 багц судар зургийн боловсруулалтад орж бүрэн дууссан бөгөөд BDRC веб сайтад байршаад байна.

Цахим номын сан

Бүтээлийн хэлбэр

 Цахим ном 138	 Сэтгүүл 56	 Сонин 0	 Магистрын ажил 0	 Диссертаци 892
-----------------------------	--------------------------	-----------------------	--------------------------------	------------------------------

Их уншигдсан бүтээлүүд Бүгдийг харах →

Народное хозяйство Монгольской Народной Республики за 40 лет



Оюутны суралцаж сурах үйлийн туршилт судалгаа

Irish Fairy Tales

Монгол улсын аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийн шинжилгээ

Номын санч, №1

Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байсан хуучны пилонк дахь 600 гаруй зургийг цахим хэлбэрт шилжүүлэн, үзэсгэлэн, олон нийтийн арга хэмжээнд дэлгэн, олон нийтэд сурталчлав.



Зорилт. 2.2. Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаа, өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага, үндэсний болон олон улсын стандартыг хангасан тав тухтай орчин бүрдүүлнэ. Шинэ салбар номын сангийн барилгыг ашиглалтад хүлээн авч, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.



Арга хэмжээ: 2.2.1 Стандартад нийцсэн орчин нөхцөлд номын сангийн үйлчилгээг уншигчдад үзүүлнэ.

Байгууллагын дулаан, хэрэглээний цэвэр, бохир ус, цахилгааны аюулгүй байдлыг хангаж, хэсэгчилсэн засвар үйлчилгээг 34 удаа 21 төрлийн засвар хийсэн. Ажлын байранд 6 удаагийн хортон шавж устгал, ариутгал, халдваргүйтгэлийн ажил хийж гүйцэтгэсэн. Монголын Үндэсний Номын сангийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан Ц.Доржбат ажилчдыг ажил үүргээ гүйцэтгэх тухай бүрд нь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмж өгч гарын үсэг зуруулан тэмдэглэл хөтөлж ажиллаж байна. Цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол, чанартай хийж дотор талбайд нийт 57 удаа, гадна талбайд 6 удаа 1900 к.мв талбайд их цэвэрлэгээг хийсэн.

Арга хэмжээ: 2.2.2 Үндэсний номын сангийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авч, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж, нээлтийн арга хэмжээг зохион байгуулна.

Үндэсний номын сангийн шинэ барилгын ажлыг гүйцэтгэл 100%, 3 давхраас дээш интерьерийн ажлыг 90%-тай ашиглалтад хүлээн авч, нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгүүлэн 6-9 сард засвар дууссан. Нийт ТХАА-ны газраас зарласан 14 багц тендерийн гүйцэтгэлийг нийлүүлэгч компаниудаас хүлээн авч В1-11 дүгээр давхрын сан хөмрөг, уншлагын танхим, албан тасалгааны тавилга, техник тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан.

Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг 03 дугаар сарын 1-ээс эхлүүлэн, 04-р сарын 03-ны өдрөөс Хил хамгаалах Ерөнхий газрын 44 албан хаагч, номын сангийн 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр тээвэрлэх ажлыг эхлүүлж, нийт 8 удаагийн тээвэрлэлтээр 534000 орчин үеийн ном хэвлэлийг шилжүүлэн, шинэ зохион байгуулалтын дагуу хүлээлцүүлж, системийн тохиргоо, данс бүртгэл, тооллогын ажлыг хийж, үйлчилгээний бэлэн байдал номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах стандартын дагуу зохион байгуулалтыг хийж, уншигчдад үйлчлэхэд бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллаа. Данс бүртгэл, каталогийн хайлт мэдээллийн системийн ажил, тооллого хяналтын ажлууд хийгдэж байна. РФАЙД системийн чип шинээр зохион байгуулж буй сан хөмрөг, уншлагын танхимуудад үе шаттай хийгдэж байна.

Нээлтийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг СБХЗГ, СХОГ-тай хамтран бэлтгэл ажил болон зохион байгуулалтын ажлыг ТНБД Ч.Цэвэгдорж удирдлага, чиглэл өгч ажилласан ба нээлт болон үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой цэвэрлэгээний материал, байгууллагын тохижилтын ажлууд мөн хийгдсэн. Нээлтийг 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, МУ-ын Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-ын гишүүд зэрэг нийт 600-аад хүндэт зочид, төлөөлөгчид, олон нийт оролцож, номын сантай танилцлаа. 5 дугаар сарын 28-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн.

Арга хэмжээ: 2.2.3 Нүүлгэн шилжүүлсэн ном, хэвлэлийг сан хөмрөг, уншлагын танхимаар зохион байгуулалтыг хийж, үйлчилгээ нээхэд бэлэн болгоно.


Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг “Үндэсний номын сангийн шинэ барилгад нүүлгэн шилжүүлэх ажлын цогц төлөвлөгөө”, “Нүүлгэн шилжүүлэлтийн үед баримтлах заавар”-ын дагуу 3 үе шаттайгаар зохион байгуулсан. 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс “Нүүлгэн шилжүүлэх ном хэвлэлийг хайрцаглах” ажлыг эхлүүлэн, 10 ажлын хэсэгт нийт 66 хүний бүрэлдэхүүнтэй Монгол, Өрнө дахины сан хөмрөгийн 4832 хайрцаг, 225697 ширхэг, Дорно, Тогтмол хэвлэлийн сан хөмрөгийн 3496 хайрцаг, 138491 ширхэг ном, Тогтмол хэвлэлийн сан хөмрөгийн 1322 хайрцаг буюу 4620 гялгар уут, 139808 ширхэг тогтмол хэвлэлийг тоолж, хайрцаглаж, хаяг нааж, 1-р давхарт зөөж тээвэрлэхэд бэлэн болгох ажлыг 03-р сарын 29-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэсэн. (Нийт өссөн дүнгээр 9650 хайрцагт 503996 ширхэг номыг зөөж, тээвэрлэхэд бэлтгэсэн.)



Албаны каталогийн цаасан картыг зөөж тээвэрлэх зорилгоор 480000 орчим цаасан картыг хайрцаглан тээвэрлэхэд бэлтгэсэн. 2024 оны 04-р сарын 03-ны өдрөөс ХХЕГ-ын 44 албан хаагч, номын сангийн 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр тээвэрлэх ажлыг эхлүүлж, нийт 8 удаа тээвэрлэлт хийсэн.

Сан хөмрөгийн нүүлгэн шилжүүлэх үед үүсэх эрсдэл, хяналт ба фондын орчны шинжилгээг ном зөөх явцад хэмжилтийн багаж суурилуулж, хяналт хийсэн. Яамны Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагч С.Урантөгс, шинжээч Б.Оюунзул нар хяналт тавьж, ажлын бэлтгэл ажлын явц, эрсдэлийн судалгаа, хяналт хийх төлөвлөлт, дараалалтай танилцсан.






Шинэ байранд тээвэрлэж авчирсан ном, хэвлэлийг төрөлжсөн уншлагын танхимд тоолж, хүлээлгэн өгч, тавиурт байрлуулах ажлыг жагсаалтын дагуу 6 ажлын хэсэгт зохион байгуулж, 453900 орчим ном хэвлэлийг тоолж, тавиурт байрлуулаад байна. Захирлын 09-р сарын 19-ны өдрийн А/46 тоот “Ажлын хэсэг



байгуулах тухай” тушаалаар 31704 ш картыг хэвлэж, 4 танхимын 6-10 оронтой бар кодтой 18337 ш номыг 12 оронтой болгож засварлан нийт 31540 ширхэг номын RFID tag нааж идэвхжүүлж, буцаан байрлуулсан.

Салбар номын сангийн чөлөөт сонголттой 4 танхимын 6-10 оронтой баркодтой 18337 ширхэг номыг 12 оронтой болгож засварласан. 18337 ширхэг монгол ном, 13203 ширхэг гадаад ном, нийт 31540 ширхэг номыг татан авч RFID tag нааж идэвхжүүлж, буцаан байрлуулсан.


Салбар номын сангийн сан хөмрөгийн номын каталогийн картыг Коха системээс хэвлэх ажлын хүрээнд каталогчид карт хэвлэх ажлын хэсгийн хувиарлалт, "Карт бичих заавар" гарын авлагыг бэлтгэж, хариуцсан номын санчдад заавар зөвлөгөө өгч ажилласан. Каталогчид нийт 15636 ширхэг, номын санчид 16068 ширхэг нийт 31704 картыг хэвлэсэн байна.



Арга хэмжээ: 2.2.4 Шинэ барилгын техник, тоног төхөөрөмж, тавилга тохижилтыг хийж, үйл ажиллагааг эхлүүлнэ.

Гэрээ байгуулсан гүйцэтгэгч компаниас нийт 14 багц тендерийн ажил үйлчилгээ, барааг акт баримтаар хүлээн авч, 2022 оноос тухайн компаниудын агуулах, байрнаас хүлээж 100%, авч, угсралт, суурилуулалтыг хийлгэн, хяналт тавьж ажилласан.

№	Танхим	Наасан TAG
2	Язгуур	9162
3	Эрдэм	7366
4	Хүмүүн	7474
6	Ертөнц	7538
	Нийт	31540



Үлдэгдэл хөрөнгө оруулалтын судалгаа, ажлын даалгаврыг хийж, бараа материал, ажил үйлчилгээний жагсаалтыг гаргаж өгөх СХОГ-т хүлээлгэн гаргаж өгсөн ба ТХАА-ны газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2024 оны хөрөнгө оруулалтын 800 саяын Багц 15 “Санаа мед” ХХК, Багц 16,17 “Грандмакс” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна.



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН ШИНЭ БАРИЛГЫН НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.3. дэх хэсэг “Үндэсний номын сангийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна.” гэсэн зорилтыг хэрэгжүүлж, орчин үеийн шаардлагад нийцсэн номын сангийн барилгыг ашиглалтад өгч, Монгол Улсын Үндэсний номын сангийн номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг дэлхийн жишигт нийцүүлэн өөрчлөлт, үйл ажиллагааны шинэчлэлт хийсэн түүхэн үйл явдлыг тэмдэглэхэд ач холбогдол өгч зохион байгууллаа.




Монгол Улсын Үндэсний номын сангийн шинэ барилгын нээлтийн бэлтгэл ажлыг хангах, ажлыг зохион байгуулахад шаардлагатай зардлыг Соёлын сайдын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/514 дүгээр тушаалаар баталж, соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр эрх шилжүүлэх тушаал гарснаар бэлтгэл ажил болон зохион байгуулалтыг хийж ажилласан.

Нээлтийн арга хэмжээний бэлтгэл ажлыг Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Соёлын бодлогын газрын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн нар удирдлага, зохион байгуулалт, зөвлөмж, хяналт тавьж

ажилласан.

Соёлын сайд Ч.Номин 04 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Үндэсний номын сангийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна” зорилтыг хэрэгжүүлж, орчин үеийн шаардлагад нийцсэн салбар номын санг ашиглалтад оруулж үйлчилгээг дэлхийн жишигт нийцүүлэхээр номын сангийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авч, ирэх тавдугаар сард нээх бэлтгэл ажилтай танилцсан. (Хавсралт 1.)



Шинэ номын сангийн нээлтийг Соёлын яам болон манай байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн байсан ч энэ 5 дугаар сардаа нээлтээ хийхээр бага зэрэг хугацаагаар хойшлогдосон. Гэхдээ 5 сарын 1-нээс хуучин номын сандаа уншлага үйлчилгээгээ нээн ажиллаж эхэлсэн, ялангуяа оюутан, судлаачдын шалгалт, хамгаалалтын үе учир хэлсэн хугацаандаа үйлчилгээ үзүүлж байна.

Энэ нь бидний номын сангийн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, зөөж тээвэрлэх болон шинэ номын сангийн уншлагын танхим, сан хөмрөгүүдэд хүлээлгэн өгөх ажил мөн номын сангийн системийн хайлт, мэдээлэл, ном захиалах, олголт гэсэн дотоод зохион байгуулалтын ажил хийгдэх болон хамгийн гол ажил нь шинэ барилга, тохижилтын ажил, нээлтийн арга хэмжээ зэрэг үндсэн 6 ажил хоорондоо уялдаатай төлөвлөн зохион байгуулж ажилласан.

Үндэсний номын сангийн шинэ барилга ашиглалтад авах ажлын хүрээнд номын сангийн нэмэлт ажил интерьерийн ажлыг 2024 онд хийж дуусгахаар төлөвлөгдсөн ажлыг хийж дуусгах асуудлыг Соёлын яамнаас шийдвэрлэж өгснөөр хугацааг хойшлуулсан ч номын сан ая тухтай, шинэлэг байх ёстой гэсэн үүднээс бид интерьерийн зураг төслийг хийлгэх зорилготой байсан.

Ер нь номын сангийн барилга ашиглалтад авах, номын сангийн үйл ажиллагаа эхлэх гэдэг нь театр, музейн нээлтээс өөр гэдгийг хэлэх хэрэгтэй байх, нарийн зохион байгуулалт, төлөвлөлт, зааврын дагуу их олон хүний хүч хөдөлмөр зарцуулдаг, уншигч, үйлчлүүлэгчид маань байнгын буюу өдөр тутам ч ирэх боломжтой, хэрэглэгчийн юу унших, ямар мэдээлэл олж авах нь агуулгын хувьд харилцан адилгүй, хязгааргүй гэж хэлж болох учраас бид бас бэлэн байдлыг дээд зэргээр хангасан байх юм. Нийт 112 ажилтан бүх хүчин чадлаараа ажиллаад үйлчилгээ үзүүлэхэд бэлэн болж сан хөмрөгөөс нүүлгэн шилжүүлэх ном, хэвлэлийг шинэ байрандаа байрлуулан зохион байгуулж дууссан ба хуучин байран дахь сан хөмрөгүүдээ мөн байрлуулж, зохион байгуулалтаа хийх зэрэг томоохон ажлуудыг зохион байгуулж ажилласан.



Гадна тохижилт: НИХТ-ийн дэмжлэгтэйгээр 40 ширхэг таримал мод тавьсан. Автомашину орох, гарах ухаалаг хаалт хийсэн.

1.1. Нээлтийн арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил: уригдах зочдын нэрс гарган, Монгол Улсын Ерөнхийлөгч, ЕТГ, УИХ-ын дарга, УИХ-ын НБСБШУ-ны

байнгын хороо, УИХ-ын гишүүдийн төлөөлөл, Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын дарга, Соёлын яам, Барилга хот, байгуулалтын яам, ШУА, ЗГХА, Соёл урлагийн газар, Соёлын яамны харьяа соёл урлагийн байгууллагууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч, НЗДТГ-ын төлөөлөл, НСУГ, 21 аймгийн номын сангийн төлөөлөл, бүх шатны боловсролын байгууллагын номын сан, номын сангийн салбарын бусад байгууллын төлөөлөл, гүйцэтгэгч, оролцогч, хандивлагчдын төлөөлөл: ШУА, ХХЕГ, “Энх төгс тэмүүлэл” ХХК, Барилга хөгжлийн төв, “Голомт сан” зэрэг хамтран ажилладаг байгууллагын төлөөлөл, Уншигч, судлаачид зохиолч, уран бүтээлчдийн төлөөлөл Үндэсний номын сангийн ахмадууд, нийт 438 зочид төлөөлөгчдийг урьсан.

Арга хэмжээний өнгө төрхийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас 2024 оны “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласантай холбогдуулан “Үндэсний бичиг соёлын жил 2024” өнгө төрхийг илтгэсэн байхаар төлөвлөсөн.

Монгол Улсын Үндэсний номын сангийн ажилтнуудын 05 дугаар сарын 27-ны өдрийн нээлтийн арга хэмжээний хариуцах ажлын зохион байгуулалтыг гарган, удирдамж, зааварчилгаа өгч ажилласан. (Хавсралт 2)

Ном, бүтээл, бэлэг дурсгал: Дотоод, гадаадын уригдсан зочид, төлөөлөгчдөд зориулсан бэлгийн багц нь байгууллагын болон нээлтийн арга хэмжээний онцлогийг харуулсан, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг зорилго болгон судлан гаргасан ба үүнд монгол бичгийн ном, дурсгалуудаас судалгааны тайлбартай номын каталог, бичиг үсгийн дурсгалын зүйл, танилцуулга, номын хавчуурга, даавуун тор зэргээс бүрдэнэ.


- Бэлгийн тор - Монгол Улсын Үндэсний Номын Сангийн брэнд бүтээгдэхүүний зориулалтаар номын сангийн шинэ, хуучин барилгын иллустратор зургийг дизайнераар зуруулан авч, торны эхийг боловсруулаад, санхүүгийнхэнтэй хамтран үйлдвэрт захиалсан. Торыг ЮНЕСКО-ын зочид төлөөлөгчид, “Монгол бичгийн цахим бичвэр-III” улсын уралдааны шилдгүүд, шинэ барилгын нээлтийн ёслолын зочдод гарын бэлэг болгон өгсөн.
- Гүюг хааны тамганы дардас - Гүюг хааны тамганы дардсыг жаазлах 250 ширхэг жаазыг судалж захиалсан. Сэргээн засварлагч, СХХХ-ийнхэн дардсыг бэлтгэж, бэлэн болсон бүтээгдэхүүнийг ЮНЕСКО-ын зочид төлөөлөгчид, шинэ барилгын нээлтийн ёслолын зочдод гарын бэлэг болгон өгсөн.
- “Монгол Улсын Үндэсний Номын Сан дахь монгол бичгийн өв” ном - Ном бүтээх ажлыг зохион байгуулалтаар хангаж ажиллаж, Сэргээн засварлагч Ү.Доржоо, Сан хөмрөгч Б.Отгонтуяа нар 2024.03.12-04.17-ны хооронд тайлбарыг боловсруулан бэлтгэсэн. Монголын гэрэл зургийн сурвалжлагчдын холбоотой шинэ байрны нээлттэй холбоотой гэрэл зургийн багц үйлчилгээ авах гэрээ байгуулсны дотор номын зургийг авхуулах ажлыг багтааж, эхийг дизайнер Б.Тамираар бэлтгүүлсэн. Номыг “Адмон” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт 500 ширхэг хэвлүүлсэн. Номоос Номын баярын худалдаа, Монгол бичгийн цахим бичвэр-III” улсын уралдааны шилдгүүд, шинэ барилгын нээлтийн ёслолын зочдод гарын бэлэгт зарлага гаргасан.



- Номын сангийн танилцуулга - Шинэ барилгын нээлттэй холбогдуулан номын сангийн хоёр байрны үйл ажиллагааг тусгасан танилцуулгын загвар, бичвэр, зургийг боловсруулсан. Эхийг М.Даваасүрэн нэмэн засварлаж эцэслэн, 600 ширхгийг хэвлүүлж, санхүүд хүлээлгэн өгсөн. Танилцуулгаас ЮНЕСКО-ын зочид төлөөлөгчид, “Монгол бичгийн цахим бичвэр-III” улсын уралдааны шилдгүүд, шинэ барилгын нээлтийн ёслолын зочдод гарын бэлэг болгон өгсөн.



- Номын хавчуурга - Данжуурын гэрэлт хөшөөний загвараар номын хавчуурга бэлтгэн 500 ширхгийг хэвлүүлж, санхүүд хүлээлгэн өгсөн. Хавчуургаас ЮНЕСКО-ын зочид төлөөлөгчид, “Монгол бичгийн цахим бичвэр-III” улсын уралдааны шилдгүүд, шинэ барилгын нээлтийн ёслолын зочдод гарын бэлэг болгон өгсөн.
- Урилга - Шинэ барилгын нээлтийн ёслолын урилгын эхийг М.Даваасүрэн бэлэн болгож бэлтгэснийг хэвлэлтэд шилжүүлж, 300 ширхгийг нээлтийн ажлын хэсгийнхэнд хүлээлгэн өгч ажиллав.



Урилгын загвар

Урилга

1.2. Дижитал контент, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа: Нээлтийн арга хэмжээний шторк³ 5 минутын хийж олон нийтэд хүргэсэн.

Нээлтийн арга хэмжээний түүхэн үйл явдал болон соёлын салбарын 89 дэх бүтээн байгуулалтын үйл явцыг бичлэгээр үлдээх зорилготой “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН ӨРХ ӨСГӨЖ, ХАЯА ТЭЛСЭН НЬ” баримтат киноны зохиолыг гарган, “Shigu film” хамтран ажиллаж, зураг авалтууд хийгдсэн байна.

Маркетинг, контент бичлэг, хэвлэл мэдээлэл:

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн салбар-Нийтийн номын сангийн шинэ барилгын нээлтэд зориулсан маркетинг, сурталчилгааны “Монгол Улсын Үндэсний Номын Сан” видео контент бүтээх ажил гүйцэтгэх 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 24/11 дугаартай гэрээг Монгол Улсын Үндэсний Номын сан “Idea Source” ХХК-тай байгуулсан.

Энэхүү гэрээгээр Монгол Улсын Үндэсний Номын сангийн захиалгын дагуу “Idea Source” ХХК нь 2 шторк бүхий 5 хэсгээс бүрдсэн 30 минутын контент бэлтгэж, хүлээлгэн өгөхөөр зааж, ажлын төлөвлөгөө, зардлын задаргааг хавсралтаар баталсан.

Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу:

1. Үндэсний Номын Сангийн түүх
2. Сан хөмрөг
3. Үнэт ховор номын музей
4. Төв байр
5. Салбар номын сан
6. Ном шилжүүлэн байршуулах үйл явц

³ Дараах холбоосоор үзэх

[https://www.facebook.com/Moc.gov.mn/posts/pfbid032th8q4uWBrcKXpi1ZGj4k43Z6pjoFXVRzseMrjQLW44CacsPE64XbMDsfPCJcV8nl?_cft_\[0\]=AZVtWUf6BJnhYQmzakz8DKsh5F8XdbxONW5162OiTaxqTGpo4dE8OT8N5p44F4c4owrunKAqHIYnuZH_Pnfigbw7XkRtaYpCi24X0ZMTeMPHA3r-RCLxOAcXUwx7jC0HJ2pDtOfaQ9K545QHQMdNqlcvFvrQnrCNfDXooZYU8-CT6plYCV1ttcgOfraqX_3zji8H_3MIPHqefx88bh1qOu8A&_tn_=%2CO%2CP-R](https://www.facebook.com/Moc.gov.mn/posts/pfbid032th8q4uWBrcKXpi1ZGj4k43Z6pjoFXVRzseMrjQLW44CacsPE64XbMDsfPCJcV8nl?_cft_[0]=AZVtWUf6BJnhYQmzakz8DKsh5F8XdbxONW5162OiTaxqTGpo4dE8OT8N5p44F4c4owrunKAqHIYnuZH_Pnfigbw7XkRtaYpCi24X0ZMTeMPHA3r-RCLxOAcXUwx7jC0HJ2pDtOfaQ9K545QHQMdNqlcvFvrQnrCNfDXooZYU8-CT6plYCV1ttcgOfraqX_3zji8H_3MIPHqefx88bh1qOu8A&_tn_=%2CO%2CP-R)

7. Шинэ байрны танхимууд гэсэн 7 хэсэг бүхий 30 минут 19 секунд үргэлжлэх “Монгол Улсын Үндэсний Номын Сан” видео контентыг 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдөр захиалагчид хүлээлгэн өгсөн.

Контентын эхний бүлэг болох 21 минут 35 секунд үргэлжлэх хэсгийг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр гүйцэтгэгчээс хүлээн авсан бөгөөд тус контентоос 10 удаагийн видео контентыг таслан Үндэсний Номын Сангийн цахим хуудаснаас нийтэлж, төлбөрт сурталчилгаа болон цацсан. Контентыг захиалагчийн олон нийтийн цахим сүлжээний хаягаар нийтлэхдээ гүйцэтгэгч талын мэргэшсэн хүнээс төлбөрт сурталчилгаа хийх арга зүйн зөвлөгөөг авч ажиллав.

Гүйцэтгэгч тал нээлт зохион байгуулсан компанийн шаардсан ёсоор нээлтийн ёслолын үеэр дэлгэцнээ үзүүлэхээр:

1. Соёлын яамны логоны хөдөлгөөнт график дүрс
2. Үндэсний Номын Сангийн логоны хөдөлгөөнт график дүрс
3. 1 минут 30 секундийн хугацаанд үргэлжлэх шинэ барилгын олон талаас авсан дрон бичлэгүүд
4. Морин хуурын чуулга хөгжимдөх, Хүүхдийн ордны дугуйлангийн сурагчид шүлэг уншихад дэлгэцэд өгөх 7 минут 15 секунд үргэлжлэх мэргэжлийн өндөр түвшний, сайн чанарын дүрс, байгалийн зураглал бичлэгийг нийлүүлж ажилласан болно.

Бүтэн контентоос тасалж, Үндэсний Номын Сангийн цахим хуудаснаас нийтэлсэн 3 reel, 7 видео нийтлэлийг 2024 оны 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 29-ний өдрийн хооронд 1 сая 50 мянга гаруй удаа үзсэн дүнтэй байна. Тус контентыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизээр 2024 оны 6 дугаар сарын 09-ний өдөр нэвтрүүлсэн.

Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ ажлын төлөвлөгөөнд туссан зорилго, зорилтод нийцүүлэн чанарын болон мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, захиалагчийн хүлээсэн үр дүнд хүрсэн видео контент, ажлын үр дүнг нийлүүлсэн буюу гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн.

1.3. ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН: “НОМЫН САНГИЙН БАРИЛГА – ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ”: 5 дугаар давхрын үзвэрийн танхимд Монголын Гэрэл зургийн сурвалжлагчдын холбоотой хамтран зохион байгуулж, барилгын гүйцэтгэл, шинэ номын сангийн бэлтгэл ажлыг харуулсан нийт 80 гэрэл зураг, 2 барилгын макет загвар, анхны шав тавих ёслолын суурь чулуун бичээс зэргийг хүндэтгэлтэйгээр байрлуулан олон нийтэд сонирхууллаа.

Нээлтийн ёслолын арга хэмжээний зохион байгуулалт

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ барилгын нээлтийн ёслол 2024 оны 5 дугаар сарын 27-ны даваа гаргийн 11:40 морин цагт боллоо.

Нээлтийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, УИХ, Засгийн газрын гишүүд, Соёлын сайд Ч.Номин, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн захирал Б.Ичинхорлоо, гадаад улс орнуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдууд, ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлууд, эрдэмтэн мэргэд, зохиолч, уншигч, олон нийтийн төлөөлөл оролцов. *(Хавсралт- Номадик контент тайлан)*

Үндэсний Номын Сан шинэ салбар номын сангаараа олон нийтийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн ном хэвлэлийг бүрдүүлж, цахим номын сан, олон талт хөтөлбөр үйлчилгээгээр бүх насны уншигчдад үйлчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд гэр бүлд чиглэсэн төрөлжсөн үйлчилгээ үзүүлж үйлчилгээнийхээ хүрээ хүртээмжийг тэлж байна. Түүнчлэн хамтын ажиллагаа, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн хурал зөвлөгөөний болон үзэсгэлэнгийн танхим, дуу, дүрс бичлэгийн студи, аудио, видео болон цахим уншлагын танхим, багаар ажиллах өрөө, бүтээлч танхим зэрэг бүтээлч орон зайн шийдэлтэй.

Шинэ барилгын нээлтийн үеэр мөн Үндэсний Цахим номын сангийн нэгдсэн системийн нээлтийг хийж, Үндэсний Номын Сангийн шинэ барилгын бүтээн байгуулалтын гэрэл зургийн үзэсгэлэн, “Хамгийн хамгийн - Онцлох ном”-ын үзэсгэлэн дэглэн гаргасан.

Монгол Улсын Үндэсний Номын Сан сан хөмрөгтөө байгаа ном хэвлэлийн 534 мянгыг нь шинээр нээж буй Салбар номын сандаа шилжүүлж, үлдсэн 3.0 сая орчим судар бичиг, сурвалж судлалын эх хэрэглэхүүн, ном хэвлэлээр Төв байр /хуучин барилга/-нд Эрдэм шинжилгээний номын сангийн үйл ажиллагаа эрхлэн явуулна. Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Салбар номын сангийн шинэ барилга нь Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Денверийн гудамж буюу Сүхбаатар дүүргийн зүүн талд, АНУ-ын ЭСЯ-ны урд буюу Сэлбэ голын баруун эрэг дагуу байрлаж



уншигчидыг хүлээн авч үйлчилж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх нээлтийн ёслолд оролцож, шинэ номын сан эрдмийг дээдлэн, номд мөргөдөг монгол ёс уламжлалын бэлгэ тэмдэг болон сүндэрлэсэнд баяртай байгаагаа илэрхийлэв. Номын сан түүх, соёл,

өв уламжлал, шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн томоохон төв болж, дэлхийн шилдэг номын сангуудын жишгээр хөгжихийн ерөөл өргөлөө.

Эрдэм номыг дээдэлдэг ардын уламжлалаа даган, хүүхдүүдээ номын сайн нөхөр болгон хүмүүжүүлж, оюунлаг ирээдүйг бүтээхийн төлөө хүн бүр сэтгэл, зүтгэл гаргахыг иргэдэд уриаллаа.

Номын санг барихад хүчин зүтгэсэн төрийн болон хувийн хэвшил, Үндэсний номын сангийн удирдлага, хамт олонд талархал илэрхийлж, амжилт хүсэн ерөөв.

Ерөнхийлөгч мөн монгол түмний өсөн дэвжиж, өргөжин дэлгэрэхийн бэлгэдэл болсон есийн тоог бэлгэдэж, 99 ширхэг “Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон” бүтээлийг өргөн барилаа. 2008 онд Үндэсний номын сангийн иж бүрэн барилга, байгууламжийг бүтээн цогцлоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн



зарлиг гарснаар шавыг нь тавьж, 2014 онд барилгын ажил нь эхэлсэн. Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх тухайн үед буюу 2019 онд Ерөнхий сайд байхдаа бүтээн байгуулалтын явцтай танилцан, ажлаа эрчимжүүлэх үүрэг, чиглэл өгч байсан юм.

Үндэсний номын сангийн шинэ салбар номын сан нь олон нийтийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан олон улсын жишигт нийцсэн бүтээн байгуулалт болсон. Орчин үеийн ном хэвлэлийг бүрдүүлж, цахим номын сан, олон талт хөтөлбөр үйлчилгээгээр бүх насны уншигчдад үйлчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд гэр бүлд чиглэсэн төрөлжсөн үйлчилгээ үзүүлж үйлчилгээнийхээ цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлсэн хэмээн тус номын сангийн захирал Б.Ичинхорлоо онцоллоо.



Монгол улсын засгийн газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд Үндэсний номын сангийн шинэ барилга бүрэн хэмжээнд тогтмол үйл ажиллагаатай болж байна. Уг барилга олон улсын жишигт нийцсэн орчин цагийн иргэдийн хэрэгцээ

шаардлагыг хангасан бүтээн байгуулалт болж байгаагаараа онцлогтой. Номын сан ашиглалтад орсноор соёлын хүртээмж нэмэгдэнэ. Мөн шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж нээгдэж байна гэж үг хэлж, талархлаа илэрхийлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Соёлын сайд Ч.Номин тэргүүтэй хүндэт зочид болон Элчин сайдын яамд, УИХ, Засгийн газрын хүндэт зочид номын



сангийн үйл ажиллагаатай танилцлаа. Нээлтийн өдөр шинэ номын сангийн барилгын зохион байгуулалттай нийт 800 гаруй хүнд танилцуулсан байна.

Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам Монгол Улсын Үндэсний номын сан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнд шинэ салбар номын сангийн барилгыг ашиглалтад хүлээн авч, үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.

Энэхүү номын санд номын сангийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үйлчлэх зорилтын хүрээнд нийтийн болон төрөлжсөн уншлагын бүх танхимуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ном унших боломжийг бүрдүүлж, тэднийг ялгаварлах, тусгаарлахгүй байх зарчмыг баримтлан, “Онцлог хэрэгцээт



иргэдийн танхим” буюу Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 82.11м² талбайтай 20 суудал бүхий танхимыг тусгайлан зохион байгуулан тохижилтыг хийж, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин Үндсэн шаардлага” MNS 6055:2009 стандарт шаардлагад нийцсэн байхаар анхаарч, зохион байгуулсан.

Шинэ номын сангийн барилга, байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч, хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах журмыг үндэслэн



<https://www.facebook.com/watch/?v=390878847353404>

Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

Зорилт: 3.1. Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ: 3.1.1 Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, эртний гар бичмэл ном, судрыг сэргээн засварлан, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Гар бичмэл, барын эртний гар бичмэл ном, судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Молон тойн эхийн ачийг хариулсан нь”, “Молон тойн эхийн ачийг хариулсан нь”, “Дотоод хэлтэст өргөсөн албан бичгүүдийн хуулбар” зэрэг дэвтэрчилсэн 209 хуудас буюу 418 нүүр бүхий 3 ш, “Шинэ засгийн гол ёс ном”-ын 28 хуудас нийт 237 хуудас буюу 468 нүүр баримтат өвийг сэргээн засварлалаа.



Сэргээн засварлахын өмнөх болон дараах зураг

Сэргээн засварлах мэргэжил арга зүй, сургалтын хүрээнд Япон Улсын Киотогийн урлаг, дизайны сургуулийн профессор Ообаяши “Япон цаасны онцлог, цаасан баримтат өвийн сэргээн засварлалт, хадгалалт, хамгаалалтын тухай” сэдвээр Монгол Улсын Үндэсний номын сан-гийн Төв байрны /Хуучин барилга/ 2 давхрын сургалтын танхимд лекц уншиж, Үндэсний номын сангийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөв.

“Соёлын бүтээлч сар 2024” аяны хүрээнд “Цаасан суурьтай баримтат өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын чиг хандлага, цаашдын хөгжлийн тухай” хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 30 гаруй архив, музей, номын сангийн соёлын өвийн мэргэжилтэн, сэргээн засварлагчид хамрагдлаа.



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Соёлын биет өвийг тээвэрлэх зөвшөөрөл олгох тухай” А/57 тоот тушаалыг үндэслэн 2016 оны 1 дүгээр сарын 18-ний өдөр батлагдсан “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ын дагуу Соёлын өвийн Үндэсний төвд 2023 онд сэргээн засварлуулахаар хүлээлгэн өгсөн 4 дэсийн 5 ширхэг өвийг Монгол Улсын Үндэсний Номын сангийн захирлын “Сэргээн засварлуулсан соёлын биет өвийг хүлээн авах, зөөж тээвэрлэх тухай” 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/50



тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн зөөж тээвэрлэн буцаан авч хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.

Арга хэмжээ: 3.1.2 Түүх, соёлын дурсгалт зүйлийн хосгүй үнэт, үнэт зэрэглэлд хамаарах болон ганц хувь бүтээлийг цахим хэлбэрт оруулж баримтын хамгаалалтын хувь хийж, эх баримтаас тусад нь хадгална.

Сан хөмрөгөөс 460 нэрийн гар бичмэл, ном судар, диссертаци, хуучин данс бүртгэл 40 ширхгийн нийт 35393 хуудас, /70,786 нүүр/-ийг цахимд оруулж нэмэгдүүлж, 460 гар бичмэл, ном судрыг жагсаалтад бүртгэн, 32,390 JPEG зургийг засварлан хадгалав.

Зорилт: 3.2. Сан хөмрөгийн судалгаа хийсний үндсэн дээр үндэсний соёлын өв, оюуны бүтээлийг бүрдүүлж, баяжуулна.

Арга хэмжээ: 3.2.1 Номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулж, уншигчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үндэсний соёлын өв, оюуны үнэт бүтээлээр сан хөмрөгийг баяжуулна.

Сан хөмрөгийн бүрдүүлэлтийн судалгааг 12 судалгаа хийсэн.



Бүрдүүлсэн ном- Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн 185 нэрийн 976 ширхэг 32,367,578,75 төгрөгийн номыг шинээр худалдан авч, бэлэг хандивын журмаар 247 нэрийн 989 ширхэг 21,354,500 төгрөгийн ном, заавал авах хувиар 24 нэрийн 146 ширхэг 4,948,000 төгрөгийн ном, 125 нэрийн 125 ширхэг 1,260,000 төгрөгийн диссертаци CD, нөхөн бүрдүүлэлтээр 14 нэрийн 31 ширхэг 1,095,000 төгрөгийн ном, солилцоогоор 176 нэрийн 180 ширхэг 3,150,000 төгрөгийн ном Нийт 771 нэрийн 2447 ширхэг 64,175,078,75 төгрөгийн ном.

-Дансалсан- 2245 ном, - 625 нэрийн 1402 ширхэг номыг цахим нэг бүрчилсэн бүртгэлийн хэлбэрт оруулсан. -Ангилсан- 2447 ном. - Коха программд номын шифр болон 2171 ширхэг түлхүүр үг, 5118 ширхэг гарчиг шивж оруулсан.

-Каталогт 3671 карт бичиж, 3338 карт байрлуулж, Редакц -10036, Лавлагаа 10700. Номын тооллогыг 7 удаагийн тооллогоор 134042 ширхэг номыг бар код уншуулж тоолж, бар код уншуулсан файлыг КОХА системд байгаа номын мэдээлэлтэй тулгалт хийж “2024-тоолов” тэмдэглэгээ хийж, дүнг гаргасан.

Тооллогын явцад алдаатай хөрвөгдсөн 1311 ширхэг номыг КОХА систем засварлаж, зөрүүтэй байгаа 1098 ширхэг номыг танхимуудын номын санч нартай хамтарч алдааг олж зассан.

Монгол номын сан хөмрөгийн 10т-ын ангийн 2022 он хүртэлх нийт номын нэгдсэн бүртгэлийн эцсийн дүнг гаргаасан.

Шинжлэх ухааны нэв:		Дансны дугаар		Тоо	Үнэ	Дансны дугаар		Тоо	Үнэ
5, 059, 91, 92, 94, 925	2 Байгалийн шинжлэл	5976	236956.25	Данс-1	898	1175.34	Данс-19	1369	5446.99
6, 06, 62,64,65,66,67, 68, 69	3 Техник	3758	66533.98	Данс-2	4219	19103.29	Данс-20	1382	5323.97
63	4 Хөдөө аж ахуй	5586	198284.54	Данс-3	1227	1556.68	Данс-21	2730	11287.63
61	5 Анагаах	3906	161404.29	Данс-4	1995	3590.83	Данс-22	3262	16384.12
3, 30, 31	60.5 Социологи	315	4323.8	Данс-5	1576	2531.41	Данс-23	3009	15689.68
9, 902, 913	63 Түүх	4333	1418727.17	Данс-6	1660	3576.07	Данс-24	3325	15597.91
33, 36	65 Эдийн засаг	6842	69730.9	Данс-7	1988	3097.65	Данс-25	3041	15974.32
32, ЗАХН	3Х/66 Улс төр	4136	11558.45	Данс-8	2046	3729.05	Данс-26	3583	22497.44
34	67 Төр эрх зүй, хууль цааз	1485	179597.33	Данс-9	1844	3508.61	Данс-27	3131	18214.5
35	68 Цэргийн ШУ	1849	4451.51	Данс-10	2254	5022.59	Данс-28	3665	21899.62
001,002,37, 39, 794, 795	7 Соёл, шинжлэх ухаан, Боловсрол	2240	40554.01	Данс-11	2166	6041.03	Данс-29	3679	22045.15
4	80/81 Хэл шинжлэл	3311	954466.16	Данс-12	2173	6301.84	Данс-30	3615	21191.32
8, 801-821	82/83 Утга зохиол, аман зохиол	862	1909096.89	Данс-13	1640	3757.56	Данс-31	3292	18702.3
8х, 081, 8дет, 8г, 81-88, 89, 891	84 Уран зохиол	23708	2148038.29	Данс-14	1871	5632.61	Данс-32	2263	12257.86
7	85 Урлаг	2589	966167.24	Данс-15	1341	4907.54	Данс-33	2306	35771.02
2	86 Шашин	1207	48291813.71	Данс-16	1151	4148.12	Данс-34	736	406422.27
1,16/3х, 3д, 3н	11/87 Гүн ухаан	5995	89108.03	Данс-17	1082	4644.37	Данс-35	398	513040.74
15	88 Сэтгэл судлал	165	899.27	Данс-18	1116	3776.5	Данс-36	1230	55487863.89
03,05,058	9 Лавлах хэвлэл								
		78263	56751711.82	Нийт	32247	86101.09	Нийт	46016	56665610.73
							10-т нийт	78263	56751711.82

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2015 оны 12 дугаар сарын 15-ны А/500 тоот тушаалаар баталсан “Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журам”-ыг үндэслэн МУҮНС-ийн захирлын А/31, А/28, А/30, А/37, Б/64, А/39, Б/80, тоот тушаалын дагуу Үндэсний номын сангийн төв байрны “Их уншлага”, Салбар номын сангийн “Язгуур, Эрдэм, Хүмүүн, Гэр бүлийн танхимыг 7 удаагийн тооллогоор 134042 ширхэг ном, А/49 тоот тушаалын дагуу Тогтмол хэвлэлийн тахимын 64398 нэгж тогтмол хэвлэлийг баркод уншуулж тоолж, баркод уншуулсан файлыг КОХА системд байгаа номын мэдээлэлтэй тулгалт хийж “2024-тоолов” тэмдэглэгээ хийж дүнг гарган илтгэх хуудсыг бичиж 2024 оны 11-р сарын 20-ны өдрийн Захиргааны хурлаар оруулж танилцуулсан.

№	Танхим	Тоолсон НОМЫН ТОО
1	Их уншлага	18600
2	Язгуур	34878
3	Эрдэм	23078
4		25565
5	Хүмүүн	28053
6	Гэр бүл	1934
7		1934
	Тогтмол хэвлэл /нэгж/	64398



Арга хэмжээ: 3.2.2 Архивын сан хөмрөг, сан хөмрөгийн ном, хэвлэлийг заавал авах хувь, гадаад солилцоогоор сан хөмрөгийг баяжуулна.

"Дэлхийн номын өдөр"-өөр 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулдаг "Эрдэм номын чуулган 2024" аяны хүрээнд ШУА-ийн харьяа 13

хүрээлэнгүүдээс номын танилцуулгыг авч, <https://www.facebook.com/National.Library.of.Mongolia> цахим хуудсаар танилцуулгыг хүргэсэн. Заавал авах хувиар 125 нэрийн 125 ширхэг 1260,000 төгрөгийн диссертаци CD, 153 нэрийн 283 ширхэг номыг ШУА-аас хүлээн авсан. Архивын сан хөмрөгт 333 нэрийн 333 ширхэг 8,439,741 төгрөгийн ном бүрдүүлсэн. Харилцаат 17 улсын 20 номын сан, эрдэм шинжилгээний байгууллагууд руу 8 нэрийн 255 ширхэг 8,925,000 төгрөгийн үнэ бүхий номыг илгээсэн. - Харилцаат 3 улсын номын сангаас 2 нэрийн 1080 ширхэг 216,000 төгрөгийн сонин, 20 нэрийн 204 ширхэг 714,000 төгрөгийн сэтгүүлийг хүлээн авсан.



Зорилго: 3.3. Үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлыг зохион байгуулах, бүх төрлийн номын санг эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

Арга хэмжээ: 3.3.1 Ном зүйн нэгдсэн лавлагаа, мэдээллийн санг цаасан ба цахим хэлбэрээр бүрдүүлж, бусад номын сангийн сан хөмрөгийн мэдээллийг нэгтгэнэ.

Тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санг нийт 3571 өгүүллээр баяжууллаа. Үүнд: Өдрийн сонин, “Өнөөдөр” сонин, Өглөөний сонин, Үндэсний шуудан сонин, Улирал ба зохиолч сонин, Номын санч сэтгүүл, Боловсрол судлал сэтгүүлийн 4469 өгүүлэл, Орон нутгийн Өнөөгийн Баянхонгор сонин, Найрамдлын Дархан сонин, Дорнод сонин, Дундговийн амьдрал сонин, Өнөөгийн Эрдэнэт сонин, Шинэ мэдээ сонин, Говийн мэдээ сонин, Сүхбаатарын өнгө сонин, Ховдын толь, Ховдын мэдээ сонин, Хэнтийн мэдээ сонин, Увсын өнгө сонин, Эрх чөлөө сонин, Монгол аман сонин, Алтай news сонин зэрэг тогтмол хэвлэлийн 1361 өгүүлэл.

Арга хэмжээ: 3.3.2 Ном зүйн мэдээллийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, улсын нэгдсэн каталог, үндэсний ном зүйг эрхлэн гаргана.

“Үндэсний цахим ном зүйн бүртгэл”-ийг сайжруулах, талбарт өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд 2023 оны Үндэсний цахим ном зүйн бүртгэлийг хийх, коха программд каталог бүртгэл хийх зөвлөмж, гарын авлага бэлтгэх талаар каталогч, ном зүйчид хамтран ажиллав.

“Үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн сан байгуулах тухай” тушаалын хэрэгжилтийг ханган Үндэсний цахим ном зүйн санд нийт 3000 нэрийн номыг бүртгэж, нэрийн Баталгаажсан бүртгэл хийсэн. Уг ажлыг зохион байгуулахад утга, зохиол ном хэвлэлийн 80 гаруй байгууллага хамтран ажилласан.

Хэвлүүлсэн ном зүйн бүртгэл 4. Үүнд: 1. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл-2018”, 2. "Монгол Улсын Төрийн шагналт, эрдэмтэн-зохиолч, хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), Ш.Гаадамбын санамж өгөх ном зүйн бүртгэл.3. Баян-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 75 жилийн ойд зориулсан “Баян-Өлгий аймаг – Орон нутгийн ном зүй”. 4. Өмнөговь аймгийн нийтийн номын сангийн 80 жилийн ойд зориулсан “Өмнөговь- орон нутгийн ном зүй 1957-2024”-г хэвлүүлэхэд хамтран ажиллав.



“Чингис хаан судлалын ном зүй” бүртгэлийн хүрээнд Чингис хааны холбогдолтой сан хөмрөгөөс 912 ном, 134 гар бичмэл, 530 өгүүлэл, Монголын Дипломатын Академиас 300 ном, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс 303 ном бүхий нийт 2179 ширхэг ном зүйтэй томоохон мэдээллийн сан үүсгэсэн. ШУА-ийн Туух, угсаатны зүйн хүрээлэнгийн Дундад зууны Түүхийн салбарын судлаачдын хянан, зөвлөснөөр хэвлэн гаргахдаа бүх салбарыг биш, зөвхөн түүхийн талаас хамааралтай агуулгын 50-с дээш хувийг эзэлсэн номуудыг авах нь зүйтэй гэж үзээд дээрх мэдээллийг дахин шалгаж, ангилах, номын агуулгын гарчгуудыг нөхөж ном зүйн программд оруулах, зарим чухал номын ашигласан номын ном зүйг оруулах, төвөд хэлээр байгаа номуудыг нэмэх зэрэг илүү нарийн ажлуудыг нэмж хийж байна

Арга хэмжээ: 3.3.3 УИХ-аас эрхлэн хэвлэдэг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг цахимжуулж, метадата үүсгэх ажлыг зохион байгуулна.

УИХ-ын сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагааны хүрээнд номын сангийн "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн цахим мэдээллийн санг түгээх, бүрэн эсэхийг нягтлан үзэж, мэдээлэл солилцох ажлыг цахимаар хийсэн. Цахим номын сангийн нэгдсэн сангаар дамжуулан 1991-2023 онд хэвлэгдсэн "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд цахимаар хайлт хийх боломжийг бүрдүүлж эхэлсэн.



Зорилт: 3.4. Бүх төрлийн номын санг эрдэм шинжилгээ-судалгаа, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

Арга хэмжээ: 3.4.1 Үндэсний номын сан нь бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Нийслэл, аймгийн төв нийтийн номын сангийн 2023 оны үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийж “Ном цом” шагнал олгох журмын дагуу дүгнэн Дорнод аймгийн төв номын санг шалгаруулж, “Ном цом” шагналыг гардуулах ажлыг зохион байгуулав.

Мэргэжил, аргазүйн чиглэлийн хурал, зөвлөгөөн, семинар сургалтыг 17 удаа зохион байгуулж, 1348 номын санч, мэдээллийн ажилтан хамрагдав. Үүнд: “Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын зөвлөгөөн”, “ЕБС-ийн номын санчдын анхдугаар чуулган”, Монголын номын сангуудын консорциумаас зохион байгуулсан “Mongolian library update” улсын XI зөвлөгөөн, БНСУ-ын Чонбукийн их сургуулийн докторант Ч.Хишигсүрэнг урьж “Орчин үеийн номын сангийн үйлчилгээний чиг хандлага: БНСУ-ын жишээн дээр” сэдвээр лекц сургалтууд зохион байгуулсан.

Орон нутагт очиж Дундговь, Өмнөговь, Увс, Дорноговь, Баянхонгор, Дархан-Уул, Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн номын санчдад мэргэжил арга зүйн сургалт хийсэн. “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бие бүрэлдэхүүн, Хэвлэл, мэдээллийн үндэсний сүлжээний гишүүн байгууллага зэрэг байгууллага хамт олонд болон МУҮНС-гийн албан хаагчдад зориулсан “Цахим ур чадвар” сургалтаар “Өөрт тулгарсан техникийн асуудлыг шийдвэрлэх, хэрэглээндээ тохирсон технологийн шийдлийг олох нь”, “Цахим контент бүтээх ур чадвар, түүнийг бэлтгэх арга зүй” сэдвээр 5 удаагийн сургалт хичээл бэлдэж цуврал сургалтад хамруулсан. Үүнд:

1. Гадаад хэргийн яам, ХБҮЗ-өөс хамтран зохион байгуулсан гадаадад амьдарч буй Монгол хэлний багш нарт “Монгол ном бичгийн өв, соёл” сэдвийн дор сургалт хийж, мэдээлэл өгөв. 20 гаруй багш хамрагдсан.



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



**ГАДААД ДАХЬ МОНГОЛ ХЭЛНИЙ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН
МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЦУВРАЛ СУРГАЛТ-2**

2024.01.27 Бямба гараг. 20:00-22:00 (GMT+8. УБ цагаар)



Сэдэв № 9:
МОНГОЛЧУУДЫН НОМЫН ҮНЭТ ӨВӨӨС

Сургагч багш: Вандангийн Түвшинтогтох
(Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч, магистр)

Зохион байгуулагч: Монгол Улсын Гадаад харилцааны яам
Хэлний бодлогын үндэсний зөвлөл



Meeting ID: 832 4136 9778
Pass code: 2024
Чиглүүлэгч: М.Гэрэлсүрэн

2. “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бие бүрэлдэхүүнд номын сангийн үйлчилгээ үзүүлэх онцлог, мэдээллийн технологи, автоматжуулалт” сэдвийн дор зохион байгуулж байна. “Цахим номын сангийн тухай ойлголт”, “Цахим номын сангийн ашиглалт”, “Номын сангийн каталог, түүний зохион байгуулалт”, “Номын сангийн фондын тухай ойлголт, фондын зохион

байгуулалт" сэдвийн дор лекц, сургалт өгч ажиллав. Сургалтад Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 50 гаруй номын санч- мэдээллийн ажилтан хамрагдсан. Сургалтыг Батлан хамгаалах их сургуулийн номын санд зохион байгуулав.

3. "Нэгдсэн цахим систем"-ийн сургалтыг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр 21 аймаг, нийслэлийн номын сангийн 230 гаруй номын санчдад хүргэж ажиллалаа.



4. Дундговь аймгийн ЗДТГ, С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын сан, "Төгөлдөр Буяннэмэх сан"-аас хамтран 2024 оны 09 сарын 20, 21-ны өдрүүдэд Мандалговь хотноо зохион байгуулсан "Ухаалаг утаснаас- уншлагын цаг руу" уншигч хүүхдүүдийн чуулга уулзалтад арга зүйчид оролцов. Уулзалтад сум тус бүрээс С.Буяннэмэх, Д.Нацагдорж тэмдэгтэн, 200 гаруй тэргүүний уншигч хүрэлцэн ирсэн бөгөөд уншлага, хүүхэд хамгааллын сургалтад

хамрагдлаа. Энэ үеэр нийтийн болон сумдын номын санчдад зориулсан сургалт болж "Нийгмийн орон зай- суралцахуйн орчин", "Номын сангийн үйлчилгээний чиг хандлага", "Соёл олон нийтийн ажлын шинэлэг хэлбэрүүд", "Зөөлөн ур чадвар" сэдвээр мэдээлэл өгч, хичээл заалаа.



5. "Төв болон хойд бүсийн аймгуудын номын санчдын зөвлөгөөн"-д хэлтсийн дарга Т.Хайдав, арга зүйч В.Түвшинтогтох, Б.Сарандэлгэр, ном зүйч Т.Наранчимэг нар оролцож, "Нэгдсэн цахим систем ба мэдээллийн сангууд", "СОНА-ын шинэлэг хэлбэрүүд" зэрэг сэдвээр сургалт зохион явууллаа. 100 гаруй номын санч хамрагдав.



6. "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийн хүрээнд Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газар, Өвөрхангай аймгийн төв номын сангаас зохион байгуулсан "Номын санч- мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах, арга зүйгээр хангах цахим сургалт"-ад "Цахим номын санг орон нутагт хөгжүүлэх боломж", "Орон нутгийн ном зүй ба цахим ном зүй" зэрэг сэдвээр мэдээлэл өгч, сургалт хийлээ. Сургалтад аймгийн нийтийн номын сан болон ерөнхий боловсролын сургуулийн номын санчид хамрагдлаа. 40 гаруй номын санч хамрагдав.



7. ЕБС-ийн номын сангийн холбооноос зохион байгуулсан *“ЕБС-ийн номын санчдын анхдугаар чуулган”*-ыг зохион байгуулахад оролцож, арга зүйгээр хангав. 270 гаруй номын санч хамрагдав.
8. Соёлын яамнаас зарласан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сарын хүрээнд Монголын номын сангуудын консорциумаас зохион байгуулсан *“Mongolian library update”* улсын XI зөвлөгөөнийг зохион байгуулахад оролцож, арга зүйгээр хангав. 100 гаруй номын санч хамрагдав.
9. Номын сангийн албан хаагчдад зориулсан *“Цахим ур чадвар”* сургалтаар *“Өөрт тулгарсан техникийн асуудлыг шийдвэрлэх, хэрэглээндээ тохирсон технологийн шийдлийг олох нь”*, *“Цахим контент бүтээх ур чадвар, түүнийг бэлтгэх арга зүй”* сэдвээр хичээл бэлдэж заав. 40 гаруй номын санч хамрагдав.
10. Хэвлэл, мэдээллийн үндэсний сүлжээний гишүүдийн 8 сарын уулзалтыг номын санд зохион байгуулав. Нийт 13 хүн оролцов. Энэ үеэр *“Номын сангийн мэдээллийн боловсрол”* сэдвээр мэдээлэл бэлтгэж, танилцуулав.



11. Олон Улсын Улаанбаатар Их Сургуулийн номын сангаас *“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”*-ийн хүрээнд зохион байгуулсан уулзалт ярилцлага 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр болж тус уулзалтад 100 гаруй оюутан хамрагдав. Мөн сургуулийн номын сантай танилцан, зөвлөгөө өгч ажилласан.
12. Өмнөговь аймгийн номын санчдад *“Нэгдсэн цахим систем”*-ийн талаарх давтан сургалтыг өгч ажиллав. 10 номын санч хамрагдав.
13. СУИС-ийн Соёлын сургуулийн номын сангийн ангийн оюутнууд дунд зохион байгуулсан *“Оюутны мэргэжлийн ур чадварын уралдаан”*-д арга зүйчид шүүгчээр оролцов. 80 гаруй оюутан хамрагдав.
14. Номын сангийн нүүдэл дуусаж, *шинэ систем ашиглаж эхлэхтэй холбоотойгоор номын санчдад инженерийн хамт танхимаар сургалт* өгч ажиллав. Сургалтыг төв болон салбар номын сангийн албан хаагчдад өгсөн. 30 гаруй номын санч хамрагдав.
15. Шинэ байранд орж, шинэ хэлбэрээр үйлчилгээ хүргэхтэй холбогдуулж БНСУ-ын Чонбукийн их сургуулийн докторант Ч.Хишигсүрэнг урьж *“Орчин үеийн номын сангийн үйлчилгээний чиг хандлага: БНСУ-ын жишээн дээр”* сэдвээр лекц авлаа. 25 номын санч хамрагдав.



16. Дорноговь, Баянхонгор, Дархан-Уул, Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн номын санчдад(50) номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, цахим системийн талаар сургалт өгч, номын сангийн хөгжил, хэтийн төлөвийн талаар санал солилцов.
17. Орон даяар нэгдсэн систем нэвтэрч байгаатай уялдан каталогжуулах гарын авлага хийх шаардлагатай байгаа тул **"Каталогч ном зүйчдийн хэлэлцүүлэг"** зохион байгуулж, 26 номын санч, мэдээллийн ажилтныг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийтийн болон их дээд сургуулийн номын сангийн MARC21 формат дээр ажилладаг туршлагатай ном зүйч, каталогчид оролцсон бөгөөд MARC21 форматын каталогжуулах ажил дээр тулгарч буй асуудлууд, цаашид анхаарах асуудлуудыг хөндсөн өндөр ач холбогдолтой хэлэлцүүлэг болсон. Тус хэлэлцүүлгийн үр дүнд 6 ажлын хэсэг байгуулж, MARC21 форматыг илүү нарийн судлан "MARC21 форматын хялбаршуулсан монгол хэл дээрх гарын авлага" боловсруулах ажлын төлөвлөгөө гаргалаа.



Арга хэмжээ: 3.4.2 Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн дагуу эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

МУҮНС, ШУА-ийн ТУЗХ-гийн хооронд 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан 02/03 дугаар Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Захирлын 2023.12.12-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар ШУА-ийн ТУЗХ-тэй хамтран Монголын ноёд тайж нарын гэрийн үеийн бичмэлүүдэд эрдэм шинжилгээний боловсруулалт хийн судалгааны эргэлтэд оруулж, каталог хэвлэх, үзэсгэлэн гаргах, нэвтрүүлэг, видео контент хийхээр ажиллаж байна.

Сан хөмрөгт хадгалагдаж буй гэрийн үеийн бичмэлүүдийг бүрэн бүртгэн тодорхойлж, цахимд хөрвүүлэх, галиглах ажлыг хийж дууссан, 2024 онд багтаан Түшээт хан аймгийн гэрийн үеийн бичмэлийг хэвлэлтэд шилжүүлэх ба ажлын санхүүжилт Монгол судлалын Үндэсний зөвлөлөөс шийдэгдээд байна. Монгол Улсаас ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн олон улсын болон бүсийн баримтат өвийн жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн 10 баримтат өвийн талаар “Дэлхийд данслагдсан монгол өв” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

Судалгааны тайлбартай 3 бүтээл хэвлүүлсэн: “Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй донтрын дээжис” ном, “Монгол Улсын Үндэсний Номын сангийн баримтын эмхэтгэл II, “Монгол Улсын Үндэсний Номын санд дахь монгол бичгийн өв” номууд.

МУҮНС дахь монгол бичгийн өв

МУҮНС-д хадгалагдаж буй



Донтрын дээжис

Илтгэл өгүүлэл-13. Үүнээс: 1. “Соёлын орон зай” ОУЭШХ-д “Хантайшир уулын ар, өврөөс олдсон хоёр өв” сэдвээр илтгэл тавьж, хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн. 2. “Засагт хан аймгийн Эрдэнэ бишрэлт Засагт ханы хошууны түүх, соёл, байгаль” ЭШХ-д “Үндэсний номын санд хадгалагдаж буй Засагт хан аймгийн Эрдэнэ бишрэлт засагт хошуутай холбогдох зарим баримт” сэдвээр илтгэл тавьж, өгүүллийн эмхэтгэлд нийтлэгдсэн. 3. “Дэлхийд данслагдсан монгол өв” ЭШХ-д “Лу.Алтантовчийн судлагдсан байдал” сэдэвт илтгэл хэлэлцүүлэв. 4. Доктор Б.Сайнбилэг Германы Хамбургийн Их Сургуулийн Эх бичгийн соёл судлалын төвд “Монголчуудын модон барын уламжлал ба бүтээж байсан бичиг үсгийн дурсгалууд” сэдвээр илтгэл тавьсан зэргийг онцлох байна.



Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/
 April 26, 2024 · 🌐


Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/-ийн Төвөд хэлт ном судрыг каталогжуулан цахижуулах төслийн ерөнхий зохицуулагч, доктор Б.Сайнбилэг Германы Хамбургийн Их Сургуулийн Эх бичгийн соёл судлалын төвд “Монголчуудын модон барын уламжлал ба бүтээж байсан бичиг үсгийн дурсгалууд” сэдэвт илтгэл танилцуулж, МУҮНС-аас эрхлэн хэвлүүлсэн бүтээлүүдийн дээжээс зохион байгуулагчдад гардуулав.

- Монгол Улсаас ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн олон улсын болон бүсийн баримтат өвийн жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн 10 баримтат өвийн Монгол Улсын тусгаар тогтнол, олон улсын түүх, соёлын хөгжилд өнгөрсөнд, одоо, ирээдүйд гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлыг судлах, дотоод гадаадын судлаач эрдэмтдэд таниулах, шинжлэх ухааны эргэлтэд оруулах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, олон нийтэд тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор “Дэлхийд данслагдсан монгол өв” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав. Нийт 13 илтгэл хэлэлцэгдэв. Илтгэлийг э/ш/х-ын эмхэтгэл болгон англи, монгол хэлээр хэвлүүлэв.

- СУИС, ОХУ-ын Дорнод Сибирийн Соёлын дээд сургуулийн хамтран зохион байгуулдаг “Соёлын орон зай” ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд “Хантайшир уулын ар, өврөөс олдсон хоёр өв” сэдвээр илтгэл уншив. Уг илтгэл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн.

- ШУА-ийн Түүх, угсаатны хүрээлэн, ГАА-ийн Дэлгэр, Тайшир сумын хамтран зохион байгуулсан “Засагт хан аймгийн Эрдэнэ бишрэлт Засагт ханы хошууны түүх, соёл, байгаль” эрдэм шинжилгээний хуралд “Үндэсний номын санд хадгалагдаж буй Засагт хан аймгийн Эрдэнэ бишрэлт засагт хошуутай холбогдох зарим баримт” сэдвээр илтгэл уншив. Тус илтгэл эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэлд нийтлэгдсэн.

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, МУҮНС хамтран зохион байгуулсан “Дэлхийд данслагдсан монгол өв: ЮНЕСКО-д бүртгэгдсэн өвүүд” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж, үндсэн илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлээ.





Арга хэмжээ: 3.4.3 Үндэсний номын сан нь бусад номын санд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор жил бүр номын санчийн гарын авлага бэлтгэн гаргаж, гурав хүртэлх хувийг үнэ төлбөргүй түгээх ажлыг зохион байгуулна.

Номын санч сэтгүүлийн 2024 оны №1, №2 дугаарыг эрхлэн 100, 100 ширхгийг хэвлүүллээ. №1 дугаарыг “Нэгдсэн цахим систем”-ийг голлон 13, №2 дугаарт ямар нэгэн сэдвийг барилгүй, чөлөөт агуулгын хүрээнд 21, нийт 34 өгүүлэл, нийтлэлийг хэвлүүлэв. Уг өгүүллийн ихэнх хэсгийг номын сангийн албан хаагчдын бичиж, нийтлүүлсэн бөгөөд СУИС, МУИС, МУБИС, АШУҮС, ХүТНС, орон нутгийн номын сангийн төлөөллүүд судалгаа, шинжилгээний өгүүлэл, нийтлэлээ хэвлүүллээ. 2. Номын санч сэтгүүлийг цахим номын сангийн <https://e-lib.cis.mn/> сайт, гар утасны аппликейшнд уншигдах хэлбэрт оруулж, уншиж, судлах хүртээмжийг нэмэгдүүллээ.

Зорилт: 3.5. Нийгмийг соён гэгээрүүлэхэд номын сангийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, номтой нөхөрлөх соёл уламжлалыг таниулах, сан хөмрөгөөр дамжуулан олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.

Арга хэмжээ: 3.5.1 Уншигч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ном хэвлэлээр танхимаар болон бусад номын сангийн үйлчилгээг чанартай үзүүлнэ.



Шинээр үнэмлэх нээлгэж бүртгүүлсэн нийт 11267 уншигч байгаагийн Төв байранд 2668, Салбар номын санд 8599 үүнээс хүүхэд 2144, уншигчийн үнэмлэх сэргээх, сунгалт хийлгэсэн уншигч 973 бүртгүүлсэн байна. Номын сангийн 2024 оны байнгын уншигчийн тоо 12240, нийт 12 уншлагын танхимаар 42197 ирцэд 49460 ширхэг ном олгож уншуулж, үйлчилсэн.

Шинэ номын сан ашиглалтад орсноор шинэ уншигчийн тоо 2,1 дахин, байнгын уншигчийн тоо 2 дахин, ирц буюу уншлагын танхимаар үйлчлүүлэгчдийн тоо 1,3 дахин өссөн.


Судалгааг 44 удаа уншигч хэрэглэгчдээс цахимаар QR кодоор авсан, судалгаанд хамрагдсан - 397 уншигч, байгууллагын цахим хуудасны чатаар 413 хүнд хариулт өгч тогтмол ажиллан, иргэдээс ирсэн санал хүсэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Цахимаар уншуулсан: 98 уншигчид 1854 гар бичмэлийг, 20 уншигчид 37 цахим номыг уншуулж үйлчилсэн.

Уншигч бүртгэл:



Ирц, ном олголт:





Арга хэмжээ: 3.5.2 Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг цахим болон хуулбар хэлбэрээр уншуулна.

Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимд 98 уншигчид 1854 гар бичмэл гар бичмэл цахимаар уншуулж үйлчилсэн.

Арга хэмжээ: 3.5.3 Сан хөмрөгийн зохион байгуулалтыг сайжруулах, бүрэн бүтэн байдлыг ханган сэлбэн засаж, ном хэвлэлээр үйлчлэх, номын сангийн үйлчилгээг боловсронгуй, чанартай үзүүлнэ.

Нийт 5 сан хөмрөгийн ном, хэвлэлээс шинэ байр руу нүүлгэн шилжүүлэх номын жагсаалт, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу сан хөмрөгчөөс тоолж, бүртгэн хайрцаглах, зөөж тээвэрлэсний дараа шинээр байгуулагдсан сан хөмрөг, уншлагын танхимуудад ном, хэвлэлийг хүлээлгэн өгч тоолох, бүртгэх ажилд хяналт тавьж ажилласан.

Шинэ номын сан руу шилжүүлсэн 534000 номын тайлан нүүлгэн шилжүүлэх ажлын тайланд тусгасан болно. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд сан хөмрөгүүдэд 103200 номыг шинээр болон буцаан байрлуулсан, үүнээс уншлага, үзэсгэлэн, солилцоогоор гарсан ном – 69800 ш. Цэгцэлсэн ном - 534000 ш. Сэлбэн зассан ном:

Уншлагад элэгдсэн 1354 ном, 162 нэгж сонин, 300 нэгж, 1180 ш сэтгүүл, 80 албан баримт, Нийт 1896 /элэгдэж урагдсан 1396 хуудас 1990 нүүрийг хувилж бүтэн болгож, 51 хуудсыг нөхөж оёсон/ ном хэвлэл. Нэгж болгож хавтасласан 542 сонин сэтгүүл, ариутгасан ном-280425 ш, Хятад 35000 ном хэвлэлийн байрын шалгалт хийж эмхэлж цэгцэлж, 2100 номын хавтасны зураг сканердаж, каталогийн бүртгэлд редакц хийсэн.

Төвөд сан хөмрөгийн цэгцэлж байрлуулсан -20174 ном, каталогт орсон номыг дансалсан-8049, монгол зохиолчтой бүтээлээс каталогт 797 ш номыг оруулж, сан хөмрөгийн зохион байгуулалтыг сайжруулах, бүрэн бүтэн байдлыг ханган, ном хэвлэлээр үйлчлэх, номын сангийн үйлчилгээг боловсронгуй, чанартай үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажилласан.

Арга хэмжээ: 3.5.4 Нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ном хэвлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах соёл танин мэдэхүйн ажил, арга хэмжээг зохион байгуулна.

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд 30 үзэсгэлэн, шинэ номын, зохиолч уран бүтээлчдийн тэгш ой 80-аас дээш ой тохиож буй 12 зохиолчийн номын үзэсгэлэн, шинэ номын нээлт, номын тухай лекц, хэлэлцүүлэг 15, нийт 55 удаа 4069 ширхэг ном, тогтмол хэвлэлээр гаргаж цахим болон танхимаар эрдэмтэн судлаач, уншигч, хэрэглэгчид сурталчилсан.

ҮНДЭСНИЙ НОМЫН САН - ТАНИЛЦАХ АЯЛАЛ

ОНЦЛОХ АЖИЛ - УУХ **8600 БАГШ, СУРАГЧ, ОЮУТАН, УНШИГЧ**

Шинэ номын нээлт – 12 удаа

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР
Өдөр бүр өдөр өдөр бүр

Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн, жүжиг, киноны зохиолч **Х.ЗАНДРААБАЙДИЙН** мэндэлсний 90 жилийн ойд зориулсан **"БАДМААРСАН ЗУЛ"** хорөг, дурсамжийн номын нээлт

2024/11/11 11:00 цагт

МҮҮНС Төв байрны Уншигчийн үйлдвэр

МОНГОЛ УЛСЫН ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРЫН ӨНӨӨДРИЙГ БИДЭНД АВЧИРЧ 1973-1982 ОНЫ ХООРОНД БИМАУ-ЫН ТЭЭВРИЙН ЯАМНЫ САЙДААР АЖИЛЛАСАН ТӨР НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН НЭРТ ДУУН ХӨРВҮҮЛЭГЧ ЗОХИОЛЧ БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ **СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ**

"Батмөнхийн Энэбиш 90"
Дурсамж уулзалт

Зохион байгуулагч:
Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрсөд



Сэдэвчилсэн номын үзэсгэлэн, гар зураг, эссе, фото зураг, номын тэмдэглэлийн үзэсгэлэн



Арга хэмжээ: 3.5.5 Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2023 арга хэмжээг 2 удаа зохион байгуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлиг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалтын дагуу жил бүрийн 9 дүгээр сарын Бямба, Ням гаргийг “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” болгон тэмдэглэж байна.

Өнөө жил Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр 2024 оныг “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласны дагуу “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” намрын үйл ажиллагааг 2024 оны 9 дүгээр сарын 13-22-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье” уриатайгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулав.

Тус тэмдэглэлт өдрүүдийн нээлтийн үйл ажиллагаа нийслэл Улаанбаатар хотноо Д.Сүхбаатарын талбайд 9 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд 36 дахь

удаагийн “Номын баяр”-аар эхэлж, нийтийг хамарсан үзэсгэлэн, уралдаан, өдөрлөг, уулзалт зэрэг үндэсний бичиг соёлоо сурталчилсан, ном унших идэвх санаачилгыг өрнүүлсэн арга хэмжээг улс даяар зохион байгуулав.

Монгол Улсын Үндэсний Номын Сангаас “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

I. Д.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ ДАХЬ НОМЫН БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

<https://www.facebook.com/share/p/SjdLVKYdeDWdqyBw/?mibextid=oFDknk>

Монгол Улсын Үндэсний номын сан Д.Сүхбаатарын талбайд 2024.09.13-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан номын баярт өөрийн эрхлэн хэвлүүлсэн ном бүтээлийн худалдаа болон номын сангийн шинэ барилгын бүтээн байгуулалтын гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, уншигч, олон нийтэд Үндэсний Номын Сангийн болон Төв /хуучин байр/, Салбар /шинэ байр/ номын санд явуулж буй үйл ажиллагааг танилцуулж ажиллав. Үндэсний Номын Сангийн асраар 1000 гаруй хүн зочилж, номын баярын үйл ажиллагаанд хамрагдсан байна.

II. ҮНДЭСНИЙ НОМЫН САН ДАХЬ НОМЫН БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Номын танилцуулга, ярилцлага

<https://www.facebook.com/share/p/7YG2iGyacSSiSg3d/?mibextid=oFDknk>

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийн хүрээнд 2024.09.12-ны өдөр Монгол Улсын Үндэсний Номын Сангийн салбар шинэ байрын үзэсгэлэнгийн танхимд Берлиний Хумболтын Их сургуулийн Монгол судлалын салбарын эрхлэгч, доктор Алтангэрэлийн Ганчимэгийн Монгол хэл, бичгийн салбарын эрдэмтэн, судлаачидтай хамтран гадаад оюутан залуучууд, залуу судлаачдад зориулан бичсэн үндэсний бичиг сурах "Classical Mongolian. A Textbook for Students, Scholars, and Everyone Interested in Mongolian" номын танилцуулга, ярилцлагыг зохион байгуулж, МУИС, СУИС, ИИС-ийн эрдэмтэн багш, оюутан залуучууд хүрэлцэн ирж оролцов.

2. Номын нээлт

<https://www.facebook.com/share/p/tDvZ3xzmFLabumL8/?mibextid=oFDknk>

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд Үндэсний Номын Сангийн Салбар номын сангийн Үзэсгэлэнгийн танхимд Франц хэлээр хэвлэгдсэн “Орчин үеийн уран зохиолын дээжис” өгүүллэгийн номын нээлт 2024.09.14-ний өдөр болов. Орчуулагч Тулгаагийн Алтанцэцэг Монголын орчин үеийн уран зохиолын төлөөлөл болсон 21 зохиолчийн өгүүллэгийг франц хэлнээ орчуулан анатолог болгон хэвлүүлжээ. Франц хэлээр хэвлэгдсэн “Орчин үеийн уран зохиолын дээжис” өгүүллэгийн номын нээлтэд орчуулагч Т.Алтанцэцэг, Кубын Элчин сайд Хорхе Феррер Родригес, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн захирал Б.Ичинхорлоо, Монгол-Францын найрамдлын нийгэмлэг, зохиолчдын төлөөлөл оролцов.

3. ОХУ-ын номын сангийн төлөөлөгчид зочлов.

<https://www.facebook.com/share/p/B7dm6R6Ri4GTAQi6/?mibextid=oFDknk>

<https://www.facebook.com/share/p/3pKwzBdXYAYxRhRA/?mibextid=oFDknk>

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд ОХУ-ын А.С.Пушкины нэрэмжит Өвөр Байгалийн бүс нутаг дахь шинжлэх ухаан, олон нийтийн номын сангийн захирал Сивцова Елена Владимировна, ном зүйч Тарасов Александр Петрович, зөвлөх мэргэжилтэн Тарасова Эльза Евгеньевна нар 2024.09.19-ний

өдөр Монгол Улсын Үндэсний номын санд зочилж, шинэ болон хуучин байртай танилцав. Зочид төлөөлөгчдийг Үндэсний номын сангийн Ерөнхий номын санч Т.Баярлах, МАЗЭШХ-ийн дарга Т.Хайдав, НББСХ-ийн дарга Г.Гүнжинлхам, Ном зүйч Г.Баяртуяа нар хүлээн авч уулзаж, мэргэжлийн чиглэлээр хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцож, номын сангийнхаа үйл ажиллагааг танилцууллаа.

4. Цахим сургалт

<https://www.facebook.com/share/p/eASgqKYS7HGzBSMQ/?mibextid=oFDknk>

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийн хүрээнд Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газар, Өвөрхангай аймгийн төв номын сангаас 2024.09.20-ны өдөр зохион байгуулсан "Номын санч-мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах, арга зүйгээр хангах цахим сургалт"-д Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч В.Түвшинтогтох, Б.Сарандэлгэр нар "Цахим номын санг орон нутагт хөгжүүлэх боломж", "Орон нутгийн ном зүй ба цахим ном зүй" сэдвээр мэдээлэл өгч, сургалт хийв. Сургалтад аймгийн нийтийн номын сан болон ерөнхий боловсролын сургуулийн номын санчид хамрагдлаа.

5. Орон нутаг дахь сургалт

<https://www.facebook.com/share/p/kUnPpK3qnJizj7gt/?mibextid=oFDknk>

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд Дундговь аймгийн ЗДТГ, С.Буяннэмэхийн нэрэмжит төв номын сан, "Төгөлдөр Буяннэмэх сан"-аас хамтран зохион байгуулсан "Ухаалаг утаснаас-Уншлагын цаг руу" уншигч хүүхдүүдийн чуулга уулзалт 2024 оны 9 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Мандалговь хотноо зохион байгуулагдаж, энэ үеэр болсон нийтийн болон сумдын номын санчдад зориулсан сургалтад Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч В.Түвшинтогтох, Б.Сарандэлгэр нар "Нийгмийн орон зай- суралцахуйн орчин", "Номын сангийн үйлчилгээний чиг хандлага", "Үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага", "Соёл олон нийтийн ажлын шинэлэг хэлбэрүүд", "Орон нутгийн ном зүй-Цахим номын сан", "Зөөлөн ур чадвар" сэдвээр мэдээлэл өгч, хичээл заав. Уулзалтад сум тус бүрээс С.Буяннэмэх, Д.Нацагдорж тэмдэгтэн, 200 гаруй тэргүүний уншигч хүрэлцэн ирсэн бөгөөд уншлага, хүүхэд хамгааллын сургалтад хамрагдлаа.

6. Мэргэжил арга зүйн зөвлөгөөний хүрээнд:

<https://www.facebook.com/share/p/irdWHhheB9Syiuqy/?mibextid=oFDknk>

Олон Улсын Улаанбаатар Их Сургуулийн номын сангаас "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийн хүрээнд зохион байгуулсан ээлжит уулзалт ярилцлага 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр болж, уулзалтад залуу зохиолч М.Пүрэвмаа, Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч Б.Сарандэлгэр нар уригдан оролцож ном, соёлын талаар халуун ярилцлага өрнүүлэв. Уулзалтын төгсгөлд арга зүйч Б.Сарандэлгэр тус сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

7. Номын сантай танилцах аялал

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ байр салбар номын сангийн үйл ажиллагаатай ЕБС-ийн сурагчид, оюутан залуусыг танилцуулах ажлыг зохион байгуулж ажиллав.

2024.09.12-ны өдөр Идэр дээд сургуулийн 25 оюутан;

2024.09.17-ны өдөр Монтэ Роза ЕБС-ийн 80 сурагч;

2024.09.20-ны өдөр Монтэ Роза ЕБС-ийн 80 сурагч;



2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Зардал хуваарилж, ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Номын сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 9 дүгээр зүйлийн 9.3.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Ой тэмдэглэх тухай" 394 дүгээр тогтоол, Соёлын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/120 дугаар тушаал, Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.2, 3 дугаар зүйлийн 3.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголчуудын бичиг соёлын түүхэнд холбогдох үндэсний бичгээр бичиж үндэсэн соёлын өвийн дурсгал болох "Чингисийн чулууны бичиг", "Дуутын хар чулууны бичиг"-ийн тухсан ойн хүрээнд "Үндэсний бичиг, соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэн зохион байгуулах, Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд үндэсний бичгийг олон нийтэд сурталчлан таниулах, түүгээр дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсуугай.

2. Үндэсний бичиг үсгийн баярын үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг холбогдох төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Э.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалт, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах, тайланг 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор гаргаж захиргааны зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Баярлах)-д даалгасугай.



ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО

Үндэсний номын сангийн Захирлын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны
өдрийн А/18 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт

ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ, ДУУТЫН ХАР ЧУЛУУНЫ БИЧЭЭСИЙГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Баярлах (Ерөнхий номын санч)

Гишүүд: Б.Тунгалаг (СХХ-ийн дарга)
Б.Цогжаргал (Ном зүйч)
Б.Хүрэлцоож (Төвөд номын сан хөмрөгийн номын санч)
Ч.Бямбажав (Тогтмол хэвлэлийн сан хөмрөгийн номын санч)
Г.Ганчимэг (Архив, бэлтгэл сан хөмрөгийн номын санч)
Б.Отгонтуяа (Сан хөмрөгч)
Ү.Доржоо (Сэргэн засварлагч)
Т.Билэгбаяр (Номын санч мэдээллийн ажилтан)
Т.Өвжин (Төслийн ажилтан)
Д.Гэрэлмаа (Төслийн ажилтан)
М.Золзаяа (Төслийн ажилтан)
С.Хонгорзул (Төслийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: С.Чулуунпүрэв (Маркетингийн менежер)

---o0o---

Үндэсний номын сангийн Захирлын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны
өдрийн А/18 дугаар тушаалын
Хоёрдугаар хавсралт

ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ, ДУУТЫН ХАР ЧУЛУУНЫ БИЧЭЭСИЙГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хугацаа: 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Байршил	Хариуцагч
1.	Үзэсгэлэн, нээлтийн арга хэмжээ: - брандбүүк - постер, анонс - шторк, - цахим танилцуулга	2024.04.15- 2024.04.26	Бэлтгэл ажил	Т.Баярлах С.Чулуунпүрэв Б.Цогжаргал Т.Билэгбаяр Б.Хүрэлцоож Ү.Доржоо
2.	"Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээний хөтөлбөр, сценари	2024.04.10- 2024.05.01	МҮҮНС-ийн салбар-Нийтийн номын сангийн шинэ барилгын үзэсгэлэнгийн танхим	Т.Баярлах С.Чулуунпүрэв Б.Тунгалаг Ү.Доржоо
3.	"Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэнгийн жагсаалт гаргах, дэглэх, тайлбар хийх	2024.04.10- 2024.04.26	МҮҮНС-ийн салбар-Нийтийн номын сангийн шинэ барилгын үзэсгэлэнгийн танхим	Б.Хүрэлцоож Ч.Бямбажав Г.Ганчимэг Б.Отгонтуяа Ү.Доржоо Т.Өвжин Д.Гэрэлмаа М.Золзаяа С.Хонгорзул
4.	"Монгол бичгийн цахим бичвэр" улсын уралдаан зохион байгуулах	2024.05.08	Цахимаар	Б.Отгонтуяа Ү.Доржоо Д.Гэрэлмаа М.Золзаяа С.Хонгорзул
5.	"Үндэсний бичгийн дурсгал" цуврал подкаст	2024.05.15	Цахимаар	ЭХ, МАЭЭШХ


---o0o---

2024.09.20-ны өдөр СУИС-ийн 50 сурагч тус тус танилцах аялалд хамрагджээ.

Арга хэмжээ: 3.5.6 "Үндэсний бичиг үсгийн баяр-2024" арга хэмжээ зохион байгуулна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Соёлын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/120 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлаглагдсан ажлын хэсэг, төлөвлөгөөний дагуу 5 арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.



Нээлтийн арга хэмжээ: Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Үнэт ховор номын музей /Төв байр-Хуучин барилга/-д 2024 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 11:40 цагт Үндэсний бичиг үсгийн баярын нээлтийн ёслол боллоо. Үндэсний бичиг үсгийн баярын нээлтийн ёслолын үеэр “ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв” бичиг соёлын үзэсгэлэн, “Үндэсний бичиг, соёлын гайхамшигт дурсгалууд” үзэсгэлэнг олон нийтийн хүртээл болгож, "Монгол Улсын Үндэсний Номын Сан дахь монгол бичгийн өв" номын нээлтийг хийв.





Мөн Монгол Улсын Их Сургуулийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ардын багш Д.Чойжалсүрэнгийн нэрэмжит “Монгол бичгийн улсын 22 дахь удаагийн олимпиад”-ын шилдгүүдэд шагналыг гардууллаа.

Үндэсний Номын Сангийн Төв байрны гаднах Номын өргөөнд монголчуудын ном бичгийн уламжлалыг харуулсан хэвлэмэл үзэсгэлэн, тус номын сангаас эрхлэн хэвлүүлсэн ном хэвлэл, брэнд бүтээгдэхүүний худалдаа гаргаад байгаа юм.



Үндэсний бичиг үсгийн баярыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногт улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд өнөө жил 21 дэх удаагаа ёслон тэмдэглэж байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 394 дүгээр тогтоолоор монгол бичгийн анхны дурсгал болох Чингисийн чулууны бичгийн 800 жил, Цогт хунтайжийн хадны бичээс буюу “Дуутын хар чулууны бичээс”-ний 400 жилийн ойг энэ онд тэмдэглэн өнгөрүүлэхээр 2024 оныг “Үндэсний бичиг соёлын жил” болгон зарлаад буй билээ.

Монгол Улсаас ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн баримтат өвийн жагсаалтад бүртгэлтэй 7 дурсгал бий бөгөөд эдгээрийг бүгдийг нь Монгол Улсын Үндэсний Номын Сангаас бүртгүүлсэн байдгаас 6 нь тус номын сангийн сан хөмрөгт хадгалагддаг юм. Үндэсний бичиг үсгийн баярт зориулсан үзэсгэлэнд ЮНЕСКО-д

бүртгэлтэй эдгээр баримтат өвүүдийг тусгайлан дэлгэж, олон нийтэд толилуулж байна.

Үндэсний бичиг соёлын баярын хөтөлбөр:

2024.05.03-Үндэсний бичиг үсгийн баярын нээлт

2024.05.03-"ЮНЕСКО-д бүртгэлтэй монгол өв" бичиг соёлын үзэсгэлэн

2024.05.08-"Монгол бичгийн цахим бичвэр-III" улсын уралдаан

2024.05.09-"Үндэсний бичиг, соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэн

2024.05.28-"Бичиг соёл-2024" уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэнг тус тус зохион байгуулан ажилласан.




Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ ...
May 15 at 8:36 AM · 🌐

МҮОНТ-ийн "Өглөө" хөтөлбөрөөс манай номын санд гарч буй "Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэнгээс бэлтгэсэн сурвалжилгыг хүргэж байна.

<https://youtu.be/n1yMxm5kw7E>

"Үндэсний бичиг соёлын гайхамшигт дурсгалууд" үзэсгэлэн энэ 5 дугаар сарыг дуустал үргэлжлэх ба энэ хугацаанд Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Үнэт ховор номын музей олон нийтэд үнэгүй үйлчилнэ.



2. "МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭР" УЛСЫН УРАЛДААН⁴ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Монгол Улсын Үндэсний Номын Сангаас "Монгол бичгийн цахим бичвэр-III" улсын уралдааныг зохион байгууллаа.

Монгол хэлний тухай хуулийн дагуу 2025 оноос Монгол Улсын төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээд албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. Албан хэргийг үндэсний бичгээр хөтлөн явуулах үндэс нь цахим бичвэр боловсруулах чадвартай мэргэжилтэн бэлтгэх явдал юм.

Иймд тус улсын уралдаанаар дамжуулан монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах чадавхтай мэргэжилтнүүдийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхийг зорьсон болно.

Уралдааныг:

1. Юникодын бус фонт - Мэргэжлийн ангилал

2. Юникодын бус фонт - Мэргэжлийн бус ангилал

3. Юникодын фонт - Мэргэжлийн ангилал

4. Юникодын фонт - Мэргэжлийн бус ангиллаар 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдөр цахимаар зохион байгуулав.

⁴ Уралдааны зарлал <https://www.facebook.com/share/p/yHtbcQUvnjTZ72Fr/?mibextid=oFDknk>

Уралдаанд <https://shorturl.at/yzJW5> холбоосоор 118 оролцогч бүртгүүлж оролцоноос 4 ангиллын эхний 4 байрт шалгарсан⁵ шилдэг 16 оролцогчид⁶ 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр шагналыг гардуулсан⁷ юм⁸.

Улсын уралдааны төрөл тус бүрийн шилдэг 4 оролцогчоос богино хэмжээний яриа авч, номын сангийн олон нийтийн сүлжээний цахим хуудсанд 4 удаагийн Reel бэлтгэн хүргэсэн нь 30 гаруй мянган удаа тоглогдсон байна.

Өнөө жилийн "Монгол бичгийн цахим бичвэр" улсын уралдаанд оролцогчдын 70 орчим хувь нь хөдөө, орон нутгаас оролцогчид байснаараа онцлог байсан төдийгүй шалгарсан шилдэг оролцогчдын тал орчим хувь нь мөн орон нутгийн оролцогчид байв.

"Монгол бичгийн цахим бичвэр-III" улсын уралдаанаас **ОНЦЛОХ ОРОЛЦОГЧИД:**

1. БАЯНМӨНХИЙН МАРАЛ /Монгол-Оросын хамтарсан 3 дугаар ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагч/

2024 он-Гутгаар байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилал/;

2023 он-Шилдэг 10 /Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилал/;

2022 он-Гутгаар байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилал/.

2. ПҮРЭВСҮРЭНГИЙН НЯМСҮРЭН /Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн Архив, бичиг хэргийн ажилтан/

2024 он - Дэд байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилал/;

2024 он - Дэд байр /Юникодын фонтын Мэргэжлийн бус ангилал/;

2023 он - Гутгаар байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилал/;

2023 он - Шилдэг 10 /Юникодын фонтын Мэргэжлийн бус ангилал/;

3. ТҮМЭНИЙ МӨНХНЯМ /Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Төслийн ажилтан/

2024 он - Тусгай байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн ангилал/;

2024 он - Тусгай байр /Юникодын фонтын Мэргэжлийн ангилал/;

4. ГАЛБАДРАХЫН НОМИНЖИН /МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн Бага ангийн багшийн 1 дүгээр курсийн оюутан/ Ховд аймгаасаа зорин ирж, шагналаа гардан авав.

Б.Номинжиныг бэлтгэсэн багш Г.Нямдаваа 2023 онд тус уралдаанд МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн Бага ангийн багшийн 4 дүгээр курсийн оюутан Ц.Содгэрэл, Э.Даваажаргал нарыг бэлтгэн оролцуулж, Ц.Содгэрэл хоёр төрөлд тэргүүн, дэд байр, Э.Даваажаргал нэг төрөлд дэд байрыг эзэлснээр мөн Үндэсний бичиг үсгийн баярын нээлтийн ёслолд Ховд аймгаас мөн хүрэлцэн ирж, шагналаа гардан авч байсан юм.

5. НЯМААГИЙН ЭНХЧИМЭГ /Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн эрдмийн хүрээлэнгийн Монгол бичгийн багш/

2024 он - Гутгаар байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн ангилал/;

2023, 2022 он - Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн эрдмийн хүрээлэнгийн Сургалтын менежер Ө.Отгонцэрэн Юникодын бус фонтын Мэргэжлийн бус ангилалд жил дараалан тэргүүн байр эзэлж байв.

⁵ Уралдааны дүнг зарласан нийтлэл

<https://www.facebook.com/share/p/9x8DmRL2rRBLy6zK/?mibextid=oFDknk>

⁶ Уралдааны дүнг хавсаргав.

⁷ Уралдааны шилдгүүдэд шагнал гардуулсан нийтлэл

<https://www.facebook.com/share/p/b6CkSKpeVtQPKTWU/?mibextid=oFDknk>

⁸ Шагнал гардуулах ёслолын үеийн гэрэл зургийг хавсаргав.

6. ЛХАСҮРЭНГИЙН ЛХАГВАСҮРЭН /МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хэл шинжлэлийн 4 дүгээр түвшний оюутан/

2024 он - Дэд байр /Юникодын фонтын Мэргэжлийн ангилал/;

2023 он - Шилдэг 10 /Юникодын фонтын Мэргэжлийн ангилал/.

7. БАТЧУЛУУНЫ ЗОЛХИШИГ /“Олонлог академи” ЕБС-ийн Монгол хэл, бичиг, уран зохиолын багш/

2024 он - Дэд байр /Юникодын бус фонтын Мэргэжлийн ангилал/;

2023 он - Шилдэг 10 /Юникодын бус фонтын Мэргэжлийн ангилал/.

8. ШАГЖИЙН ШИРНЭН /“Монгол билиг оюун” ЕБС-ийн Монгол хэл, бичиг, уран зохиолын багш/


2024 он - Гутгаар байр /Юникодын фонтын Мэргэжлийн ангилал/;

2023 он - Шилдэг 10 /Юникодын фонтын Мэргэжлийн ангилал/.



3. “БИЧИГ СОЁЛ 2024” УРАН БИЧЛЭГИЙН ҮЗЭСГЭЛЭН:

Үндэсний бичиг үсгийн баяраар уламжлал болгон 15 дахь жилдээ хамтран зохион байгуулдаг үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Урчуудын эвлэлийн үзэсгэлэнгийн танхимд нээлтээ хийсэн ба 06 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл гарна. Нээлтийн арга хэмжээнд 60 гаруй зочид оролцон, нийт 300 орчим хүн үзэж сонирхсон байна.



Арга хэмжээ: 3.5.7 Эх хэлний өдөр арга хэмжээг зохион байгуулна.

ЭХ ХЭЛНИЙ ДАРХЧУУД" ҮЗЭСГЭЛЭН: Жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдөр тохиодог "Эх хэлний өдөр"-т зориулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Монгол Улсын Үндэсний Номын Сангаас тус номын сангийн Салбар шинэ байрны Үзэсгэлэнгийн танхимд "Эх хэлний дархчууд" сэдэвт эрдэмтэн, зохиолчдын гар бичмэл эх, хөрөг ба гэрэл зураг, ном бүтээлийн дээжээс бүрдсэн үзэсгэлэнг 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн нээлтэд ССАЖЗЯ-ны Газрын дарга Б.Сэргэлэн, МУҮНС-ийн захирал Б.Ичинхорлоо, Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Т.Галсан, "Болор цом"-ын эзэн, яруу найрагч Ш.Лхамноржмаа, Ардын уран зохиолч Ш.Дулмаа агсны охин Уранчимэг нар болон Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн В.Уянга багштай 11в ангийн хамт олон оролцов.

"Эх хэлний дархчууд" үзэсгэлэнгээр Б.Ринчен, Ш.Лувсанвандан, Д.Чойжилсүрэн нарын эрдэмтэн Д.Нацагдорж, Т.Галсан, Ш.Дулмаа, С.Дашдооров,

Ш.Сүрэнжав, Д.Цоодол, П.Бадарч, До.Нямаа, Д.Урианхай, Х.Чилаажав, А.Эрдэнэ-Очир, Л.Мягмарсүрэн, Ш.Лхамноржмаа, А.Лхагва нарын зохиолчийн зохиолын гар бичмэл эх, уран сайхны хөрөг зураг, ном бүтээл болон МЗЭ-ийн зурагчин Бат-Очирын 1990-ээд оны эхээр буулган хадгалсан 380 гаруй хальснаас түүвэрлэсэн 400 гаруй зургийг дижитал хэлбэрт хөрвүүлэн уншигч олны хүртээл болгож, 700 орчим хүүхэд, залуус үзсэн байна.

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02FiwVEWUgMpg6oVRv46HnbzJ5Jpd7B4diZuAKYnKyJ27sDnn5a9ec5dKgW56dTRhbl?_cft_\[0\]=AZVuzclU8hzipewVzMCcph9HdW779wruRn--s8IXjEoBOkzpxPEhFhCvZlouqxx-lbKzYK9PvzqAj58YGjJPZc1TTionFQxpA8JLGK7MGDIOWVwmbjsjHFpVu7QI9KJ4GZN-QxyJoBY1ytCGv11WKv1KLBO1Z0b8Wid_3FWaojNjhwScSNMeTcbwAXLHWGCbM5jf0&_tn_=%2C0%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02FiwVEWUgMpg6oVRv46HnbzJ5Jpd7B4diZuAKYnKyJ27sDnn5a9ec5dKgW56dTRhbl?_cft_[0]=AZVuzclU8hzipewVzMCcph9HdW779wruRn--s8IXjEoBOkzpxPEhFhCvZlouqxx-lbKzYK9PvzqAj58YGjJPZc1TTionFQxpA8JLGK7MGDIOWVwmbjsjHFpVu7QI9KJ4GZN-QxyJoBY1ytCGv11WKv1KLBO1Z0b8Wid_3FWaojNjhwScSNMeTcbwAXLHWGCbM5jf0&_tn_=%2C0%2CP-R)

“Эх хэлний өдөр 2024” контент бичлэг, танилцуулгыг 3 удаа бэлтгэн, 4253 хүнд цахимаар сурталчилсан.

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/videos/1051911269614229/?_cft_\[0\]=AZXRPycM133gf-1TdVZoygDR8s4dEW7wULKIXoW6n-zF-ybGKr-wo8hKS-KR4LYHbInK1qvRsAhE3kpbC7YTrTzyxDrmGP_19hkuV2HNmP5gh8MAWKVixktMZIbCdxcoM1I31xsl-eopDH6f9g-GsAgOZxrmjlov2zXydG4VhMzKQjY6wml98KklPK-4FIOutW81WpGMRd9RBmO_c6qf_vdX&_tn_=%2C0%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/videos/1051911269614229/?_cft_[0]=AZXRPycM133gf-1TdVZoygDR8s4dEW7wULKIXoW6n-zF-ybGKr-wo8hKS-KR4LYHbInK1qvRsAhE3kpbC7YTrTzyxDrmGP_19hkuV2HNmP5gh8MAWKVixktMZIbCdxcoM1I31xsl-eopDH6f9g-GsAgOZxrmjlov2zXydG4VhMzKQjY6wml98KklPK-4FIOutW81WpGMRd9RBmO_c6qf_vdX&_tn_=%2C0%2CP-R)

[https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02hJZQdkYzGA4YL4yhng2z1Bu686eGicjHZ6Zy283YUefgnFheMgBHAQvgxLc8mhQl?_cft_\[0\]=AZU_7uJol7atxZxVOjzgtFZJLI51KxbSck1YQN2nXg-3hjSw42ATK3roFQGWJozQA-NEtfgA7rSaroud-AKcKoVT4qbp--tY_RvAPWeZ8AWFWAh0e-gtmnFtwv4TiqsxHDLsKI2mLEMqrHnwfNNegf9bBB0BrHyHMG2Ij6nl3gY2zRzxS82pfGURer6869QsbGQ&_tn_=%2C0%2CP-R](https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid02hJZQdkYzGA4YL4yhng2z1Bu686eGicjHZ6Zy283YUefgnFheMgBHAQvgxLc8mhQl?_cft_[0]=AZU_7uJol7atxZxVOjzgtFZJLI51KxbSck1YQN2nXg-3hjSw42ATK3roFQGWJozQA-NEtfgA7rSaroud-AKcKoVT4qbp--tY_RvAPWeZ8AWFWAh0e-gtmnFtwv4TiqsxHDLsKI2mLEMqrHnwfNNegf9bBB0BrHyHMG2Ij6nl3gY2zRzxS82pfGURer6869QsbGQ&_tn_=%2C0%2CP-R)

[https://www.facebook.com/ichinkhorloo.bayarkhuu/posts/pfbid037NbG9z3qw6Rth2eFqDHit2ZYxgy9mqPxQth7Yj2CV2b7V6FuTmm6i45w1kg82kpl?_cft_\[0\]=AZWKNF1eMzfcCd8f5Hi-kZs8sPdxdw5DDQWamWWFoG08Kmkog0Q8poXmXtWc0srkoSohitU_Rphux8k8pMeKbgB7TbTQxzFOEdiHD2xMMOAipWY4gKT1UU9PBo2uJJMYv6WIEYQvjNvadAV_DGUjEFsAZOkPIBEkeUDXgCD6Nc-adH4b5IZsOulRMhxxZNLfXP7E83EZwikZYDpbp0nuellRcLF0weyWZHBMO-o78MmbKw&_tn_=%2C0%2CP-R](https://www.facebook.com/ichinkhorloo.bayarkhuu/posts/pfbid037NbG9z3qw6Rth2eFqDHit2ZYxgy9mqPxQth7Yj2CV2b7V6FuTmm6i45w1kg82kpl?_cft_[0]=AZWKNF1eMzfcCd8f5Hi-kZs8sPdxdw5DDQWamWWFoG08Kmkog0Q8poXmXtWc0srkoSohitU_Rphux8k8pMeKbgB7TbTQxzFOEdiHD2xMMOAipWY4gKT1UU9PBo2uJJMYv6WIEYQvjNvadAV_DGUjEFsAZOkPIBEkeUDXgCD6Nc-adH4b5IZsOulRMhxxZNLfXP7E83EZwikZYDpbp0nuellRcLF0weyWZHBMO-o78MmbKw&_tn_=%2C0%2CP-R)

Арга хэмжээ: 3.5.8 Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд соён гэгээрүүлэх нөлөөллийн аян, хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Бүх нийтийн соёлын боловсрол” хөтөлбөрийн Номын сангийн боловсролын хөтөлбөрийг боловсруулсан. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх 110 буланд 48 ш гарын авлага нэмж, 5 ном солилцсон. Цахимаар сурталчилгаа 9, сэдэвчилсэн 2 үзэсгэлэнгээр 135 номоор гаргасан, бүрдүүлсэн номын судалгаагаар дайн, түрэмгийлэл, садар самууныг сурталчилсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг сурталчилсан ном, хэвлэл худалдан аваагүй.

“Алдарт эх” цахим нэгдлийн гишүүдтэй хамтарсан “Сайхан сэтгэл” аяны хүрээнд “МС, Тереза эх” ахмад настны асрамжийн газарт “Номын булан” байгуулж 65 нэрийн номоор баяжуулж, уншлагыг дэмжсэн. Шуурхай удирдлага мэдээллийн төвтэй хамтын ажиллагааны хүрээнд “Номтой нөхөрлөө” арга хэмжээ, СБД-ийн ТЦГ-тай хамтран “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээнд оролцогч 26 сургуулийн 300 хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж хамтран ажиллав.

ССАЖЗЯ, НҮБ-ын Хүүхдийн сантай 2023 оноос эхлэн “Санамж бичиг”-ийн хүрээнд 2 дахь жилдээ “Гэр бүл - Соёлын анхдагч орчин” соёлын боловсролын хөтөлбөрийг 2 сарын турш хэрэгжүүлсэн.

Соёл, урлагийн боловсрол олгох, нийгмийн соён гэгээрлийг дэмжих олон талт үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэх зорилготой “Гэр бүл - Соёлын анхдагч

орчин” соёлын боловсрол олгох хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг 9 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн Салбар номын сангийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулсан ба тус арга хэмжээг СУБХЗГ-ын дарга Б.Сэргэлэн нээж, НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлан мэндчилгээ дэвшүүлж, “Voice kids mongolia” шоуны шилдэг оролцогчид, Хүүхэлдэйн театрын уран бүтээлчид уран бүтээлээ хүргэлээ.



Нээлтийн өдөр хөтөлбөр хэрэгжүүлэгч 9 байгууллага тус тусын хөтөлбөрөө явуулсанаас гадна хөтөлбөрийн онцлог, чиглэлээс хамааран Хүүхдийн төв номын сан “Гэр бүлийн уншлагын танхим”-д “Үлгэрийн цаг, Улсын хүүхэлдэйн театр “Хүүхэд саатуулах өрөө”-нд жүжигчилсэн тоглолт, Хүүхэд, залуучуудын театр 1 давхарын задгай талбайд “Бүжгийн дасгал заах”, Монгол улсын Үндэсний номын сан “Бүтээлч танхим”-д “Цахимаар уншъя”, “Make space буюу бүтээлчээр сэтгэе” гэсэн тус тусын онцлох хөтөлбөрүүдээ явуулсан. Тус өдөрлөгт Ерөнхий боловсролын Оргил сургууль, 21-р сургуулийн 7-р анги, 13-р сургуулийн 8-р анги, 23-р сургуулийн 3-р ангийн нийт 200 орчим сурагчид болон ССАЖЗ-ын яам, МУҮНС-гийн ажилтнуудын 50 гаруй хүүхэд хамрагдсан.



Долоо хоног бүрийн баасан, бямба гарагт хэрэгжүүлэгч 9 байгууллагыг төлөвлөгөөний дагуу 18 удаа зохион байгуулж, тухайн байгууллагын хөтөлбөрт тохирсон танхим, ширээ сандал, техник, тоног төхөөрөмжөөр ханган, боловсролын хөтөлбөрөө хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрэн олгож хамтарч ажилласан.

"ГЭР БҮЛ - СОЁЛЫН АНХДАГЧ ОРЧИН" СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
 КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024 ОН

2024 оны 09 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Хугацаа Зохион байгуулагч	9-Р САР									10-Р САР									Байршил										
			20	21	22	27	28	29	4	5	6	11	12	13	18	19	20	25	26	27		1	2	3	8	9	10	15	16	17	20
			Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням		Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Баасан	Бямба	Ням	Лугава
1	Нээлт	Бүх байгууллага																												Монгол Улсын Үндэсний Номын Сангийн /шэвэр/ Зөвлөх Хийл соёл, амралтын цогцолбор	
2	"Гэр бүл-соёлын анхдагч орчин" соёлын боловсролын хөтөлбөр	Хүүхдийн Төв номын сан																													
		Чингис хаан үндэсний музей																													
		Монголын Уран Зургийн галерей																													
		Улсын Хүүхэдзүйн театр																													
		Монгол Улсын Үндэсний музей																													
		Монгол Улсын Үндэсний номын сан																													
		Байгалийн Түүхийн музей																													
		Улсын Хүүхэд, Залуучуудын театр																													
Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх																															
3	Хөтөлбөрийн хаалт /Дэлхийн хүүхдийн өдөр/	Хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх байгууллага																													

ХЯНАСАН: ДАРГА
 БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН

Б.СЭРГЭЛЭН
 Б.АЛТАНЦЭЦЭГ

“Гэр бүл- Соёлын анхдагч орчин” хөтөлбөрийн хуваарьт өдөр номын сангаас 1 ажилтан хариуцан ажиллаж, хүүхдүүдийг оролцоог ханган, сонирхсон бүлэгт



номын сангийн үйл ажиллагааг танилцуулсан.

Хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын үндэсний номын сан нь 6 өдрийн арга хэмжээнд нийт 9 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж ажиллалаа.

Үндэсний номын сан нь соёлын боловсрол олгох “Номтой монгол” нэрийн дор нийт 9 хөтөлбөрийг зохион байгуулж, 1970 хүүхэд, 260 том хүнд соёлын боловсролын ойлголт, түвшинг нэмэгдүүлэх, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэхэд нөлөөлөх боловсролын хөтөлбөрүүд хэрэгжүүллээ. Цахим орчинд 9 мэдээлэл-контент түгээсэн бөгөөд нийт 25483 хандалттай байна. ССАЖЗ-ын яамнаас хамтран хөтөлбөрүүдийг сурталчилсан контент, бичлэгүүдийг хамтран цувралаар түгээн олон нийтэд сурталчилсан.



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

Зорилт. 4.1. Номын сангийн үйл ажиллагааны мэдээ, судалгаа, эрх зүйн орчин, хүний нөөцийн хөгжлийн сургалт, ажилтны нийгмийн баталгааг ханган, бүтээлч хамт олныг бүрдүүлнэ.

Арга хэмжээ: 4.1.1 Хос бичигтэн байгууллага болох, монгол бичгийн албан бичгийн хэрэглээний орчныг бүрдүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III”-ийн 3.3.7-д төрийн байгууллагууд албан хэрэг хөтлөлтөө 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл, болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. Гэсэн заалтуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан ба мөн Засгийн газраас 2024 оныг Үндэсний бичиг, соёлын жил болгон зарласантай холбогдуулан зохион байгуулсан, сурталчилсан олон төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллаа.


Албан хаагчдад Үндэсний бичгийн сургалт хэдэн удаа зохион байгуулсан мөн хэдэн албан хаагч хамрагдсан тоо /баримт, зураг/.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган, хос бичгээр албан хэрэг хөтлөх, цахим орчин дахь монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдад зориулсан монгол бичгийн цахим бичвэр буюу компьютерт бичих хичээлийг 2 удаа явуулсан. Монгол бичгээр цахимд шивэх 10 цагийн сургалтад Монгол бичгийн мэдлэгтэй байх гэсэн шалгуурыг хангасан 23 албан хаагч хамрагдсан. Давтан сургалтыг “МОНГОЛ БИЧГИЙН “ТУНГААМАЛ” ЗАГВАРЫГ АШИГЛАН ЦАХИМД БИЧИХ НЬ: 3 дахь жилдээ явуулсан. <https://www.youtube.com/watch?v=kX7E2Eg0oU>

ССАЖЗ-ын яамнаас 2023 онд хийсэн “Хос бичигтэн” үндэсний бичгийн цахим хичээл зайн сургалтын хөтөлбөрийн хичээлийг 11 дүгээр сараас эхлэн байгууллагын явуулж, нийт 112 албан хаагч хамрагдсан байна. Үүнд: Нэгдүгээр хичээл: 2024.11.12-ны өдрийн 316 үзэлттэй, Хоёрдугаар хичээл Монгол бичвэрийн цахим бичвэрийн уралдаанд ажилтан Т.Мөнхням 2 төрлөөр тэргүүн байр эзэлсэн.


Олон нийтэд Монгол Улсын Үндэсний номын сангийн <https://www.youtube.com/@NationalLibraryofMongolia> сувгаар Монгол бичгийн цахим хичээлийг нээлттэй үзүүлж, нийт 179 хүн үзсэн байна.

Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа-2024” судалгааг нийт 93 албан хаагчид [MONGOL-BICHIG.NSO.MN](https://www.youtube.com/@NationalLibraryofMongolia) цахимаар өгч оролцсон.



10. Цахим орчинд үндэсний бичгээр харилцах

135 үзэлт • 1 жилийн өмнө



9.Цахим орчинд монгол бичгээр харилцах | Mongol bichgeer tsahimd hariltsah

180 үзэлт • 1 жилийн өмнө

Монгол Улсын Үндэсний номын сангийн YOU TUBE сувгаар Монгол бичгийн цахим хичээлийг нээлттэй үзүүлж, нийт 167 хүн үзсэн байна. .

Монгол бичвэрийн цахим бичвэрийн уралдаан ажилтан Т.Мөнхням 2 төрлөөр тэргүүн байр эзэлсэн.

Хос бичигтэн хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн монгол бичгийн анхан шатны 18 цагийн хичээлийг байгууллагын цахим сүлжээн дэх бүлэгт нийтлэв. Тус хичээлийг албан хаагчид ажлын бус цагаар үзэж, мэдлэг боловсролоо дээшлүүлж байна.

Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа-2024” судалгааг нийт 93 албан хаагчид MONGOL-BICHIG.NSO.MN цахимаар өгч оролцсон. Байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллага руу явуулж буй зарим албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Арга хэмжээ: 4.1.2 Статистикийн мэдээ, судалгаа гаргана.

БСШУС-ын сайдын А/181 дугаар тушаалын дагуу 2023 оны үйл ажиллагааны тайланг Б-НС-1.1, 1.2, 1.3, Б-НС-2.1, 2.2, 2.3, Б-СУСХ-1.1, 1.2. маягтын дагуу жилийн статистик мэдээг ЗГХА СУГ-т болон НСУГ-т илгээсэн.

Соёлын сайдын 2021 оны А/300 дугаар тушаалаар баталсан маягтаар 2024 оны улирлын мэдээг 4 удаа гаргаж, баталгаажуулан илгээсэн. Соёлын салбарын статистикийн системийн хөгжүүлэлтийн хүрээнд ажлын хэсэгт төлөөлөл орж ажиллаж байна.

Shilen.gov.mn системийн холбогдох сургалтад 2 удаа хамрагдаж, Соёлын яамны СБХЗГ, ЦБМТХ-тэй хамтран 21 аймгийн номын сангийн удирдлагуудад сургалт зохион байгуулсан. Shilen.gov.mn системийн админ эрхээр 2022, 2023, 2024 оны эхний хагас жилийн мэдээг оруулсан.

Арга хэмжээ: 4.1.3 Хүний нөөцийн хөгжлийг дэмжсэн сургалтын хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох арга хэмжээ, ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж ажиллана.

Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулсан.

Авлигатай тэмцэх газар, Соёлын яамнаас хамтран 2024.01.05-ны өдөр харьяа байгууллагын холбогдох албан хаагчдын дунд зохион байгуулсан “2023 оны шинэчилсэн ХАСХОМ гаргах албан тушаалтнуудад зориулсан сургалт”-д Монгол Улсын Үндэсний номын сангийн ХАСХОМ гаргах удирдах албан хаагч-6, Ахлах нягтлан бодогч-1, ЭБАТ-1 нийт 8 албан хаагч оролцсон.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Хүний эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхал болон шаардлагатай сэдвийн хүрээнд сурталчилгаа мэдээллийг сар бүр цахимаар таниулан, танхимаар зохион байгуулах сургалт–3, Сургалтад хамрагдсан албан хаагч 264. Гадаад, дотоодын сургалт, семинарт хамрагдсан мэргэжилтний тоо 96, ТАЗ 7:4:10 сургалтад 9 албан тушаалтан тогтмол оролцож, нийт 67 хүн хамрагдсан. Халамж үйлчилгээнд хамрагдсан 5%. Судалгаа-4, Тайлан-2, Журам-2, журмын төсөл 4.

Зорилт: 4.2. Номын сангийн үйл ажиллагаа,эрх зүйн орчин, төрийн албан хаагчийн ёс зүй, хөдөлмөрийн суурь зарчмыг мөрдлөг олгон хөдөлмөрлөх орчин, нийгмийн хамгаалал, залуучууд, гэр бүл, хүүхэд хамгааллын эерэг орчин бүрдүүлж ажиллана.

Арга хэмжээ: 4.2.1 Хууль тогтоомж, нийтээр мөрдөх эрх зүйн акт, нийтлэг хүлээх үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.

Байгууллагын орчин нөхцөл, үйл ажиллагаа нь стандартад тавигдсан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. Захирлын 2024 оны А/28 тоот тушаалын дагуу Салбар номын сангийн “Язгуур” танхимын сан хөмрөгийн нийт 34878 ширхэг ном, А/30 тоот тушаалын дагуу Салбар номын сангийн “Эрдэм” танхимын сан хөмрөгийн 23078 ширхэг ном, Б/64 тушаалаар Гэр бүлийн танхимын 1934 ширхэг номыг тус тус тоолоход хяналт тавьж ажиллалаа.

Соёлын өвийн Үндэсний төвд сэргээн засварлагдсан Түүх соёлын дурсгалт зүйлс ном судрыг зөөж тээвэрлэх зөвшөөрлийн дагуу очиж хүлээн авах тээвэрлэх ажилд хяналт тавих үүрэгтэйгээр ажлын хэсгийн ахлагчаар ДХШ-ын комиссын дарга Т.Наранчимэг ажиллаж 4 дэсийн 5 судар тээвэрлэж авчирлаа. Соёлын яамны Салбарын хяналтын мэргэжилтэн Оюунзул ирж хяналт тавин хамтран ажиллаа.


Бүртгэл тооллого хариуцсан ажлын хэсэгтэй хамтран өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг өгч ажилласан.

Соёлын яамнаас зохион байгуулсан сургалтад удирдлага, комиссын 2 гишүүн хамрагдсан, ХШҮДАГ-т холбогдох мэдээ, тайланг илгээсэн. Дотоод хяналт, шалгалтын хүрээнд хяналт үнэлгээ-5 удаа, хэрэгжүүлэх арга хэмжээ-2

Арга хэмжээ: 4.2.2 Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хороо хяналт тавьж ажиллана.

Үндэсний номын сангийн "Ёс зүйн дэд хороо"-г 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажиллах журмыг батлуулсан. Дэд хорооны хурлыг 3 удаа хийсэн.

ТАЗ-ийн 7:4:10 вебинар сургалтын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн холбогдох сэдвийн сургалтад 4 удаа хамрагдсан. Байгууллагын мэдээллийн самбарт 4 мэдээлэл, цахимаар 8 мэдээлэл өгч, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулсан. МУҮНС-ийн 113 ажилтаас судалгаанд 85 ажилтан буюу нийт ажилчдын 75 хувь нь хамрагдсан.



Судалгааг 12 асуулгаар цаасаар авсан ба орон нутгаар сургалтаар явсан 2 хүнээс цахимаар авсан. Байгууллагын нийт ажилчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” танхимаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Үүнд: “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ” сэдэвт сургалт МУҮНС-ийн Салбар номын сангийн Үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдаж нийт 43 ажилтан хамрагдсан,

Байгууллагын захиргаа, Ёс зүйн дэд хороо, Ёс зүйн академийн сургагч багш, Олон улсын хуульч Ж.Оймандах хамтран 2024.11.12-ны өдөр нийт албан хаагчдад “Байгууллагын ёс зүйн анхан шатны ухагдахуун” сэдэвт сургалтыг зохион байгуулж 46 ажилтан хамрагдсан.

Монголын Хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн академитай хамтран “Үйлчилгээний ажилтны соёл, ёс зүй” сэдвээр Монголын Хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн Академи-ийн Гүйцэтгэх захирал З.Гоомарал сургалт зохион байгууллаа.






Арга хэмжээ: 4.2.3 Ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьпчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.

“Эцэг эхийн зөвлөл”-ийн хурлыг 2 удаа зохион байгуулж, төлөвлөгөөгөө боловсруулж батлуулсан. Зөвлөлийн гишүүдэд 5 удаа сургалт, мэдээлэл хийсэн.

Ажилтнуудыг хүүхэдтэйгээ чөлөөт цагаа хамт өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх, эцэг, эхийн ажилладаг шинэ салбар номын сантай хүүхдүүдийг танилцуулах зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “ХҮҮХЭД - ЭЦЭГ, ЭХ” арга хэмжээг зохион байгуулсан.



Байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудаст сар бүр хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээл мэдээлэл байршуулж, 12 удаа сурталчилсан.



Шинэ салбар номын санд Номын сангийн албан хаагчид болон номын сангийн үйлчилгээ авахыг хүсдэг ч хүүхэд харах хүнгүй эцэг эхчүүдэд зориулсан “Хүүхэд саатуулах танхим” байгуулан тохижуулсан. “СБҮ-2024” үйл ажиллагааны хүрээнд “Бүх нийтийн соёлын боловсрол-хүний хөгжил” хэлэлцүүлэгт оролцсон.

Арга хэмжээ: 4.2.4 Хөдөлмөрийн харилцааны суурь зарчмыг мөрдлөг болгож, албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлын оролцоог хангана.

Монголын ажилтан, албан хаагчдын ҮЭХ-ноос дэвшүүлсэн зорилт, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, гишүүдэд хуулийг сурталчлах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, гишүүнчлэлээ өргөжүүлэх, ажилчдын нийгмийн баталгааг хангах зорилготой ажиллаж ирлээ. “Хөдөлмөрийн тухай” хууль /шинэчилсэн найруулга/-д заасан хөдөлмөрийн харилцааны суурь зарчмыг мөрдлөг болгож, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг уян хатан зохицуулж, Үндэсний номын сангийн ажил үйлчилгээг хэвийн явуулах, төрийн үйлчилгээг нийтэд чанартай хүргэх, аливаа дарамт, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэх, ажилтнууд үндсэн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах, захиргаатай хийсэн хамтын гэрээнд тусгагдсан ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үүнд: МУҮНС-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2023-2024 оны хамтын гэрээний хүрээнд биелэлтийг ханган ажиллаж, бүх гишүүдийн хурал 2 удаа хийсэн.

Үйлдвэрчний эвлэлд шинээр 42 гишүүн бүртгэж гишүүнчлэлээ нэмэгдүүллээ. Мэдээлэл сурталчилгааг 3 удаа цахим хуудсаар мэдээлэл өгсөн. Нийт албан хаагчдад Үйлдвэрчний эвлэл, Хөдөлмөр аюулгүй байдлын чиглэлээр сургалт 11 сарын 19-нд зохион байгуулсан. Сургалтад МҮЭ-ийн хуульч А.Эрдэнэбаяр “Хөдөлмөрийн соёл, харилцаа, эрх зүйн орчин” сэдвээр, МҮЭХ-ны ХАБЭА-н мэргэжилтэн Д.Баттөгөлдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдвээр тус тус сургалт явууллаа. “Эх үрсийн баяр”-ын өдрийг тохиолдуулан бүх гишүүддээ нийт 800,000 төгрөгийн бэлэг өглөө.

ҮЭ-ийн хорооны тэргүүлэх гишүүдээс “Хүндэт тэмдэг” болон “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэгт 4 хүн тодорхойлж, шагнуулав. Үндэсний номын сангийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2022-2024 оны хамтын гэрээнд талууд харилцан тохиролцож гэрээний 4.1 дэх заалтад өөрчлөлт оруулж, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд байгууллагаас нөхөн олгох мөнгөний доод хэмжээг 500 төгрөгөөр, тэдний нэг өдрийн хоолны мөнгийг 30,000 /гучин мянган/ төгрөгөөр тогтоож, сар бүрийн цалин дээр нэмж олгохоор шийдвэрлэсэн.



Арга хэмжээ: 4.2.5 Залуучуудын хөгжлийг дэмжин, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

Зөвлөлийн гишүүдийн дунд болон байгууллагын хэмжээнд нөлөөллийн арга хэмжээ "Номтой болзоо" зохион байгуулсан. Залуучуудын хувь хүний хөгжил, номын санч залуучуудын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сурталчилгааг цахимаар 5 удаа хүргэж, сургалтад 2 албан хаагч хамрагдсан.

Шинэ номын сангийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой бэлтгэл ажилд ЗХЗ манлайлан ажиллаж, цахим уншлагын танхим, Онцлог хэрэгцээт иргэдийн танхим, Гэр бүлийн уншлагын танхим зэрэг шинэ танхимын тохижилт, зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Omi номын клубийн 100 дахь уулзалтыг номын санд хийж номын сангийн үйлчилгээ, номын клубийн хамтын ажиллагааны талаар эдээлэл өгч, зөвлөв. 50 гаруй хүн хамрагдав. Сар бүрийн сүүлийн бямба гарагт зохион байгуулагддаг Ukasbookclub-ийн 25 дахь удаагийн уулзалтыг хамтран зохион байгуулав. Тус номын клуб 2022 оны 4 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба энэ удаагийн уулзалтаар "АМЬДРАЛЫН УТГА УЧИР" сэдвийн хүрээнд уншсан номынхоо тухай ярилцаж, үзэл бодлоо хуваалцаж 15 гишүүн оролцлоо.

Зорилт. 4.3.Үндэсний номын сангийн төсвийг зүй зохистой захиран зарцуулж, ил тод байдлыг хангаж ажиллана.

Арга хэмжээ: 4.3.1 Байгууллагын төсвийг зүй зохистой захиран зарцуулж, ил тод байдлыг хангаж ажиллана.

Тайлангийн хугацаанд улсын төсвөөс 3,014.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт, 166.6 сая төгрөгийн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт авч 3,063.4 сая төгрөгийн зардал гарсан байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 11, Нийгмийн даатгалын тайлан -11, Татварын тайлан -3, Санхүүгийн тайлан-1, судалгаа 5.

Арга хэмжээ: 4.3.2 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэн, байгууллагын үйлчилгээ, орчин нөхцөлийг сайжруулж, ажилтнуудын нийгмийн баталгааг нэмэгдүүлнэ.

Санхүү, хөрөнгө оруулалтын газартай үр дүнд суурилсан санхүүжилтийн тооцоо хийж 166.6 сая төгрөгийн санхүүжилт авч. Журмын дагуу хамт олны хурал 2 удаа хийсэн, зарцуулалтын хуваарилалт хийж, гүйцэтгэсэн.

Зорилт. 4.4. Гадаад, дотоодын номын сан, ном хэвлэл, соёлын байгууллагатай хамтран ажиллана.

Арга хэмжээ: 4.4.1 Гадаадын номын сан, ном хэвлэлийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн, үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулна.

Соёлын яамны 5 сарын 6-10-ны хооронд зохион байгуулсан ЮНЕСКО-гийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн хорооны 10-р чуулганд номын сангийн 2 төлөөлөгч оролцсон бөгөөд "Халхын долоон хошуу, дөрвөн аймгийн ноёдын гэрийн үеийн бичмэл" нь олон улсын баримтад өвийн жагсаалтад бүртгэгдсэнээр нийт бүртгэгдсэн 8 өв боллоо. Гадаад харилцааны төсөл, гэрээ: 3: Москва дахь Оросын Улсын номын сантай хамтран МУҮНС дээр "НЭБ Свет" цахим номын сан байгуулах гэрээнийг төслийг монголоор орчуулж Соёлын яаманд танилцуулаар явуулсан. Санкт Петербург дэхь Оросын Үндэсний номын сангийн захиралын албыг түр хамаарах, ноён Д.О.Цыпкинд захирлын нэрээр захиа илгээсэн. Б дахь Хятадын соёлын төвөөс манайд ном хандивлах гэрээний төслийг боловсруулж бэлэн болгосон. Зохион байгуулсан арга хэмжээ: Японы Засгийн газрын "Ниппон сан"-аас хэрэгжүүлдэг "Read Japan" төслийн ном хандивлах ёслолыг зохион байгуулсан, ёслолд Японы ЭСЯ-ны Гутгаар нарийн бичгийн дарга, ноён Катанода; Соёл, олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан,

хатагтай Ж.Сэргэлэн; захирал Б.Ичинхорлоо, Ерөхний номын санч Т. Баярлах нар оролцсон.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Андун хот дахь Солонгос Судлалын Хүрээлэн (한국국학진흥원)-ийн дэд ерөнхийлөгч Бэ Сонгил, тус хүрээлэнгийн Баримтат өв судлалын хэлтсийн дарга Кан Босин нар захирал Б.Ичинхорлоотой цаашид хамтран ажиллах боломжийн талаар санал солилцох уулзалт, мөн цаасан баримтад өвийн сэргээн засварлалт, хадгалалт, хамгаалалтын чиглэлээр төсөл хэрэгжүүлэх талаар Япон Улсын монголч эрдэмтэдтэй уулзалт хийсэн.

Шинэ салбарын нээлтийн ёслолоор гадаадын зочдыг урих ажлыг хариуцсан



бөгөөд ёслолд нийт 11 ЭСЯ-ны 22 зочин ирснээс АНУ, БНХАУ, Австрали, Унгар, Түрк, Киргиз, Казакстаны 7 элчин сайд оролцсон. Монгол Улсын Гадаад харилцааны яамны дэргэдэх Эмэгтэйчүүдийн дипломат клубийн гишүүн эмэгтэйчүүд болон Монголд суугаа зарим ЭСЯ-ны эмэгтэйчүүдийг Төв байртай танилцуулах ажлыг зохион байгуулсан. Оролцсон хурал, семинар 3.

Хамтын ажиллагаа:



Арга хэмжээ: 4.4.2 Номын санчдыг мэргэшүүлэх сургалт, хэлэлцүүлэг, хурал, семинарт танхим болон цахимаар хамруулна.

Дотоодын сургалтад: Төрийн худалдан авах ажиллагааны АЗ сургалтад суусан 2024 оны 03-р сарын 14-16-ны хооронд 6 албан хаагч хамрагдаж, 4 албан хаагч сертификат авсан. Магистрын сургалтад 2, докторын сургалтад 4.

Гадаадын сургалт, семинар: Австралийн ЭСЯ-ны тэтгэлгээр Үндэсний номын санг төлөөлж М.Даваасүрэн семинарт оролцож, илтгэл тавьсан. Төвөд хэлт ном судрыг каталогт оруулах, цахимд шилжүүлэх төслийн ерөнхий зохицуулагч, доктор Б.Сайнбилэг Германы Хамбургийн Их Сургуулийн Эх бичгийн соёл судлалын төвд 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр “Монголчуудын модон барын уламжлал ба бүтээж байсан бичиг үсгийн дурсгалууд” сэдэвт илтгэл тавьж оролцсон.

БНСУ-ын СРІ хөтөлбөрт номын санч мэдээллийн ажилтан Э.Болормаа хамрагдсан.

Арга хэмжээ: 4.4.3 Дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, номын сан, ном хэвлэлийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн, үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулна.

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран Монголын ноёд тайж нарын гэрийн үеийн бичмэлүүдэд эрдэм шинжилгээний боловсруулалт хийн судалгааны эргэлтэд оруулж, каталог хэвлэх, үзэсгэлэн гаргах, нэвтрүүлэг, видео контент зэрэг бусад хэлбэрээр олон нийтийн хүртээл болгох зорилгоор гэрээ байгуулан номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй гэрийн үеийн бичмэлүүдийг бүрэн бүртгэн тодорхойлж, цахимд шилжүүлэх, хөрвүүлэх, галиглах ажлыг хийж байна. 2024 онд багтаан Түшээт хан аймгийн гэрийн үеийн бичмэлийг хэвлэн гаргах төлөвлөгөө гаргасан ба уг ажлын санхүүжилт Монгол судлалын Үндэсний зөвлөлөөс шийдэгдээд байгаа билээ.



ШУА-ийн харьяа 12 хүрээлэнтэй хамтран "Эрдэм номын чуулган" ном хандивлах арга хэмжээг уламжлал болгон 6 дахь жилдээ зохион байгуулсан.

МУБИС-тай хамтран боловсрол судлалын оюутны ЭШХ, СИТИ ИС, СБД, дүүргийн ахмадын зөвлөл, ТЦГ зэрэг 10 гаруй байгууллагатай хамтран 23 арга хэмжээ зохион байгуулсан.



Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө, Нийслэлийг хөгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд тус номын сангаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн соёлын ордны номын сангийн фондын баяжилтыг жил бүр хийнэ.

Энэ онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар номын баяжилт хийгдээгүй тул төв болон салбар 4 номын сангийн фондын баяжилтыг өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 312 ширхэг ном, бэлэг, хандиваар авсан 1087 ширхэг ном нийт 1399 ширхэг номоор тус тус баяжуулсан байна.



2.6.3.1. “Хотын соёл” цуврал контент бий болгож цахим аян хэрэгжүүлнэ.


Тайлант хугацаанд хотын соёлтой холбоотой сэдвүүдээр 92 удаагийн богино хэмжээний контент, рийл хийж номын сангийн пэйж хуудаснуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн байна.

Тухайлбал: Номоо хэрхэн зөв арчлах вэ, Ном унших арга, Хог хаягдлын менежмент яагаад чухал вэ, Хотын соёл хотын гудамж талбай, Хотын соёлтой иргэн, Хотын соёлын тодорхойлолтууд, Хотын соёлын тухай, Байгууллагын соёл, Соёлтой иргэн, эерэг хандлагыг төлөвшүүлье, Улаанбаатар хотын түүх, Хотын соёлыг хамтдаа түгээе, Хотдоо хайртай, боловсролтой, соёлтой иргэн байцгаая, Хотын соёл энгийнээс эхэлдэг, Ногоон орчинг хамтдаа бүтээе, Замын хөдөлгөөний дүрмийг баримталж, бие биеэ хүндэтгэн замын хөдөлгөөнд соёлтой оролцъё, видео Хотын соёлд хамтдаа, Хотын соёл, Улаанбаатар хамтдаа соёлтой болгоё, Хотын соёл бидний оролцоо, Соёл биднээс эхэлнэ, Хотын соёлд хамтдаа, Хотын соёлыг төлөвшүүлэхэд иргэн бүрийн оролцоо чухал, Хотын соёл гэж юу вэ, Хүүхэд ба цахим орчин, Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох талаар зөвлөмж, Хүүхдийг дэлгэцийн донтолтод өртөхөөс сэргийлье, Тоглоомын талбайд мөрдөх дүрэм, Хоггүй орчин хотын соёл, Хотын соёл биднээс эхтэй, Хотын соёлд хамтдаа, Нийтийн тээврээр үйлчлүүлэх соёл, Хотын соёл харилцаанаас эхэлнэ, Хотын соёл буюу харилцаа, Нийгмийн сүлжээнд зөв байцгаая зэрэг сэдвүүдээр бэлтгэн хүргэсэн байна.



4.1.2.2. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

Тус номын сан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх орчны стандарт бүрдсэн нэг танхимтай бөгөөд энэ оны байдлаар харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 20 нэрийн цахим ном бүтээсэн. Мөн Андроид үйлдлийн систем дээр ажилладаг монгол хэлээр ярьдаг Aim TTS аппыг үйлчилгээндээ нэвтрүүлсэн. Энэ апп нь дэлгэц дээр гарсан бичвэрийг монголоор ярих учир хараагүй хүн андроид төхөөрөмжийг ашиглах боломжтой юм. Мөн "Туслагч технологийн сургалт"-ыг ганцаарчилсан хэлбэрээр 8 уншигчдад 6 удаа зохион явуулж 20 хүнийг хамруулж, орбит 40 брайл дэлгэц, NVDA дэлгэц уншигч программ, Jieshuo андроид дэлгэц уншигч программ, харааны бэрхшээлтэй хүнд зориулсан андроид таблет зэргийг танилцуулж, анхан шатны ойлголт өгсөн.



Андроид системийн хүртээмжийн стандартын шаардлага хангасан БИЧВЭР ЯРИХ АПП

“AIM” TTS

©2024

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж Андроид систем дээр AIM МОНГОЛ ХЭЛНИЙ ЯРЬДАГ АППЫГ ЭНГИЙН ДЭЛГЭЦ ҮНШИГЧ АПП (JIESHUO)-ын хамт хэрэглээнд орууллаа.



4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах хууль болон холбогдох бусад журмын дагуу төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган, 2023 оны жилийн эцсийн тайлан, Аудитын дүгнэлт, сар бүрийн ажил гүйлгээ зэргийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан.

Төрөл	2023.01.01-2023.01.31	2023.02.01-2023.02.28	2023.03.01-2023.03.31	2023.04.01-2023.04.30	2023.05.01-2023.05.31	2023.06.01-2023.06.30	2023.07.01-2023.07.31	2023.08.01-2023.08.31	2023.09.01-2023.09.30	2023.10.01-2023.10.31	2023.11.01-2023.11.30	2023.12.01-2023.12.31	2023.01.01-2023.12.31
1. Дотоод орлого
2. Дотоод зардал
3. Дотоод хөрөнгийн өөрчлөлт

Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг

Жил бүр улс даяар үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жил үндэсний бичиг үсгийн баярыг “Үндэсний бичиг үсэг- Монгол соёлын үнэт өв” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд тус номын сангаас дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

Цахим үзэсгэлэн

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан номын сангийн сан хөмрөгт байгаа монгол бичгээр хэвлэгдсэн 100 номыг багтаасан



санамж өгөх ном зүй болон номын танилцуулгыг богино хэмжээний видео болгон цахим хуудсаар дамжуулан сурталчилсан ба уг номоор үзэсгэлэн гаргасан. Мөн Монгол бичгийн 39 ширхэг номоор цахим каталог гаргаж сурталчилсан байна.

Эл өдрийг тохиолдуулан үндэсний бичгээ эрхэмлэн дээдэлж, эх бичгийн соёлоо сурталчлах зорилготойгоор Монгол бичгийн тухай шүлгүүдээр рийл хийж 5 ширхэг толь бичгийн ном ашиглан “Монгол бичгийн толь бичгүүд” сэдвээр цахим үзэсгэлэн гаргаж, “Монгол бичиг сурах бичгүүд” сэдэвт 6 ширхэг номоор танилцуулга хийж номын сангийн пэйж хуудсаар сурталчилсан.



Уралдаан тэмцээн

Тус өдрөөр "Хичээнгүй сайхан бичигтэн" уралдааныг зохион байгуулж Ерөнхий боловсролын 19-р сургуулийн 11-12 дугаар ангийн нийт 50 сурагчыг хамруулж түүнээс 3 сурагч шалгаруулж шагнаж урамшуулсан.

Үндэсний бичиг үсгийн өдөрт зориулан сурагчдын дунд бийрэн бичлэгээр хэн сайхан алдаагүй зөв бичих вэ? уралдааныг 25 сурагчдын дунд явууллаа. "Би монгол хүн" шүлгийн эхний бадгийг алдаагүй зөв бичсэн 4 сурагчийг шалгаруулж, сурагчдад дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

Үзэсгэлэн

Мөн Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан хүүхдийн танин мэдэхүйн 38 ширхэг номоор, Эх хэл, бичиг соёлын тухай 18 ширхэг номоор 2 удаагийн сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигчдад хүргэсэн.

Сурагчдын бичсэн бийрэн бичлэгийн бүтээлээр 2 удаа бүтээлийн үзэсгэлэн гаргаж мөн сурагчдын уншсан номын тэмдэглэлүүдээр тус тус үзэсгэлэн гаргасан.

Уулзалт, ярилцлага



Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж МҮОНР-ийн уран зохиол, өв соёлын редакцын редактор, зохиолч, сэтгүүлч Б. Даариймаатай уншигч зохиолчийн уулзалт хийж уулзалтад Ертөнц бүрэн дунд сургуулийн С.Цэнгэл багштай 8а ангийн 16 сурагчдыг хамруулсан. Уулзалтад сурагчид өөрийн зохиосон шүлгээ уншиж өгч, ямар мэргэжил сонгосон тухайгаа ярьж, ном уншихын гайхамшиг, хүн байх утга учрын талаар нээлттэй ярилцаж чөлөөт яриа өрнүүлсэн.

Номын өдөрлөг

Үндэсний бичиг соёл, номын баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхэд залуучуудын ном унших хүсэл сонирхлыг дэмжих, хичээлээс олсон мэдлэгээ бататгаж НОМЫН БАЯР-2024 өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж 110 сурагч, иргэдийг хамруулсан. Тус өдөрлөгөөр:

- Чанга шивнээ уралдаан
- Номыг таа тэмцээн


- Үсгээр үг эвлүүлье
- “Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэг”-ийн болзол хангасан уншигчийг шагнаж урамшуулах
- Сэдэвчилсэн номын үзэсгэлэн




2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг номын баяр арга хэмжээг Улсын их хурлын дарга Г. Занданшатарын ивээл дор “Илүү их уншъя” уриан дор зохион байгуулагдаж манай номын сангаас дараах ажлуудыг зохион явуулсан. Үүнд:

- Номын баярыг угтаж СГЗ, Д.Нацагдоржийн шагналт зохиолч, Болор цомын эзэн Ж.Баяржаргал, СТА дуучин, зохиолч, өв соёл судлаач Хумбагарын Батмэнд болон МЗЭ-ийн хүүхдийн зохиолч, хүүхдийн сэтгэл судлаач, сэтгүүлч редактор Адъяагийн Найгалмаа нартай “Зохиолч Уншигчдын уулзалт” хийсэн.
- Хүүхдийн номын зохиолч, редактор, үлгэрч багш А.Даваасүрэнтэй "Уншигч-Багачуудад" сэдэвтэй уулзалт хийсэн.
- Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Хүүхдийн зохиолч Н.Мандалтай "Сайхан сэтгэлийн эрэлд" сэдэвтэй уншигч зохиолчийн уулзалт хийсэн.
- МЗЭ-ийн шагналт, 2016 оны "Утгын чимэг" богино өгүүллэгийн наадмын тэргүүн байрын шагналт зохиолч, сэтгүүлч Б.Лхагвасүрэнтэй уулзалт хийсэн.
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиол судлалын салбарын эрхлэгч Гаадамбын Билгүүдэйг урьж подкаст бэлтгэн хүргэсэн.
- Хүүхдийн танхимын сан хөмрөгт байгаа зохиолчдын бүтээлээс цувралаар видео танилцуулга зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Хүүхдийн урлан бүтээх төвтэй хамтран НЕБ-ын 103 дугаар сургууль, НЕБ-ын 5 дугаар сургуулийн сурагчдад Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Монгол уран бичлэгийн ангийн багш Г.Болормаа, Д.Дуламсүрэн нар “Монгол уран бичлэгийн тухай ойлголт” ярилцлага өрнүүлж, Монгол уран бичлэгийн дадлага сургалтыг явуулсан.



- Номын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд: Тува СССР Мөнгөн тайга яруу найргийн наадмын түрүү шагналт МЗЭ-ийн гишүүн зохиолч Х.Алтанцэцэгтэй уулзалт хийсэн.
- Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 5г ангийн сурагчдын уншсан номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргаж сурталчилсан.
- Монгол Улсын Гавъяат жүжигчин Аюурзанын Цэгмэд уригдан ирж хүүхэд багачуудтай “Номыг яаж зөв сайхан унших вэ? Зөв харилцаа соёл, сэдвийн хүрээнд сонирхолтой яриа өрнүүллээ.
- Номын баяр бидний баяр, Ном унших сайхан мэдээлэл постыг бэлтгэн номын сангийн пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн.
- Илүү их уншъя Хүүхдүүд ээ! Өдөрт 10-15 минут ном уншиж хэвшээрэй! “Номыг хэрхэн унших вэ? Ном унших тухай зөвлөмж видео бэлтгэн номын сангийн пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн.
- "love the book" Хүүхдүүдээ “Шинжлэх ухаан, технологийн номын ертөнцөөр аялцгаая! 5 цуврал номоор видеог бэлтгэн номын сангийн пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн.
- МЗЭ-ийн шагналт, Болор цомын эзэн яруу найрагч Б.Болорцэрэн, Сүүнбэх утга зохиолын нэгдлийн ТУЗ-ийн гишүүнийг зочны ярилцлагаар урьж оролцуулсан.
- Яруу найрагч, Болорцом-41 шилдэг оролцогч А.Анхбаярыг зочны ярилцлагаар урьж оролцуулсан.
- МЗЭ-ийн гишүүн Н. Уламбаярыг зочны ярилцлагаар урьж оролцуулсан.
- Залуу яруу найрагч Б. Дагвадуламыг номын сангийн зочны ярилцлагаар урьж оролцуулсан.
- Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн сэтгүүлч, нийтлэлч А.Баатархуяг, сэтгүүлч, нийтлэлч Г.Уянга нар оролцон өөрсдийн туурвисан уран бүтээлүүдээ танилцуулан, номтой хэрхэн нөхөрлөх, ном уншихын ач холбогдол сэдвээр офицер, ахлагч, албан хаагчидтай сонирхолтой хэлбэрээр яриа өрнүүлсэн.



- Дүрслэх урлагийн академийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга сэтгүүлч, зохиолч, судлаач Д.Батмөнх оролцсон.



Номын өдөрлөг

Мөн “Илүү их уншъя” уриатай 36 дахь удаагийн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт Хүчний 017 дугаар ангитай хамтран "Хязгаар үгүй ном сэтгэлгээний эрх чөлөө" сэдэвт номын өдөрлөг,



Сонгинохайрхан дүүргийн алслагдсан 25 дугаар хорооны Ерөнхий боловсролын лаборатори 151 дүгээр сургуультай хамтран "Номтой нөхөрлөхүйн утга" сэдэвт өдөрлөг, СХДүүргийн 13-р хорооны иргэдийн дундах номын өдөрлөг зэрэг өдөрлөгүүдийг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр:





- Зөөврийн номын сангийн үйлчилгээ
- Номын сангийн карт нээх үйлчилгээ
- Танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг 2 удаа зохион явуулж, тэмцээнд 73-хүүхдийг хамрууллаа.

Номын үзэсгэлэн

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2 удаа 125 ширхэг боть номоор үзэсгэлэн гаргаж 123 уншигч хэрэглэгчдэд танилцуулсан.

Цахим номын танилцуулга үзэсгэлэнг 1 удаа 5 ш номоор 59 хүнд хүргэсэн байна.

Уралдаан тэмцээн



Мөн “Номын баяр 2024” арга хэмжээний хүрээнд 105 уншигчдыг хамруулсан 2 удаагийн уралдаан тэмцээнийг зохион байгууллаа. Үүнд:

- НЕБ-ын 151 дүгээр сургуулийн 6-8 дугаар ангийн сурагчдын дунд “Үсэглэлийн хаад” тэмцээн
- “Номтой нөхөрлөхийн ач тус”сэдэвт гар зургийн уралдааныг 3-5 ангийн сурагчдын дунд зохион байгуулсан.



2.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг

Тус зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот – Иргэний оролцоо” хавар, намарын мод тарих аяны хүрээнд 2022 онд батлагдсан хуваарийн дагуу байгууллага хамт олноороо Хан Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Айдсын аманд 60 ширхэг модны суулгац тарьж, усалгаа арчилгаа хийсэн. Мөн энэ онд аяны хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 10, 10 дугаар сарын 13-ны өдрийн 11⁰⁰-13⁰⁰ цагийн хооронд заавар зөвлөмжийн дагуу ХУД-ийн 14 хороо айцийн амны заасан байршилд мод тарих үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- 2022 онд тарьсан 60 модыг арчлан, цэнэг усалгаа, нөхөн сэргээлт хийж хог хаягдлыг цэвэрлэсэн.
- 2022 онд тарьсан 60 модноос 10 мод нь сэргээх боломжгүй байсан тул шинээр 20 ширхэг монос, хар мод худалдан авч суулгалт хийж усалгаа тордолгоо тус тус хийсэн.



Мөн Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод тарих ашиг тусын тухай <https://www.facebook.com/ChingilteiPublicLibrary> пейж хуудсаар дамжуулан Тэрбум мод байгалиа бүтээе, Хүн бүр байгаль хамгаалагч, тэрбум мод байгалиа бүтээе, Хотын өнгө үзэмжийг сайжруулахад иргэд санаачилгатай байж, хашаандаа мод тарьж, ногоон өнгө нэмье!, Тэрбум мод байгалиа бүтээе!, Хотын өнгө үзэмжийг сайжруулахад



иргэд санаачилгатай байж, хашаандаа мод тарьж, ногоон өнгө нэмье!, Цөлжилтийн эсрэг хамтдаа, Мод тарья, Алтан намар, Мод тарих цаг зэрэг 4 мэдээлэл 8 постерыг бэлтгэн хүргэсэн.

2.4. Монгол улсын засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоол

Дэлхийн ном, зохиогчийн эрхийг хамгаалах өдөрт зориулан тус номын сангийн харьяа Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангаас номын соёлыг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх хүүхэд багачуудыг номонд дурлуулах, хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Ном бидний ертөнц” уулзалтыг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Д.Долгорсүрэн багштай хамтран 4 сургуулийн 120 сурагчдын дунд зохион байгуулсан.



2.5. Монгол улсын засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоол


Тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Берлиний Хумболтын Их сургуулийн Монгол судлалын салбарын эрхлэгч, доктор А.Ганчимэгийн залуучууд, залуу судлаачдад зориулан бичсэн Үндэсний бичиг сурах "Classical Mongolian: A Textbook for Students, Scholars, and Everyone Interested in Mongolian" номыг танилцуулж үндэсний бичиг соёлыг сурталчлах сургах зорилгоор нийт албан хаагчдад сургалт ярилцлага орсон. Англи хэл дээрх тус сурах бичиг нь "Уйгаржин Монгол" бичгийг дэлхий даяар тархан суугаа 200 гаруй мянган монгол угсаатнуудын хэл, соёл, түүхийг сонирхсон



бүх хүмүүст зориулагдсан бүтээл болжээ.

2.6. Монгол улсын засгийн газрын 2021 оны “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол

Тус тогтоолын хүрээнд Номын сангийн 2023 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж төсөвт зардлыг хэмнэхэд чиглүүлж Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, Шаардлагагүй албан конторын тавилга болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд хэмнэлт гаргах, удирдлагын болон ажиллагсдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр ашигтай нь уялдуулан нарийн тооцож, ур чадвар, урамшуулалт цалинг хязгаараас хэтрүүлэхгүйгээр хавтгайруулан олгохгүй байх зэрэг арга хэмжээг авч ажиллахыг тасаг салбарын эрхлэгч, хүний нөөцийн мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгож ажилласан.



2.7. Монгол улсын засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 201 дүгээр тогтоол

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1488 жиргээ илгээгдэж, 413 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 51000, үүнээс гадна АСМТ 47000 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг өдөр бүр тогтмол түгээн ажиллаж байна.

№	Нэр	Хэргүй	Өөрчлөлт	Хэргүй	Өөрчлөлт
1	UB Public Library - Хот...	39.5K	▲0.1%	2	470
2	Монгол Улсын Үндэсний...	19.2K	▲0.3%	11	3.4K
3	American Corner, Ulaan...	18.5K	0%	1	71
4	Хүүхдийн төв номын сан	9.2K	▲0.2%	34	816

2.8. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" А/480 дугаар захирамж


Тус номын сангаас “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Хөгжлийн харандаа” хөтөлбөрт оролцож номын сангийн үйл ажиллагааг сурталчлан 15 уншигчдад үнэ төлбөргүй уншигчийн карт нээж ажиллалаа.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 21 удаагийн цахим мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэсэн байна. Тухайлбал:

- Сургуулийн орчинд хамгийн эелдэг, найрсаг сурагч нь байгаарай! мэдээлэл
- Дэлгэцийн донтолтоос сэргийлэхийн тулд эцэг эхчүүд юу анхаарах вэ? мэдээлэл
- Нэгдүгээрт хүүхэд
- Найз байя мэдээлэл
- Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлье! мэдээлэл,

- Дэлгэцийн донтолтоос сэргийлье!
- Хүндлэл хамгийн тод гэрэл
- Өсвөр насны хүүхэдтэйгээ та хамгийн сүүлд хэзээ найз шиг нь ярилцсан бэ?
- Хүүхдийн сурч боловсрох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, соёлын амьдралд оролцох эрх
- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн тухай
- Хүүхдийн эрхийн тухай конвенцийн талаарх контент
- Хүүхдийн тусгай хамгаалагдах эрх
- Гэр бүлийн хүчирхийлэлд охид эмэгтэйчүүд, хүүхдүүд илүү өртдөг зэрэг мэдээлэл постуудыг оруулсан байна.



Уулзалт ярилцлага

Мөн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Гоц авьяастнуудын сургууль” сэдэвт уулзалтыг зохион байгуулж зочноор МЗЭ-ийн шагналт, “Миний супер найз” хүүхдийн номын зохиолч Э.Амарзаяаг урьж оролцууллаа.



“Өсвөр насны сэтгэлзүй” сэдэвт уулзалтыг ерөнхий боловсролын 19-р сургуультай хамтран зохион байгуулж, зочноор “Амин хүүхэд” ТББ-ын хүүхэд гэр бүлийн сэтгэл зүйч Г.Солонгыг урьж оролцуулан 19-р сургуулийн 10 ангийн 28 сурагч арга хэмжээнд хамрагдсан байна.




2.12. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж Веб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <http://www.pl.ub.gov.mn> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2023 оны 12 дугаар сарын 11-аас 2024 оны 11 дүгээр сарын 29-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 125420 хэрэглэгч зочилж /visits/, 548694 хуудасны мэдээллийг үзжээ.

Нийт сайтийн хэрэглэгчдийн 71.2% нь шинээр орж, 28.8% нь хуучин хэрэглэгчид хэрэглэгчид зочилсон байна.


Вэб хуудас шинэчлэх ажлын хүрээнд

Байгууллагын вэб сайтыг шинэчилж мэдээ, мэдээлэл оруулж тогтворжуулан ажиллаж байна. Мөн вэб сайтад 57 мэдээ, мэдээлэл оруулсан байна.



Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2023 оны 12 дугаар сарын 11-аас 2024 оны 11 дүгээр сарын 29-нийг хүртэлх хугацаанд 79613 хэрэглэгч зочилж /visits/, 245716 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 87,5% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 12,5% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.


Country	Users	% Users
1. Mongolia	36,969	90.53%
2. United States	933	2.28%
3. Russia	581	1.42%
4. South Korea	335	0.82%
5. Japan	281	0.69%
6. China	251	0.61%
7. Ireland	168	0.41%
8. Netherlands	163	0.40%
9. Germany	127	0.31%
10. Sweden	121	0.30%

Интернэт сүлжээ

Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон. Сонгино-Хайрхан дүүрэг дэх салбар номын сангийн сүлжээний свич шатсанг сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үндсэн интернэтийн хурдыг 50 Mbps болгон бусад салбарийн интернэтийн хурдыг 10 Mbps болгон нэмэгдүүлсэн.


Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 33.77 Mbps, дунджаар 31.99 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 97.26 Mbps, дунджаар 127.37 Kbps хүрсэн байна.



Утасгүй Интернэтийн сүлжээ

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 5.17 Mbps, дунджаар 10.24 Mbps,



түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 71.17 Mbps, дунджаар 14.12 Mbps хүрсэн байна.

2.13. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн, шинээр болон эгүүлэн томилогдсон, шилжин ажилласан 7 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

2.14. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 152 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 150 бичиг ирсэн байна. 147 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 6 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 80 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 71, систем ашиглагдаггүй 8 байгууллагаруу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн зөрчилтэй 4 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 20 удаа танилцуулж ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Номын сангийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Шинэ уншигч	15,800	15,807	100%
2	Ирэгсэд	102,500	130,864	100%
3	Ном олголт	260,500	264,489	100%

Тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2

Он		2022			2023		
№	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	15,800	15,800	17,405	100%	15,800	14,379	92%
2	102,500	102,500	69,401	67,7%	102,500	159,000	100%
3	260,500	260,500	141,184	54,2%	260,500	278,000	100%

Тайлбар

Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд зарим албан хаагчид ажлаас чөлөөлөгдөх, шилжин ажиллах, жирэмсэний амралт авах зэрэгтэй холбогдуулан 4 удаагийн тооллого хийгдсэн.

3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Номын сангийн Kona программийг API (Application Programming Interface)-аар E-mongolia платформатай холбож уншигчийн бүртгэл, гэрээр ном олгох, ном бүрдүүлэх санал авах боломжуудыг API түвшинд холбон туршин ажиллууж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас төрийн үйлчилгээний нэгдсэн системд шинээр үйлчилгээ нэвтрүүлэх ажлыг түр хугацаанд түтгэлзүүлж байгаатай холбоотойгоор манай үйлчилгээг энэ онд нэвтрүүлэх ажил түр саатсан байна.

3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу байгууллагуудтай зөөврийн номын сангийн гэрээг байгуулан 128 удаагийн солилцоо болон зөөврийн үйлчилгээг 1038 нэрийн 2836 ширхэг номоор үзүүлсэн байна. Үүнд:

- Нийслэлийн Налайх дүүргийн Зэвсэгт хүчний 353 дугаар цэргийн анги
- Улсын 3 дугаар төв эмнэлэг
- Зэвсэгт Хүчний 089 дүгээр анги
- Нийслэлийн СХД дэх 27-р хорооны иргэд
- НЕБ-ийн 6-р сургуулийн 3а, 3б ангийн сурагчдад
- И-Монгол академид
- Нийслэлийн 66 цэцэрлэгийн хамт олонд
- ХӨСҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст
- Баянзүрх дүүргийн 301-р цэцэрлэгийн 56 багш, ажилтанд
- БГД-ийн НЕБ-ын 28 дугаар сургууль
- СХД-ийн 12-р хороо Нийслэлийн 105-р цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт



- СХД-ийн 30-р хороо Нийслэлийн 303-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлэгт
- СБД-ийн 1-р хороо Нийслэлийн 143-р цэцэрлэгийн дундын бүлгийн хүүхдүүдэд
- БГД-ийн НЕБ-ын 28 дугаар сургуульд
- Нийслэлийн 68-р цэцэрлэгийн бага, дунд, бүлгийн хүүхдүүдэд
- Хан-Уул дүүргийн 24-р хорооны ажилчдтай
- ЕБС “Томуо” ахлах сургуультай
- Хан-Уул дүүргийн Сэргээн засах клиник эмнэлэгтэй
- Зэвсэгт Хүчний 326-р дугаар цэргийн ангитай
- Улсын 2 дугаар эмнэлэгтэй
- Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалтай
- Шинэ-Өнөөдөр сургуулийн 10а ангийн 29-н сурагчдад
- “Ертөнц” дунд сургуулийн 9а ангийн сурагчдад
- Налайх дүүргийн зэвсэгт хүчний 353-р ангийн номын санч Сонинцэцэгтэй
- Төв салбарын А, Б, танхим, 4-р салбар номын сангуудаас солилцоогоор
- БЗД-ийн 147 дугаар сургуулийн 4д ангийн сурагчид
- БЗД-ийн 48 сургуулийн 3ж ангийн 43 сурагчид
- Зэвсэгт хүчний 303-р ангийн номын санд
- ХААН банкны дарь эх салбарын албан хаагч нарт
- Цус сэлбэх судлалын үндэсний төвийн албан хаагч нарт
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролтой
- Олон Улсын Эдийн Засаг Бизнесийн Их Сургуультай
- Чингис Соосэ их сургуультай
- СХД-ийн 13-р хорооны иргэдэдэд
- Зэвсэгт хүчний 017-р ангид
- НЕБ-ын лаборатори 151 дүгээр сургуультай
- СХД-ийн 105-р цэцэрлэгийн “Бэлтгэл-Б” бүлэгтэй
- СХД-ийн 13 хорооны оршин суугчдад
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролтой
- Нийслэлийн ерөнхий боловсролын 19-р сургуультай

Зөврийн номын сангийн үйлчилгээ



- Зэвсэгт хүчний 017-р ангитай
- Зэвсэгт хүчний 017-р ангид
- Агнистийн гэгээ ахмадын асрамжийн газарт
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролын төвтэй
- Сонгинохайрхан дүүргийн алслагдсан 25 дугаар хорооны 151 дүгээр сургуульд
- 5 дугаар сургуулийн 4г ангид
- Шинэ иргэншил МСҮТ
- СУИС–ын хөгжил үйлчилгээний төв Хүүхдийн уншлагын танхим, НЕБ-ын 5 дугаар сургуулийн номын сан, III-р салбар)-д
- СБДүүргийн 71 дүгээр сургуулийн номын сантай
- БГД-ийн 47 дугаар сургуулийн н.Даариймаа багштай 7г ангид
- “Фантастик Продакшин”-тай
- “Шинэ Иргэншил Дээд Сургууль”
- Нийслэлийн Баянгол дүүргийн 50 дугаар сургуулийн багш ажилчдад
- Төгс стандарт аудит ХХК-тай
- Олон улсын эдийн засаг бизнесийн их сургуультай
- Хан-Уул дүүргийн насан туршийн боловсролтой
- Салбар номын сангийн НУТ болон ХУТанхим хооронд
- ХУДүүрэг дэх салбар номын сангийн нийтийн уншлагын танхимтай
- Сонгинохайрхан дүүрэг салбар номын сангийн Хүүхдийн уншлагын танхимтай
- Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн нийтийн уншлагын танхимтай
- ЕБС-ын 5-р сургуулийн Б.Ариунцэцэг багштай 4в ангид солилцоо болон зөөврийн номын сангийн үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.



3.4. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар



2024 оны байдлаар E-PUB ном 20 ширхэг, 65 нэрийн 312 ширхэг 12,780,505 төгрөгийн номыг худалдаагаар, 387 Нэрийн 1084 ширхэг 14,974,498 төгрөгийн номыг



бэлэг хандиваар тус тус бүрдүүлэн авч, нийт 452 нэрийн 1399 ширхэг 27,755,003 төгрөгийн номоор бүрдүүлэлт хийсэн. Өмнөх оны тендерийн 149 нэрийн 788 ширхэг 18,987,341 төгрөгийн номыг оруулж нийт 2184 номонд техник ажиллагаа хийж, 611 нэрийн 2184 ширхэг номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2017 ш RFID баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Дээрх бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 10 нэр төрлийн 4,809,200 төгрөгийн тогтмол хэвлэл захиалга хийсэн.

Урагдаж гэмтсэн нийт 400 ширхэг ном хэвлэлийг сэлбэн зассан байна. Үүнд

- Чөлөөт сонголттой уншлагын А, Б танхимын 206 ширхэг ном
- Хүүхдийн уншлагын танхим 80 ширхэг ном
- Ном бүрдүүлэх, тусгай үйлчилгээний тасгийн 21 ширхэг ном
- Фонд 40 ширхэг
- СХД дэх салбар номын сангийн 40 ширхэг ном
- ХУД дэх салбар номын сангийн 55 ширхэг ном





Төв болон салбар номын сангуудын тогтмол

хэвлэлүүдийг нийт 55 нэгж, баримт 11 нэгж болгон тус тус хавтасласан байна. Үүнд:

- Төв 96 нэгж,
- ЧД дэх салбар номын сан 84 нэгж
- ХУД дэх салбар номын сан 83 нэгж,
- БЗД дэх салбар номын сан 72 нэгж
- СХД дэх салбар номын сан 73 нэгж

Ном зүйн мэдээлэл. UB Public Library - Хотын Төв Номын Сан пейж хуудсанд номын сангийн сан хөмрөгөө сурталчлах зорилготойгоор “Онцлох ном” Ном зүйн мэдээлэл бэлтгэн, номын жагсаалт / List / үүсгэн ажиллаж байна



3.5. Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааг амаар, цахимаар, утсаар, e mail-ээр нийт 4081 удаа лавлагаа өгсөн байна.



Ном зүй

Тайлант хугацаанд цахим санамж өгөх номзүйг 6 удаа нийт 379ш номоор гаргасан байна.

3.6. Мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөө

Номын сангийн нийт номын санчдад болон мэргэжил нэгт албан хаагчдад зориулж дараах мэргэжлийн сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Салбар номын сангийн ажилчдад ажлын байрны ганцаарчилсан сургалтыг зохион байгуулсан байна.
- Шинээр ажилд орсон номын санчдад зориулсан Коха програмын каталогжуулалтын сургалтыг өгч ажилласан байна.
- Налайх дүүргийн соёлын ордны номын санчид Коха програмд ном каталогжуулалтын анхан шатны сургалтыг өгч ажилласан байна.
- СУИС-ийн Соёлын сургуулийн эчнээ ангийн оюутнуудад үйлдвэрлэлийн дадлагыг хариуцан ажиллаж, номонд техник ажиллагаа, данс номын баркод, формулярын уутыг хэрхэн бичих номын нэг бүрчилсэн бүртгэл хөтлөх, ном ангилах, каталогжуулах, талаар тус тус сургалт өгсөн.



- “Номоо өөрсдөө сэлбэн засацгаая” сэдэвт ном сэлбэн засах анхан шатны сургалтыг Нийслэлийн ХУДүүргийн ЕБС-ийн 15 сургуулийн Гүнжид, Эрдэнэбилэг багштай 11б, 11в ангийн сурагчидад урагдаж гэмтсэн номоо сэлбэн засах арга зүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулсан.
- Хан-Уул дүүргийн номын сангийн номын санч Д.Алтанзагаст ном хэвлэл сэлбэн засах сургалт өгсөн.
- Хараагүй хүмүүст зориулсан тэмтэрч уншдаг цэгт товгор үсэгтэй “Брайл” бичгийн анхан шатны танилцуулах сургалтыг хийсэн. Брайл бичиг сурах товч гарын авлагыг боловсруулж тараасан.
- Номын санчдыг “Чадавхжуулах сургалт”-ыг Хэвлэлийн Хүрээлэн-тэй хамтран “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол” сэдвээр захиргааны гишүүд болон төв болон салбарын номын санчид (43 хүн) хамрагдсан сургалтыг амжилттай зохион байгуулсан.
- Байгалийн түүхийн музейн номын санчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.
- Говь Алтай аймгийн Алтай сумын соёлын төвийн номын санч нар номын сангийн үйл ажиллагаатай танилцан, сэлбэн засах арга ажиллагааны заавар, зөвлөгөө, арга зүйн сургалт хийсэн.
- “Туслагч технологийн сургалт”-ыг ганцаарчилсан хэлбэрээр 8 уншигчдад 6 удаа зохион явуулсан. Сургалтад 20 хүнийг хамруулж, орбит 40 брайл дэлгэц, NVDA дэлгэц уншигч программ, Jieshuo андройд дэлгэц уншигч программ, харааны бэрхшээлтэй хүнд зориулсан андройд таблет зэргийг танилцуулж, анхан шатны ойлголт өгсөн.



Номын танилцуулга мэдээлэл

Номын сангийн цахим хуудсанд уншигчид хэрэглэгчдэд цахим хэлбэрээр номын мэдээлэл, танилцуулгыг 36 удаа бэлтгэн хүргэсэн. Тухайлбал уншлагын танхимд шинээр ирсэн номын мэдээлэл болон инээдмийн өдөрт хошин шог зохиолоор, театрын өдөрт, олон улсын дуурын өдөрт, хүүхдийн зохиолчдын цуврал номоор болон монгол бичгээр хэвлэгдсэн ном зэрэг номын танилцуулгыг видео хэлбэрээр хийсэн.



Мөн хүүхдийн номоор цуврал үзэсгэлэн танилцуулга бэлтгэн хүүхэд багачуудад хүргэсэн.



3.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2024 оны байдлаар 1060 ирцэд 1420 ном олгож үйлчилснээс 360 номыг танхимаар, 650 номыг гэрээр, 381 номыг зөөврөөр, солилцоогоор 29 ширхэг номыг тус тус олгож үйлчилсэн байна.

Харааны бэрхшээлтэй 130 иргэдэд 139 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 42, утсаар 52, онлайнаар 11 удаа

Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “Ном сонсож сонсож хөгжье” фэйсбүүк группт 5 удаа танин мэдэхүйн мэдээлэл оруулсан.

Брайль болон дэйзи номын сэдэвчилсэн үзэсгэлэн нийт 4 удаа 38 ширхэг номоор:

- Хүүхдэд зориулсан номоор
- Ганс Христиан Андерсений уран бүтээл
- Товгор дүрст номоор





Хүртээмжит номын сангийн үйлчилгээ нээгдсэний 20 жилийн ойд зориулж Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, хүүхдийн Ж.Батноовтой, Сэтгэл зүйн ухааны магистрант Д.Цэцэнбилэгтэй “Амьдрах стратеги” сэдвээр уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд харааны бэрхшээлтэй 90 иргэн хамрагдлаа.

Харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудад зориулан танин мэдэхүйн АХА тэмцээн “НОМ” сэдэвтэй уралдааныг зохион явуулж нийт 112 уншигч хүүхэд залуучууд хамрагдлаа.

- Дэлхийн хүүхдийн номын өдөрт зориулж харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудад зориулан танин мэдэхүйн АХА тэмцээн “НОМ” сэдэвтэй уралдааныг зохион явуулж нийт 50 уншигч хүүхэд залуучууд хамрагдлаа. амжилттай зохион байгууллаа.
- Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар Хотын Нийтийн Төв Номын сангийн Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан "ХҮРТЭЭМЖИТ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЭЭГДСЭНИЙ 20 ЖИЛ"-ийн ойн хүрээнд Дэлхийн номын өдөр болон Үндэсний бичиг үсгийн өдрийг тохиолдуулан "НОМ ТААЦГААЯ" танин мэдэхүйн хөгжөөнт уралдаан, Монгол ёс заншлын "ДӨРВӨН БЭРХ" шагайн наадгай, Хотын соёлд иргэн бүрийн оролцоо-Идэвхтэй хөдөлгөөн өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

Харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Дэлхийн цагаан таягтны өдөрт зориулж ХХХСТ-тэй хамтарч ажилчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулсан.

Мөн харааны бэрхшээлтэй өндөр настангуудын дунд чанга уншлага зохион явуулсан.



Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 20 нэрийн цахим ном бүтээсэн.

Андройд үйлдлийн систем дээр ажилладаг монгол хэлээр ярьдаг Aim TTS аппыг үйлчилгээндээ нэвтрүүлсэн. Энэ апп нь дэлгэц дээр гарсан бичвэрийг монголоор ярих учир хараагүй хүн андройд төхөөрөмжийг ашиглаж чадна.

"Туслагч технологийн сургалт"-ыг ганцаарчилсан хэлбэрээр 8 уншигчдад 6 удаа зохион явуулсан. Сургалтад 20 хүнийг хамруулж, орбит 40 брайл дэлгэц, NVDA дэлгэц уншигч программ, Jieshuo андройд дэлгэц уншигч программ, харааны бэрхшээлтэй хүнд зориулсан андройд таблет зэргийг танилцуулж, анхан шатны ойлголт өгсөн.

Шинээр хийсэн ажил. "DW contacts" утасны аппликэйшнийг монгол хэл дээр орчуулж, нэвтрүүлсэн. Уг аппыг харааны бэрхшээлтэй хүмүүс ямар ч төрлийн андройд утсанд суулгаж, ашиглана. Үүнийг ашигласнаар хараагүй хүмүүс утсаар залгах, зурвас унших, дугаар хадгалах зэрэг дуудлагатай холбоотой бүх үйлдлүүдийг монгол хэлээр сонсож, хүссэн үйлдлээ хялбар хүртээмжтэй, эх хэлээрээ гүйцэтгэх боломжтой болж буй юм.

Үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, и-ном тоглуулагч, цахим брайль төхөөрөмж гэх техник хэрэгслүүдийн програм хангамжийн шинэчлэлт, сайжруулалтыг 8 удаа, мөн үйлчилгээнд ашиглагдаж буй техник хэрэгслүүдийн бүрэн ажиллагааг хариуцаж гарах 4 удаагийн засварыг тус тус хийж ажилласан байна.



Өдөр тутам хараагүй хүний ашигладаг цагаан таяг, ярьдаг даралтын аппарат, ярьдаг цаг, ярьдаг халуун хэмжигч, брайль бичгийн хэрэгсэл гэх мэт тусгай хэрэгсэл ашиглах тухай зөвлөмж тогтмол өгч нийт 60 харааны бэрхшээлтэй иргэнд 80 удаа амаар болон утсаар зөвлөмж өгч ажилласан.

Дэлхий даяар олон сая харааны бэрхшээлтэй иргэд хэрэглэдэг, шилдэг дэлгэц уншигч "Jieshuo" андройд аппыг монгол хэлээр орчуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ нь анхны монгол хэлтэй андройд дэлгэц уншигч апп болсон. Үүнээс өмнө зөвхөн англи хэлтэй дэлгэц уншигч апп байсан тул өндөр настай, англи хэлний мэдлэггүй бол хараагүй иргэд андройд төхөөрөмж ашиглах нь хязгаарлагдмал хүрээнд байсан. Ийнхүү орчуулснаар харааны бэрхшээлтэй иргэд андройд гар утас, таблет гэх мэт төхөөрөмжүүдийг "Aim TTS" ярьдаг апптай хослуулан эх хэлээрээ саадгүй ашиглах боломж бүрдсэн.

10.3. Jieshuo андройд дэлгэц уншигч апп



Андройд системийн хүртээмжийн стандартын шаардлага хангасан БИЧВЭР ЯРИХ АПП

"AIM" TTS

©2024

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж Андройд систем дээр АИМ МОНГОЛ ХЭЛНИЙ ЯРЬДАГ АППЫГ ЭНГИЙН ДЭЛГЭЦ УНШИГЧ АПП (JIESHUO)-ын хамт хэрэглээнд орууллаа.



ДЭЙЗИ технологийн дараагийн үе "Ц8" ярьдаг таблетыг номын сангийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн. Ингэснээрээ тусгай технологиор уншдаг байсан номыг андройд дэлгэц бүхий планшетаар унших боломжтой болсон.



Бэлэн мөнгө уншигч "CASH READER" аппликэйшныг монгол хэлээр орчуулж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Харааны бэрхшээлтэй иргэдэд өдөр тутмын тулгарч байдаг асуудал өдөр тутмын ажилд тохиолдож байдаг төлбөр тооцооны асуудал юм. Энэ аппликэйшн монгол хэлтэй болсноор Монгол төгрөгийн бүх дэвсгэртийг саадгүй таньж, монгол хэлээр хэлж төлбөр тооцооны асуудлыг харааны бэрхшээлтэй иргэн бие

даан шийдэх чадамжтай болж байгаа юм.

3.8. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

Тус номын санд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 32 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 150.000 төгрөг олгодог.

3.9. Зохион байгуулсан болон хамрагдсан сургалтууд

Тайлант хугацаанд номын сангийн хэмжээнд нийт номын санчид болон албан хаагчдийг чадавхжуулахаар дараах сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд нийт 13 удаагийн сургалтыг 80 албан хаагчдад орсон байна. Үүнд:

- “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол”-ыг олгох сургалт
- Хараагүй хүнд зориулсан тэмтэрч уншдаг товгор үсэгтэй “Брайль” бичгийн сургалт
- Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм журмын талаарх сургалт
- Худал мэдээлэл, түүнийг хэрхэн таних вэ?
- Сошиалд зориулсан сонирхолтой пост бэлтгэх боломжууд, өгөгдлийн дүрсжүүлэлт, инфографик.
- Аудио агуулга гэж юу вэ? Подкаст хэрхэн хийх вэ?
- Номын сангийн мэдээллийн боловсрол ба Номын санчийн манлайлал сургалт
- Орчин үеийн номын сангийн чиг хандлага "АНУ-ын номын сангуудтай танилцсан туршлага"
- Авлигатай тэмцэх газрын сургалт
- “Байгууллагын албан хаагчдад зориулан багаар ажиллах болон сэтгэл хөдлөлөө удирдаж сурах” сургалт
- “Хувийн өнгө тодорхойлох” сургалт ба Хувь хүний “Биеэ зөв авч явах соёлд суралцъя” сургалт
- “Үйлдвэрчний эвлэл”-ийн сургалт

- Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх сургалт сургалт



Мөн үүнээс гадна Нийслэл болон холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан дараах сургалтуудад хамаарал бүхий албан хаагчдыг хамруулсан байна.


Үүнд:

1. МУҮНС-гаас зохион явуулсан "Каталогч, ном зүйчдийн хэлэлцүүлэг" сургалт
2. EBSCO information services болон ШУТИС-номын сангийн хамтран зохион байгуулсан EBSCO – Номын сангийн програм хангамж, хиймэл оюун ухаан /AI/ сургалт.
3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол MIL сүлжээний гишүүдийн 2024 цахим ээлжит сургалт.
4. YOUTH MONGOLIA Залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар чуулган
5. МУ-ын соёлын биет бус өвийг хамгаалах, чадавхыг бэхжүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх 2 дах шатны сургалтан.
6. Монголын номын санч - мэдээллийн ажилтнуудын XI дэх “Mongolian library update” 2024 зөвлөгөөн.
7. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, Үр дүнд суурилсан төлөвлөлт гүйцэтгэл” сэдэвт сургалт
8. HR 2024 чуулган.
9. “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” сэдэвт сургалт.
10. Авлигатай тэмцэх газар ёс зүйн хороотой хамтран хийсэн Төрийн албан хаагчийн ёс зүй, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтад тус тус нийт 9 албан хаагч хамрагдсан байна.



3.10. Үйл ажиллагааны ил тод байдал

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **26** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

3.11. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан шинэчилсэн.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Дөрөв. БУСАД МЭДЭЭЛЭЛ

4.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Олон нийтэд үйлчлэх тасгийн хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн

дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Үүнд:

Д/д	Үйл ажиллагааны ерөнхий нэр	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Контент	80	71000
2	Уулзалт, лекц, ярилцлага	56	4780
3	Сургалт	7	2693
4	Номын өдөрлөг, номын нээлт	3	650
5	Номын сангийн зочны ярилцлага	50	5780
6	Номын үзэсгэлэн	80	6800
7	Уралдаан, тэмцээн	6	772
8	Чанга уншлага, Уншлагын цаг хөтөлбөр	58	12350
9	Үлгэрийн цаг хөтөлбөр	100	1565
10	Номын жим	143	4822
11	Америкийн соёл мэдээллийн төв	937	23377
	Нийт	1520	134589

Эдгээрээс тоймлон үзвэл:

Видео контент

Хадаг барих ёс, Дэлхийн усны өдөр, Эх орончдын өдөр, Битүүлэх ёсны талаар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн яруу найргийн өдөрт, Дэлхийн номын болон Зохиогчийн эрхийн өдөр, ЦЕГ-тай хамтран “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд, Шинэ жилийн тухай, үндсэн хуулийн өдөр, гэгээн хайрын өдөр зэрэг тэмдэглэлт баярууд болон бусад сэдвээр контент буюу богино хэмжээний видеог хийсэн.

Уулзалт, лекц, ярилцлага

- “Эх орончдын өдөр”-т зориулан Хүүхдийн амьдралын дасгалжуулагч Ж.Батболор багштай хамтран “өөрийн хүсэл тэмүүлээ тодорхойлох”





Стресс эм
хүний сэтгэгч-
мэдрэлийн
эрүүл мэнд



- “Дэлхийн яруу найргийн өдөр”-ийг тохиолдуулан МЗЭ-ийн шагналт зохиолч Ш.Солонготой
- Үе тэнгийн дээрэлхэлт ба цахим хэрэглээ уулзалт лекцийг СБД-ийн ХБГХХХ-ийн хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн Д.Болортунгалагтай
- "Гэгээн хайрын баяр"-ыг тохиолдуулан зохион байгуулсан "Хайр, хүндлэл, гэр бүл" сэдэвт уулзалт зочин болох Ж.Бэгзсүрэн болон түүний гэргийн хамт
- Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан “Уул, үүл” хуудасны админ, залуу уран бүтээлч жүжигчин Б.Уянгатай
- МУСГЗ, Д. Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч О.Сундуйтай
- Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсний 118 жилийн ойг тохиолдуулан Д.Нацагдоржийн шагналт, утга зохиол судлаач, хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D) дэд профессор Алтангэрэлийн Мөнх-Оргилтой “Д.Нацагдоржийн амьдрал, уран бүтээл” сэдвийн дор "ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ"-ыг зохион байгууллаа.



- “Нийслэл Улаанбаатар хотын үүсэл хөгжил” сэдэвт бяцхан ном бүтээх уралдааны үзэсгэлэн
- Уншигч-Зохиолчдын уулзалтын хүрээнд "Минималист" номын зохиолч, орчуулагч Эссо Хулан уригдан “Энгийн амьдрах дадлын” талаар

Сургалт

Англи хэлний багш нарт зориулсан заах арга зүй, Game on И Спорт, Англи хэл дээрх код бичих, Лего болон инженерчлэл хосолсон “In the driver’s seat”, Монголын сайн дурынхны төвтэй хамтран зохион байгуулсан сайн дурын ажил хэрхэн хийх, түүний ашиг тус юу байх талаарх сургалтуудыг зохион байгуулсан.



Номын өдөрлөг, номын нээлт

Номын өдөрлөгийг нийт 3 удаа 650 хүүхэд хамруулсан байна.

- Зохиолч Хишигнямын Дуламсүрэнгийн “Улаан даашинзтай бүсгүй” номын нээлт
- Хэл бичгийн ухааны доктор, зохиолч, яруу найрагч, судлаач Пүрэвхүүгийн Батхуягийн 50 насны ойд зориулсан “Залбирал” уран зураг, яруу найрагчдын гар бичмэлийн үзэсгэлэн, шинэ номын нээлт
- Берлиний Хумболтын Их сургуулийн “Монгол судлал”-ын салбарын эрхлэгч, доктор Алтангэрэлийн Ганчимэгийн “Classical Mongolian: A Textbook for Students, Scholars, and Everyone Interested in Mongolian” номын нээлт тус тус зохион байгуулсан байна.

Зочны ярилцлага

Номын сангийн зочны ярилцлага буланг 79 удаа явуулж байгууллагын вэб хаягаар дамжуулан 5800 иргэдэд цахимаар хүргэсэн байна.

- ЭША Р.Отгонбаатар
- Жүжигчин Д.Баттогтох
- МЗЭ-ийн шагналт зохиолч С.Пүрэвсүрэн
- Хэлбичгийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Цэзэн



- “Болор цом”-ын эзэн Нацагдорж шагналтан яруу найрагч Д.Галсансүх
- Зохиолч, контент бүтээгч Энхбатын Дөлгөөн
- Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн ахлагч Д.Мөнхбаяр
- Жүжигчин, уртын дуучин Д.Ганцэцэг
- Жүжигчин Лхагвабаярын Жинжжалам
- Монгол Улсын Соёлын гавьяат Зүтгэлтэн номын санч, Ном зүйч О.Цацрал
- Зохиолч Хишигнямын Дуламсүрэн
- МЗЭ-ийн шагналт зохиолч М.Наранболд
- МЗЭ-ийн шагналт зохиолч Г.Болормаа
- МЗЭ-ийн шагналт зохиолч Ш.Солонго
- МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Ж.Нарана
- Зохиолч нийтлэлч Ж.Нарана
- МУГЖ А.Цэгмид
- Зураач Б.Гэрэлцэцэг
- Зохиолч Б.Эрхэмбаяр
- Хүүхдийн номын орчуулагч Э.Мөнхбилэг
- Хүүхдийн зохиолч, редактор, үлгэрч багш Арцбазарын Даваасүрэн
- Сэтгүүлч Г.Тэгшжаргал
- Сэтгүүлч, улс төрч Гантөмөрийн Уянга
- МҮОНРТ-ийн нэвтрүүлэгч, дуу оруулагч Ө.Наранбаатар
- ХБУ-ны доктор Ч.Заяасүрэн
- Төрийн Соёрхолт соёлын гавьяат зүтгэлтэн С.Оюун нар оролцсон.





Номын үзэсгэлэн танилцуулга

Тайлант хугацаанд номын сэдэвчилсэн үзэсгэлэнг нийт 44 удаа 44 нэрийн 285 ширхэг боть номоор гаргасан бол гинэ номын үзэсгэлэнг нийт 38 удаа 38 нэрийн 527 ширхэг боть номоор тус тус гаргасан байна.

- Олон улсын Эмэгтэйчүүдийн баярт зориулж нийт 28ш ном
- Зохиолч Х.Дуламсүрэнгийн зохиолуудын үзэсгэлэн нийт 9ш номоор (байгууллагад 6ш ном хандивласан)
- Монгол цэргийн өдөрт
- Эх түүхээрээ бахархъя
